



ШИХИХУТУГ

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ МЭДЭЭЛЭЛ





МӨРДӨХ ЧИГ ҮҮРГИЙН АГУУЛГЫГ ШИНЭЭР АВЧ ҮЗЭХ НЬ



Профессор Ж.Бямбаа

Эрүүгийн процесс ажиллагааны чиг үүрэг нь тухайн ерөнхий харилцаа эрх зүйн ямар бүлд хамаарахыг тодорхойлохын зэрэгцээ зорилттойгоо ямагт уялдаж байдаг. Гарсан гэмт хэрэг бүрийг бүрэн илрүүлэх, өдүүлсэн этгээдийг нь илчлэн гэм буруутай эсэхийг тогтоох, улмаар шүүхээр хэлэлцүүлж эрүүгийн хариуцлага оноох эсэхийг шийдвэрлэх нь ямар ч нийгэмд эрүүгийн процесс ажиллагааны үндсэн зорилт болж байдаг учраас чухамдаа чиг үүргүүд (функци) түүнд л бүрнээ үйлчлэх учиртай.

Эрүүгийн процессын чиг үүргийн талаар ОХУ-ын эрдэмтэн Лупинская А.П., АНУ-ын судлаач Брадлей. М., ХБНГУ-ын профессор Б.Шюнемани болон доктор Д.Баярсайхан¹ нар ном, бүтээлдээ нэлээд тодорхой тусгажээ.

Тэд уг ойлголтыг 4-22 янзаар ангилж системчлэн авч үзсэн. Ингэхдээ ямар ч тохиолдолд процесс ажиллагааны яллах, өмгөөлөх, шүүн шийдвэрлэх чиг үүргүүдийг бусдынхаа **суурь тулгуур нь** гэж үзжээ. 70-80-аад оноос Ром-Германы эрх зүйн бүлд мөрдөх, мөрдөн мөшгөх гэсэн бие даасан ойлголтууд процессын бүхий л хэлбэрүүдэд гарч ирсэн нь **"инквизици"**-ийн гэгдэх төрийн эрх бүхий субъектүүд эрхлэн явуулдаг ажиллагаа **"акусаци"** буюу мэтгэлцүүлэн шийдвэрлэх зарим хувилбарт байраа тавьж өгөх болсон нь **"холимог"** нэрт шинэ хэлбэр баттай бүрдсэний илрэл биз.

Ялангуяа эрүүгийн **мөрдөн мөшгөх** онцлог ажиллагаа нь яллах, өмгөөлөх, шүүн шийдвэрлэх гол тулгуур чиг үүргүүдийн

¹ Эрх зүй сэтгүүл. 2010 он. УБ., №1. Проф. Б.Шюнеманий тавьсан илтгэлээс. Уголовно-процессуальное право, под.ред. Лупинской М. 2008 г. Стр 74-78; Criminal procedure a worldwide study, Second edition ... M. Bradley. Carlina press. 2004. P. 37-43. Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. Ер. Анги. УБ., 2014 он. 66-68 дахь тал.



эхлэл үндсийг тавигч хэмээн нэрлэгдэж улам бүр шийдвэрлэх ач холбогдолтой болсоор байна.

Ер нь эрүүгийн процессын чиг үүргүүд, түүний дотор "мөрдөх" нь нотлох баримт бүрийг бодит шинжээр нь илрүүлэхийг зорилгоо болгосоор ирсэн. Тиймээс ч (аливаа баримт, мэдээллийг тухайн хэргийн бодит байдлыг тогтоох зорилгын үүднээс) яллаж зэмлэхээс гадна өмгөөлөн хамгаалах процесс ажиллагаа мөрдөн мөшгөлтийн үед явагдсаар байдаг нь эргэлзээгүй үнэн.

Мөрдөн мөшгөх гэсэн субстанцын утга учрыг ойлгож мэдэх, онол, арга зүйн үндсийг баттай тогтоох нь процессын шинжлэх ухааны бие даасан цоо шинэ чиглэлд зүй ёсоор тооцогдох болов.

Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олсон **мөрдөн мөшгөлт** гэдэг ойлголт мөрдөн шалгах, эрүүгийн эрэн сурвалжлах ажлын хослол шинжийг өөртөө агуулдаг бөгөөд зорилго нь гэмт хэрэг бүрийг илрүүлэх, өдүүлсэн этгээдийг илчлэн, түүний гэм буруутай эсэхийг тогтоож, улмаар хөндлөнгийн, хараат бус шударга шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлэн өгөхөд чиглэгддэг юм. Тийм учраас мөрдөлт, байцаалт хоёрын салгаж болдоггүйтэй нэгэн адил мөрдөн шалгах, эрүүгийн эрэн сурвалжлах ажлыг (үйл ажиллагааны хувьд ч, удирдлага зохион байгуулалтын үүднээс) бие биеэс нь салангид авч үзэх боломжгүй.

Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2-т Цагдаагийн байгууллага хуулиар өөрт нь харъяалуулсан гэмт хэргийг далд аргаар үйлдсэн буюу үйлдэхээр бэлтгэж байгаа тухай хуулийн үндэслэл бүхий мэдээллийг ердийн арга, хэрэгслээр шалгах боломжгүй /11.2.1/, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг өөр арга, хэрэгслээр олж тогтоох боломжгүй /11.2.2/, энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1.5-д алдагдсан нууц бичиг баримт, эд зүйл, галт хэрэгсэл, зэвсэг, тэсрэх болон хүчтэй хордуулах, цацраг идэвхит, мансууруулах бодис, түүх соёлын дурсгалт зүйл, нуугдмал эд хөрөнгийг эрж олох /11.2.5/... зэрэг тодорхой үндэслэлийн аль нэг нь байвал, мөн энэ хуулийн 11-р зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,3,4,5,6-д заасан үндэслэлээр Тагнуулын байгууллага эрэн сурвалжлах чиглэлээр гүйцэтгэх ажил явуулах эрхийг тус тус эдэлж ирсэн.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба мөнхүү хуулийн 9 дүгээр зүйлийн 1.4-д заасан хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаалах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх үүднээс, Хилийн тагнуулын алба хуулиар харъяалуулсан эрүүгийн хэрэгт мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,3,5,6-д заасан үндэслэлээр, Авилгатай тэмцэх



газар ЭХХШ хуулиар харъяалуулсан хэрэгт дээр дурдсан хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,3,5,6-д заасан үндэслэлээр эрэн сурвалжлах гүйцэтгэх ажил тус тус явуулах эрхтэй гэж заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, "тагнуулын" "гүйцэтгэх", "эрэн сурвалжлах" зэрэг өөр өөрөөр нэрлэгдсэн, зорилго, агуулга нэгтэй дээрх ажиллагаануудыг ноцтой гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг илрүүлж, таслан зогсоох, зайлшгүй шаардлагатай мэдээллийг олж тогтоох, түүнийг зохих журмын дагуу бэхжүүлэхийн тулд явуулна. Улс төр, эрх мэдэлт олигархи бүлэглэлийн ивээлд багтан эрүүгийн хариуцлагаас зайлсхийхийг оролдсон бүлэг этгээдүүдийн хэд хэдэн ноцтой хэргийг шалгахдаа гүйцэтгэх ажлын мэдээ мэдээллийг үндэслэн прокурорын хяналтын дор эрэн сурвалжлах ажиллагаа явуулж хангалттай баримт бүрдүүлж чадсан олон тодорхой жишээ бий. Тэрхүү жишиг туршлага манайд цаашдаа ч хэрэг болох биз. Нэгэн ноцтой хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдэхдээ "... Нууц, далд аргаар илрүүлэх олж тогтоох чиглэлээр төрийн тусгай албадын хүчийг дайчилж ашигласан"², тэр нь "шүүхийн эцсийн шийдвэр гаргахад үнэмшихүйц үндэслэл болсон" гэж тусгайлан дурдсан байдаг.

Эрэн сурвалжлах чиглэлээр

ил, далд аргаар явагддаг энэхүү ажиллагаанууд нь гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд, ихэнх тохиолдолд прокурорын хяналтын дор хэрэгждэг боловч тэнд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, зөрчих эрсдэл ихтэй, бас нийгэм, олон нийтийн хараа хяналтанд төдийлөн өртдөггүй, тэгээд ч эрүүгийн процессын, ялангуяа өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэх боломж, нөхцөл тун хязгаарлагдмал гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Ер нь, эрүүгийн мөрдөн мөшгөх ажиллагаанд одоо ч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт чиглүүлэх үүрэг гүйцэтгэж таарна. Гэмт хэргийн нөхцөл байдлыг тогтоож, хэрэгт ач холбогдол бүхий баримт, сэлт, мэдээллийг цуглуулахын тулд мөрдөгчөөс явуулж буй **мөрдөн шалгах** (үндсэн) болон **бусад ажиллагаа**г ерөнхийд нь "шүүхийн өмнөх" хэмээн нэрлэдэг³.

Мөрдөн шалгалт нь ЭБШ ажиллагааны зарчмуудыг ямар ч алагчлалгүйгээр чандлан баримтлахыг гол зорилго болгоно. Тийм хэрэгцээ, шаардлага хэрэг дээрээ зөвхөн шүүхийн өмнөх шатанд л сүрхий ажиглагддаг.

ЭХХШ-т.Хуулийн 1.7 дугаар зүйлийн дагуу "хар цагаан" баримтын аль алиных нь хойноос мөрдөгч элдэв алагчлалгүй уйгагүй хөөцөлдөх шаардлагатайг харуулж байна.

² Е.Сарсай. ГЕГ бол МАХН-ын саалийн үнээ биш. Зууны мэдээ., 2006.06.06, №24 болон Н.Энхбаяр нарын хэргийн талаар 2014 онд Үндэсний шуудан сонины №54,56 дугаарт өгсөн ярилцлагууд.

³ Уголовный процесс. Коллектив авторов. М. 2015 с.26-32

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЙЛБАР ҮРГЭЛЖЛЭЛ...



А.Доржготов

*Шихихутуг ИС-ийн Иргэн, бизнесийн эрх
зүйн тэнхимийн эрхлэгч*

ХОЁРДУГААР БҮЛЭГ

**Компани, түүний эрх зүйн
байдал**

**2 дугаар зүйл. Компани, түүний
хэлбэр**

2.1 Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.

2.2 Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд харин компанийн эд

хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

2.3 Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоох бөгөөд хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.

2.4 Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна.

2.5 Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ.

2.6 Хувьцаат компани нь "нээлттэй болон хаалттай" гэсэн төрөлтэй байна.

2.7 "Нээлттэй хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ.

2.8 "Хаалттай хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан



хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ.

2.9 Хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь тусгай зориулалтын компани хэлбэртэй байна. Уг хэлбэрийн компанийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон харилцааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар зохицуулах бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн зохицуулалт хамаарахгүй.

/Энэ хэсгийг 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуулиар нэмсэн/

1. Хуулийн этгээд: Монгол улсын иргэний эрх зүйд хуулийн этгээд гэсэн ойлголт байдаг. Хуулийн этгээд гэдэг бол хөрөнгө төвлөрүүлэх, аж үйлдвэрийг хөгжүүлэх явцад бий болсон хийсвэр ойлголт¹ гэж үзэх нь бий. Монгол улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлд хуулийн этгээдийн үндсэн шинжийг тодорхойлсон байдаг. Өмчлөлдөө бүх эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч хариуцагч байж чадах,

тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

Хуулийн этгээд нь ашгийн төлөө, ашгийн төлөө бус гэсэн хоёр үндсэн төрөлтэй байж болно. Хуулийн этгээд нийтийн, хувийн, холимог өмчийн байж болох тухай заасан байна. Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны² хэлбэрээр байгуулна.

Компани бол хуулийн этгээдийн эдгээр шинжүүдийг бүрэн агуулсан байдаг. Иргэний хуульд компаний тухай тодорхойлохдоо³: “хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ” гэжээ. Компанийн тухай хуулийн 3.1-д: Компанийг тодорхойлохдоо түүний үндсэн шинжийг илэрхийлж байна.

- Компани бол хуулийн этгээд мөн.
- Үндсэн зорилго нь ашгийн төлөө байдаг.
- Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг.
- Компани өөрийн тусгайлсан эд

² Хоршооны тухай Монгол улсын хуульд /3.1/“... хамтран байгуулсан хуулийн этгээд” гэж, Хадгаламж зээлийн хоршооны тухай хуульд 3.1-д “ашгийн төлөө бус хуулийн этгээд” гэж тус тус тодорхойлжээ.

³ Иргэний хуулийн 33 дугаар зүйл.

¹ Монгол улсын иргэний хуулийн тайлбар / ерөнхий анги/ УБ хот 2005 он



хөрөнгөтэй байх.

2. Компаний хувьцаа өмчлөлд оролцох эрхийг нотолно. Энгийн ойлголтоор бол хувьцаа гэдэг бол компанийг өмчлөх эрх үүсгэж буйг илтгэдэг гэж хэлж болно. Хувьцааг худалдан авсан цагаас эхлэн тухайн компанийг эзэмшиж байгаа хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, явуулж байгаа бизнес хувьцаа эзэмшигчид хамаатай болно. Нийт хувьцааны хэдэн хувийг худалдан авсан, тоон утгаараа тэр хувийн хамаарал бий болно. Эзэмшиж байгаа хувьцааны хувиас хамаарч хувьцаа эзэмшигчийн эрх мэдэл өөр өөр байдлаар тодорхойлогдоно. Хуулийн 3.2 заалтад хувьцаа нь хөрөнгийг өмчлөхөд оролцох эрхийг нотлох талаар заасан байна. Энд дараах хоёр үндсэн ойлголтыг тодорхойлно.

а) Хувьцаа нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн оролцох эрхийг нотлоно. Энэ ойлголтын талаар дээр товчлон, энгийн байдлаар дурьдсан болно. Ер нь хувьцаа эзэмшигчийн эрхийн талаар “үнэт цаасны зах зээлийн тухай хууль, компанийн тухай хуульд” тодорхой заасан байдаг. Түүнчлэн компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчийн зарим эрхийг тогтоож болдог. Хувьцаа эзэмшигчийн эрх гэсэн ойлголтын хүрээнд авч үзвэл:

- “Хувьцаа эзэмшигч нь бусдын саналыг харгалзахгүйгээр өөрийн хувьцааг захиран зарцуулах эрхтэй”. Үүнээс гадна түүний эдэлбэл зохих үндсэн

эрх гэж бий. Үүнд:

- Санал өгөх эрх. 1) энгийн хувьцаа бүр саналын нэг эрхтэй, 2) саналын эрхийн олонхоор асуудлыг шийддэг, 3) ээлжит болон ээлжит бус хуралд оролцох эрхтэй, 4) давуу эрхийн хувьцааны саналын эрх хязгаарлагдмал байдаг.
- Ногдол ашиг авах эрх. 1) хувьцааны өгөөж болох ногдол ашиг авах эрх, 2) давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг түрүүлж хуваарилах /эхний ээлжинд ашиг хүртэх эрх/, 3) компанийг татан буулгасны дараа зохих журмын дагуу хувь хүртэх эрхтэй, 4) давуу эрхийн хувьцаа, дараа нь энгийн хувьцаанд хуваарилах зарчим хэрэгждэг.
- Хувьцаа эзэмшигчийн бусад эрх. 1) компаний талаар мэдээлэл авах эрх, 2) хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх, 3) хувьцааг компанидаа эргүүлэн худалдах эрх, 4) гомдол гаргах, улмаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зэргийг энд хамруулан ерөнхий томъёолсон гэж тайлбарлаж болно. Эдгээр эрхийг хувьцаа нотолно. Энэ эрхүүдээр Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцоно.
- б)** Дээр дурьдсан эрхүүд нь компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй. Хувьцаа эзэмшигч компанийн эд хөрөнгийг шууд захиран зарцуулах эрхийг хувьцаа нотлохгүй. Тийм эрхийг



хувьцаа эзэмшигч оролцох, хэрэгжүүлэх боломжгүй юм. Тиймээс ч хуулийн 3.3-д заахдаа дараах эрхийг тодорхойлжээ.

3. Хувьцаа эзэмшигч: Хуульд дараах байдлаар тодорхойлсон. "Компанийн давуу эрхийн болон энгийн хувьцаа эзэмшиж буй этгээдийг хувьцаа эзэмшигч" гэнэ. Үүнийг энгийн үгээр тайлбарлавал аль нэг хувьцаат компанийн тодорхой хувийг эзэмшиж байгааг гэрчилсэн үнэт цаас буюу хувьцааг эзэмшиж байгаагаа илэрхийлсэн ойлголт юм. Хувьцаа эзэмшигчийн эрхийг Компанийн хууль, Компанийн дүрмээр тогтоох тухай хуульд заасан байна. Энд үндсэн эрхийг заан томъёолжээ.



Эндээс харахад "хувьцаа эзэмшигчийн үндсэн эрхэд" хуулиар тодорхойлсон эрхийг хамааруулан томъёолсон гэж үзэж болно.

Хуулийн 3.4, 3.5-д компанийн хэлбэр, түүний үндсэн шинжийг тодорхойлжээ. Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат компани гэсэн хоёр хэлбэртэй. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг үндсэн шинжийг томъёолохдоо:

а) хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдана.

б) хувьцааг захиран зарцуулах эрх нь хууль, компанийн дүрмээр хязгаарлагдана.

Хуульд "түүнийг" гэсэн үгээр захиран зарцуулах эрхийг томъёолсон нь ойлгомжгүй болсон байна. Тэгэхээр энд **"оруулсан хөрөнгө"**, эсхүл **"хувьцаа"**-г захиран зарцуулах эрхийг заасан уу, аль алинд нь хамааралтай юу? Тэгэхлээр **"түүнийг"** гэдгийг хувьцаа гэж эрх зүйн талаас нь ойлгох хэрэгтэй гэж үзнэ. Энэ нь хуулийн этгээдийн хөрөнгө, компанийн өөрийн хөрөнгө гэдэг ойлголттой холбоотойгоор тайлбарлагдах асуудал юм. Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө бол компанийн өөрийн хөрөнгөд бүрэн шилжих бөгөөд түүний хувь хэмжээ бол өмчлөлд оролцох эрхийг нотлох үндэслэл болно. Харин компанийн эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхэд хамаардаг зүйл гэж хуулийн 3.3-3.8-д хувьцаат компанийн төрлийг тодорхойлон нээлттэй хувьцаат компани, хаалттай хувьцаат компани гэж хоёр төрөлд ангилан заасан.

Нээлттэй хувьцаат компани, түүний үндсэн шинж нь:

- Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдана.
- Хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэнэ.
- Нийтэд чөлөөтэй арилжаалагдана. Нээлттэй



хувьцаат компани нь зөвхөн хэдхэн хүний өмчлөлд бус харин олон нийтийн өмчлөлд байдаг. Нээлттэй хувьцаат компанийн ихэнх өмчлөгчид нь хөрөнгө оруулалт хийсэн эгэл жирийн хүмүүс байдаг. Нээлттэй хувьцаат компани нь тухайн компанийн хувьцааг худалдан авах санхүүгийн боломжтой бүхий л хүнд нээлттэй. Энэ онцлог байдал нь зөвхөн нэг гэр бүлийн эсвэл цөөхөн хэдэн хүмүүс хувьцааг нь эзэмшиж байдаг хувийн компаниас ялгарна. Нээлттэй хувьцаат компани нь хувьцаагаа нийтэд гаргана. Хөрөнгийн биржээр хувьцаагаа арилжаална. Ямар ч хүн уг хувьцааг худалдан авах, зарах боломжтой байдаг.

- Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагдана.

Хувьцаат компанийг хаалтгайд тооцох үндэслэл нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байх, гаргасан хувьцаа нь нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэгдээгүй байх явдал юм. Хаалттай хувьцаат компани компанийн төрлөө өөрчлөх, нээлттэй болох зорилгоор нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлснээс бусад тохиолдолд өөрийн хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон төдийгүй хөрвөх үнэт цаасыг нийтэд

санал болгохыг хориглодог.

Хувьцаа нь зөвхөн хаалттай хүрээнд арилжаалагдана. Хаалттай хүрээ гэдэгт үнэт цаасаа аливаа мэдээллийн хэрэгслийг ашиглан зарлаж сурталчлахгүйгээр худалдагч, худалдан авагч талуудын тохиролцсон гэрээний үндсэн дээр үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур худалдахыг ойлгоно.⁴

Тусгай зориулалтын компани. Хуулийн 3.9-т зааснаар хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байна. Тусгай зориулалтын хэлбэрийн компанийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой харилцааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар зохицуулдаг. Хуульд өөрөөр заагаагүй бол компанийн тухай хуулиар зохицуулахгүй. Хөрөнгө оруулалтын сангын ойлголтыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар тодорхойлдог.

Хөрөнгө оруулалтын сан нь хуулийн этгээдийн эрхтэй тусгай зориулалтын компани байх бөгөөд "Хөрөнгө оруулалтын сан нь түүний гишүүн хуулийн этгээдийн өмчлөлд дэх сангийн нэгж эрхийн хувь, хэмжээнээс үл хамаарч тухайн гишүүн хуулийн этгээдээс хараат бус байх бөгөөд Компанийн тухай хуульд заасан охин болон хараат компани, толгой компанийн хоорондын эрх, үүрэг, хариуцлага хүлээхгүй" гэдгийг хөрөнгө оруулалтын сангийн тухай

⁴ Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 280 дугаар тогтоолоор "Хаалттай хувьцаат компанийн тухай журам" батлан гаргажээ.



хуулийн 7 дугаар зүйлд тодорхойлон заасан байна.

4 дүгээр зүйл. Хувьцаат компани

4.1 Хуульд өөрөөр заагаагүй бол хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.

4.2 Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээдэд бүртгүүлэх үүрэгтэй.

4.3 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно.

4.4 Нээлттэй хувьцаат компанийн хаалттай захиалгын үндсэн дээр нэмж гаргасан хувьцааг худалдан авагч нь түүнийг чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.

4.5 Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчид тохиролцсоны үндсэн дээр хувьцаагаа захиран зарцуулах эрхээ харилцан хязгаарласан гэрээ байгуулж болно.

1. Хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх Компанийн хувьцаа

эзэмшигч бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүй өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй байдаг. Ийнхүү чөлөөтэй захиран зарцуулах эрх бол хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нарт хамаатай юм. Захиран зарцуулах эрх бол хувьцаа өмчлөгчийн хүсэл зоригийн дагуу тухайн хувьцааг хууль зүйн хувьд эцэслэн шийдвэрлэх үйл ажиллагаа бөгөөд өмчлөх эрхийн гол элемент юм. Хувьцаа эзэмшигч хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрхийг хуулиар хязгаарлах, эрх зүйн байдлыг өөрөөр тогтоосон байж болно.

2. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа захиран зарцуулахдаа гол төлөв үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалддаг. Хэрэв хувьцаагаа бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээд бүртгүүлэх үүрэгтэй. Энэ нь хувьцааг шилжүүлэн авсан этгээдийн эдлэх эрхийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болно. Жишээ нь: хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч өөрийн хүүдээ хувьцаагаа бэлэглэж болно. Түүнчлэн хувьцаагаа бусад өр төлбөрт шилжүүлэн өгсөн гэх мэт тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээдэд бүртгүүлнэ.

3. Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа нээлттэй байх ёстой гэсэн ойлголт байдаг. Хуульд компани нээлттэй, эсхүл хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа, бусад үнэт цаас гаргаж болох тухай заасан байна.



Харин компанийн дүрэмд өөрөөр зааж болно. Тэгэхлээр компани хувьцаа гаргах, үнэт цаас гаргах асуудлыг дүрэмд нарийвчлан тодорхойлох ёстой.

4. Дээр нээлттэй хувьцаат компани хаалттай захиалгын үндсэн дээр нэмж хувьцаа гаргадаг тохиолдолд хувьцааг худалдан авсан этгээдийн захиран зарцуулах эрхийг тодорхойлсон байна. Хэдийгээр хаалттай захиалгын үндсэн дээр компанийн нэмж гаргасан хувьцааг худалдан авсан бол тэдгээр хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх зүйн байдал нь хуулийн 4.1 дэх заалтын зохицуулалттай адил байх учиртай гэж үзнэ.

5. Эрх хязгаарласан гэрээ: Хувьцаа эзэмшигчийн чөлөөтэй захиран зарцуулах эрхийг гэрээ байгуулах замаар хязгаарлах арга байдаг. Тухайлбал: хувьцаа эзэмшигчийн харилцан тохиролцооны үндсэн дээр хувьцаагаа захиран зарцуулах эрх, үүргийг гэрээнд зааж тодорхойлох замаар зохицуулж болно гэсэн үг. Энэ гэрээ хувьцаа эзэмшигчдийг хувьцаагаа захиран зарцуулах эрхийг харилцан хязгаарлана. Гэрээгээр тохиролцсон, гэрээ байгуулахад оролцож, түүнийг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигч гэрээнд оролцож, түүнийг зөвшөөрөн хувьцаа эзэмшигч гэрээнд заасан хязгаарлалт, үүргийг биелүүлэх үүрэгтэй. Жишээ нь: гэрээгээр хувьцаагаа зөвхөн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдаалахаас бусад хэлбэрээр бусдад шилжүүлэхгүй

байхаар тохиролцож болно. Мөн аль ч хэлбэрээр арилжсан, бусдад шилжүүлсэн байлаа ч хувьцаа эзэмшигч бусад этгээдэд урьдчилан мэдэгдэх ёстой гэх мэт байж болох юм.

5 дугаар зүйл.Хязгаарлагдмал хариуцлагатай компани

5.1 Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн байгуулах үеийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-аас дээшгүй байна.

5.2 Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргах бөгөөд бусад үнэт цаасыг нээлттэй болон хаалттай аль ч хэлбэрээр гаргаж болно.

5.3 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн болон бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг гуравдагч этгээдэд санал болгох үнээр өөрийн эзэмшлийн хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн энэ хууль болон компанийн дүрэмд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.

5.4 Хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигч нь уг саналаа компанид мэдэгдэх бөгөөд энэ тухай компани нь



бусад хувьцаа эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.

5.5 Энэ хуулийн 5.4-т заасан мэдэгдэлд худалдах хувьцааны төрөл, тоо, худалдах үнэ, тэргүүн ээлжид худалдан авч болох хувьцааны тоо, худалдан авах хугацаа, журмыг тодорхойлсон байна.

5.6 Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах хувьцаа эзэмшигч нь энэ шийдвэрээ тогтоосон хугацааны дотор бичгээр компанид мэдэгдэнэ.

5.7 Энэ хуулийн 5.6-д заасан мэдэгдэлд хувьцаа худалдан авагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, худалдан авах хувьцааны тоо зэргийг зааж, төлбөр хийсэн баримтыг хавсаргасан байна.

5.8 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн хувьцааг энэ хуулийн 5.3-т заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхээ бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хэрэгжүүлэх, эсхүл энэ эрхээ бүхэлд нь буюу зарим хэсгийг нь бусад хувьцаа эзэмшигчид шилжүүлэх эрхтэй.

5.9 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5.3-т заасан эрхийг хувьцаа эзэмшигч тогтоосон хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй тохиолдолд уг эрх компанид шилжих бөгөөд компани нь энэхүү эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай шийдвэрээ энэ хуулийн 5.4-

т заасан мэдэгдэлд заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор гаргана.

5.10 Энэ хуулийн 5.3, 5.9-д заасан этгээд тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 5.4-т заасан мэдэгдэлд зааснаас багагүй үнээр гуравдагч этгээдэд худалдах эрхтэй.

5.11 Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах эрхтэй.


1. Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаат компаниас ялгагдах онцлогтой. Тэдгээрийн тусгайлсан нэрийн хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/, хувьцаат компани /ХК/ гэсэн товчлолоор компанийн хэлбэрийг тодотгодог. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн тоог компанийн дүрмээр хязгаарлахгүй. Тэгвэл хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үүсгэн байгуулагчдын тоо 50-аас дээшгүй байдаг. Энэ хязгаарлалт нь компани байгуулагдсаны дараа хувьцаа эзэмшигчдийн тоог 50-аас доош байхаар зохицуулсан гэж үзэх боломжгүй юм. Тухайлбал хувьцаа эзэмшигчдэд хамааралгүй юм.

2. Хязгаарлагдмал хариуцлагатай компани нийтэд санал болгосон үнэт цаас гаргахгүй. Компанийн хувьцааг



худалдан авах, эрхийн бичиг, хувьцаа болон эрхийн бичгийн хөрвөх үнэт цаас гаргаж болно. Эдгээрийг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргана.

Хялбаршуулсан байдлаар үзүүлбэл:



3. Тэргүүн ээлжинд худалдан авах Энэ бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хуулийн зохицуулалтын нэг юм. Хуульд зааснаар энэ давуу эрхээр худалдан авахад дараах зүйлүүдэд хамааралтай. Үүнд:

- Компанийн хувьцаа
- Тус компанийн хувьцаа эзэмшиж байгаа бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа
- Хувьцаа худалдан авах эрхийн бичиг
- Хувьцаа болон хувьцаа худалдан авах эрхийн бичигт хөрвөх үнэт цаас эдгээр болно.

Хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаа эзэмшигч нь гуравдагч этгээдэд санал болгох үнээр тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй байна. Тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх нь тухайн хувьцаа эзэмшигчийн өөрийнх нь эзэмшлийн хувьцааны тоогоор хязгаарлагдаж байдаг.

Тухайлбал тэрээр өөрийн эзэмшлийн тоонд хувь тэнцүүлэн худалдан авах эрхтэй гэсэн үг. Энэ эрхээ хэрэгжүүлэх үндэслэл нь Компанийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан тус компанийн дүрмийн заалт болдог.

Компанийн дүрэмд өөрөөр зааж зохицуулж болохыг хуульд "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол" хэмээн томъёолсон байна. Гэвч энэхүү зохицуулалт нь компанийн гишүүдийн хүсэл зоригт үндэслэсэн, хуульд нийцсэн шударга ёсны хэм хэмжээг зөрчсөн байж болохгүй. Энэ нь компанийн гишүүн бүр анхаарвал зохих асуудлын нэг мөн.

4. Компанид мэдэгдэх үүрэг: Хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдахаар бол энэ тухай саналаа компанидаа мэдэгдэх үүрэгтэй. Компанид гэдэг ойлголт ТУЗ, гүйцэтгэх удирдлагад хамааралтай. Санал гэдэгт худалдах хувьцааны тоо хэмжээ, түүний үнэ, худалдах хугацаа зэрэг багтана. Харин компани нь хувьцаа худалдах санал гарсан тухай нийт хувьцаа эзэмшигчдэд бичгээр мэдэгдэх ёстой. Компанийн энэ мэдэгдэл бол хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд хувьцаа худалдаж авах эрхээ хэрэгжүүлэх гол нөхцлийг бүрдүүлнэ.

5. Мэдэгдэл: Компани нь хувьцаа эзэмшигч хувьцаагаа худалдах санал ирүүлсэн тухай мэдэгдэл гаргахдаа хуульд заасан дараах зүйлүүдийг тусгаж, бичгийн хэлбэрээр илэрхийлсэн байх учиртай. Үүнд:

- Худалдах хувьцааны төрөл



- Худалдах хувьцааны тоо
- Хувьцаагаа худалдах үнэ
- Тэргүүн ээлжинд худалдан авч болох хувьцааны тоо / Энэ нь гишүүн нэг бүрээр тодорхойлогдох ёстой болно. Эзэмшиж байгаа хувьцааны тоо адил биш бол/
- Хувьцаагаа худалдан авах хугацаа
- Худалдан авах журмыг тус тус уг мэдэгдэлд заасан байна.

Уг мэдэгдэл нь тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхтэй хувьцаа эзэмшигч нэг бүрд хүргэгдэнэ. Энэ мэдэгдлийг хүлээн авсан хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд мөн компанид бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэх асуудал нь компанийн мэдэгдэл заасан хугацаанд, түүнд заасан журмын дагуу үйлдсэн байх ёстойг хуулийн 5.6-д заасны дагуу компанид хүргүүлэх хувьцаа эзэмшигчийн мэдэгдэлийн бүрдүүлбэрийг хуулийн 5.7-д заажээ. Энэ мэдэгдэлд: Хувьцаа худалдан авах хувьцаа эзэмшигчийн эцэг, эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, худалдан авах хувьцааны тоог тодорхой бичнэ. Түүнчлэн хувьцаа худалдан авах талаар хийсэн баримтыг хавсаргана. Энэ шаардлагыг хангаагүй мэдэгдэл бол хувьцаа эзэмшигчийн тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болно.

6. Эрх шилжүүлэх: Хуулийн 5.8-

д зааснаар тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ бусад хувьцаа эзэмшигчид шилжүүлэх эрхтэй байна. Харин компанийн дүрэмд өөрөөр заах, тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах, бусад хувьцаа эзэмшигчид шилжүүлэх асуудлыг журамлан, нарийвчилсан зохицуулалт хийсэн байж болно. Дүрэмд өөрөөр заасан тохиолдолд хувьцаа эзэмшигчид дүрмийнхээ заалтыг хэрэгжүүлэх хэрэгтэй болно.

Хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хэрэгжүүлэх эрх зөвхөн хувьцаа эзэмшигчид байдаг. Тэрээр энэхүү эрхээ бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг бусад хувьцаа эзэмшигчид шилжүүлэх эрхтэй болохыг хуульд заажээ. Жишээ: А,Б нар компанийн 10,10 хувийг эзэмшигчид. Тэд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхтэй. Гэвч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ Ц-д шилжүүлэх тухай мэдэгдэв. Ийнхүү хувьцаа эзэмшигчид эрхээ шилжүүлэхээр заах эрх зүйн боломжтой юу?

Хуулийн 5.3-д <өөрийн эзэмшлийн хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн> худалдан авах эрхтэй байдаг. Тэгэхлээр Ц 1+2 боломж эдлэх болно. Бусад хувьцаа эзэмшигч нараас давуу эрх эдлэх боломжгүй байх ёстой. Энэ хязгаарлалт бол хувьцаа эзэмшигчдийн эрх тэгш байх зарчим хангадаг. Энэ мэт тохиолдолд тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхийг хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг компанийн дүрэмд нарийвчлан заах нь маргаан гарах үндэслэл нөхцлийг



урьдчилан зохицуулдаг. Тэгэхлээр дүрэм, түүний заалт бүр чухал ач холбогдолтой байдаг.

7. Тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрхээ бусад хувьцаа эзэмшигчид шилжүүлэх эрх нь уг эрх компанид шилжих асуудал нь хоорондоо ялгаатай ойлголт гэж үзнэ. Учир нь хуулийн 5.8, 5.9-д заалтуудын зохицуулалтын хуулиас ялгаатай болох нь харагдана.

Тэргүүн ээлжинд хувьцаа эзэмших эрхээ бүрэн буюу хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлээгүй, түүнчлэн энэ эрхээ бусад хувьцаа эзэмшигчид шилжүүлэх тухай мэдэгдээгүй тохиолдолд хуулийн 5.9 дэх заалтын зохицуулалт хэрэглэгдэнэ. Хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг тогтсон хугацаанд /компанийн мэдэгдэлд заасан/ бүрэн хэрэгжүүлээгүй тохиолдолд уг эрх компанид шилжинэ. Компани нь дараах эрхийг хэрэгжүүлэх тухай шийдвэрээ гаргана. Компани шийдвэрээ компанийн мэдэгдэлд /5.4/ заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор гаргах ёстой. Компанийн шийдвэр гаргах хугацаа бол хувьцаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчид болон компаниас бусад этгээд буюу гуравдагч этгээдэд хувьцаагаа худалдах эрхтэй холбоотой юм. Ажлын таван өдрийн дотор шийдвэр гараагүй бол тус компани тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэглээгүй гэж үзнэ. Тэгэхлээр хувьцаа эзэмшигчид мөн компани

тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хувьцаа худалдахаар санал болгож буй этгээд гуравдагч этгээдэд хувьцаагаа худалдах эрхтэй. Гэхдээ энэ эрх нь үнийн хувьд хязгаартай. Тухайлбал компани, тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй хувьцаа эзэмшигчид санал болгосон, компанийн мэдэгдэлд заасан үнээс багагүй үнээр гуравдагч этгээдэд худалдана. Тухайлбал: мэдэгдэлд заагдсан үнээс хямдаар худалдах эрхгүй гэсэн үг. Энэ нь "Компани, түүний хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол"-ыг хамгаалсан зохицуулалт юм. Хямдаар гуравдагч этгээдэд худалдсан тохиолдолд маргаан гарвал хэлцэл хүчин төгөлдөр бус болох нөхцөл бий болж болно.

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч мэдээлэл авах, бичиг баримттай танилцах эрхтэй байдаг. Энэ эрхэд:



Энэ эрх бол компани болон түүний удирдлагын үйл ажиллагаанд хөрөнгө оруулагчийн зүгээс тавих хяналтын нэгэн хэлбэр гэж ойлгож болно.



6 дугаар зүйл. Хараат болон охин компани, компанийн нэгдэл

6.1 Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ.

6.2 Хараат компани нь бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна.

6.3 Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ.

6.4 Охин компани нь санхүүгийн тайлангаа тусдаа гаргах ба толгой компани нь охин компанитайгаа нэгдсэн санхүүгийн тайлан гаргана.

6.5 Хараат болон охин компани нь толгой компанийнхаа өрийг хариуцахгүй бөгөөд хууль болон тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол толгой компани нь хараат болон охин компанийнхаа өрийг хариуцахгүй.

6.6 Толгой компанийн гаргасан шийдвэрийн улмаас охин компани төлбөрийн чадваргүй болсон бол толгой компани нь тухайн өрийг хамтран хариуцна.

6.7 Охин компанийн хүлээсэн алдагдал нь толгой компанийн гаргасан шийдвэрээс шалтгаалсан гэж үзвэл охин компанийн хувьцаа эзэмшигч алдагдлын улмаас охин компанид учирсан хохирлыг толгой

компаниар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

6.8 Толгой компани нь гуравдагч компанийн хараат болон охин компани бол түүний хараат болон охин компани нь гуравдагч компанийн хувьд мөн хараат болон охин компани болох бөгөөд энэ зарчмыг үүнээс ч илүү үргэлжилсэн хэлхээ холбоонд ашиглан хамаарлыг тогтооно.

6.9 Хараат болон охин компани нь толгой компанийн хувьцааг эзэмшиж болно.

6.10 Энэ хуулийн 6.9-д заасны дагуу охин компанийн эзэмшиж байгаа толгой компанийн хувьцаа нь саналын эрхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг тооцохдоо охин компанийн эзэмшиж байгаа хувьцааг хасч тооцно.

6.11 Энэ хуулийн 6.9-д заасны дагуу эзэмшиж байгаа хувьцааг гуравдагч этгээдэд шилжүүлсэн тохиолдолд уг этгээдэд хувьцаа эзэмшигчийн бүх эрх шилжинэ.

6.12 Толгой компани нь үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд хараат болон охин компанийн үйл ажиллагаанд зөвхөн эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээр оролцоно.

6.13 Төр болон бусад хуулийн этгээд аливаа компанид хөрөнгө оруулсныхаа төлөө эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээ хэрэгжүүлэхдээ дүрэмдээ заасан эрх бүхий этгээдээс томилсон төлөөлөгчөөр дамжуулан төлөөллөө хэрэгжүүлэх бөгөөд



энэхүү төлөөлөгч нь уг төлөөллийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль болон тухайн компанийн дүрэмд заасан эрх бүхий этгээдээс өгсөн удирдамжийг үндэслэх ба энэхүү удирдамжаас өөрөөр санал гаргасан нь түүнийг энэхүү төлөөллийг хэрэгжүүлэх эрхээс чөлөөлөх үндэслэл болно.

6.14 Толгой компани, түүнтэй энэ хуулийн 6.1, 6.3, 6.8-д заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл гэнэ.


6.15 Нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани гэнэ.

6.16 Компанийн нэгдэлд хамаарагдаж байгаа компани нь толгой компани, эсхүл хараат болон охин компани, зэргэлдээ компани аль нь болохоос үл хамааран түүнийг нэгдлийн оролцогч компани гэнэ.


Хуулийн 6 дугаар зүйлд хараат болон охин компани, компанийн нэгдэл, тэдгээрийн үндсэн шинж, эрх зүйн хувьд харилцан нөлөөлөл зэргийг заан тодорхойлжээ. Энэ зүйлийг тайлбарлахад хараат компани, охин компани, толгой компанийн тус тусын үндсэн шинж, харилцан хүлээх үүрэг, улмаар хариуцлага хүлээх ерөнхий үндэслэл, охин компанийн хувьцаа

эзэмшигч шүүхэд нэхэмжлэл гаргах эрх, толгой компанийн хувьцаа эзэмшсэн тохиолдолд саналын эрхийг хэрхэн тодорхойлдог, хувьцаа эзэмшигчийн эрх шилжих, компанийн хамаарлыг тогтоох хийгээд гуравдагч компани, компанийн нэгдэл, түүнд оролцогч компанийн эрх зүйн байдлыг тус тусад нь тодорхойлох шаардлагатай гэж үзэв.

1. Хараат компани:



2. Охин компани:





3. Толгой компани



4. Шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д зааснаар бол охин компанийн хувьцаа эзэмшигч шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна. Нэхэмжлэл гаргах үндэслэл нь:

- Охин компани алдагдал хүлээсэн байх
- Уг алдагдал толгой компанийн шийдвэрээс шалтгаалсан байх
- Алдагдлын улмаас охин компанид хохирол учирсан байх

Охин компанийн хувьцаа эзэмшигч нь толгой компанийн шийдвэрээс шалтгаалан өөрийн хувьцаа эзэмшдэг. Охин компани алдагдал бий болсон гэж үзвэл тус компанид учирсан хохиролыг толгой компаниар төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна.

Тэгэхлээр энд анхаарвал зохих асуудал бол охин компанид алдагдал бий болсон, хохирол

учирсан, эдгээр нь толгой компанийн шийдвэрээс шалтгаалсан байдал заавал бодитойгоор бий болсон, тэр нь тогтоогдсон эсэхийг хуулийн энэ зохицуулалтад заагаагүй байна. Иймээс хуулийн заалт ёсоор бол охин компанийн хувьцаа эзэмшигч, охин компанийн хүлээсэн алдагдал, толгой компанийн шийдвэрээс шалтгаалсан гэж үзсэн л бол охин компанид учирсан хохиролыг толгой компаниар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Охин компанийн хувьцаа эзэмшигч толгой компанийн шийдвэрийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд шүүх нэхэмжлэлийг хүлээн авч, хэрэг үүсгэж хянан шийдвэрлэнэ.

Харин шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд⁵ заасан журмын дагуу толгой компанийн ажил хэргээ байнга явуулдаг эсхүл удирдах байгууллага⁶ нь байгаа газрын шүүхэд гаргасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангасан байхыг шаардана.

Компанийн тухай хууль /6.12/-д толгой компани үйл ажиллагаа явуулах зорилгоор байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд хараат болон охин компанийн үйл ажиллагаанд шууд оролцохгүй талаар зохицуулжээ. Хараат болон охин компанийн үйл ажиллагаанд зөвхөн эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээр оролцох гэдэг нь

⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.1.1, 14 дүгээр зүйл 61-73 дугаар зүйлээс үзнэ үү.

⁶ Иргэний хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д хуулийн этгээдийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг түүний оршин байгаа газар гэнэ.



шийдвэрлэх зэрэгт ихээхэн ач холбогдолтой байж болох юм.

Компани хоорондын хамаарлыг тогтооход толгой компани нь гуравдагч компанийн хараат болон охин компани байж болно. Энэ тохиололд уг толгой компанийн хараат болон охин компаниуд гуравдагч компанийн хараат болон охин компани болно. Энэ хамаарал үргэлжилсэн хэлхээ холбоонд байж болно.



Зүүлт: Ийм байдлаар үргэлжилсэн хамаарал бүхий компанитай харилцах эдийн засаг, эрх зүйн асуудалд болгоомжтой хандах, хамаарлыг зөв тогтоосны үндсэн дээр гэрээ хэлцэл байгуулах нь зүйтэй байдаг.

6. Гүравдагч компани.

Компаниудын хамаарлыг тогтооход гуравдагч компанийн тухай ойлголт бас чухал хуульд гуравдагч компани, толгой компани, хараат, охин компанийн харилцан хамаарлын талаар тодорхойлсон гэж үзэж болно. Толгой компани өөрөө гуравдагч компанийн хараат, охин компани байх юм бол түүний хараат, охин



компани мөн гуравдагч компанийн хараат, охин компани байх зарчмыг илэрхийлж байна /6.8/. Эрх зүйн байдлын хувьд энэ зарчмаар гуравдагч компани компанийн хамаарлыг буй болгох замаар үргэлжилсэн хэлхээ холбоог бий болгосон байж болно. Компанийн хамаарал, гуравдагч компанийн тухай эрх зүйн ойлголтыг хувьцааны хяналтын багц, түүнийг эзэмших явдалтай холбоотойгоор авч үзэх хэрэгтэй.

7. Хараат болон охин компани нь толгой компанийнхаа хувьцааг эзэмшиж болно. Толгой компанийнхаа хувьцааг эзэмшиж байгаагаас шалтгаалан бий болох дараах ойлголтуудыг Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10, 6.11-д заан зохицуулсан байдаг. Үүнд:

Толгой компанийн хувьцаа саналын эрх зүй. Охин компанийн эзэмшиж байгаа толгой компанийн хувьцаа саналын эрхгүй. Тэгэхлээр хараат компани толгой компанийнхаа хувьцааг эзэмшиж байгаа бол саналын эрхтэй гэсэн агуулга илэрхийлэгдэнэ. Охин компанийн эзэмшиж байгаа хувьцаа саналын эрхгүй тул хувьцаа эзэмшигчийн хурлын ирцийг тооцоход нөлөөлнө. Хурлын ирц бол хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр хүчин төгөлдөр болоход нэн чухал. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцэд охин компанийн эзэмшиж байгаа хувьцаа орохгүй. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцээс "охин компанийн эзэмшиж байгаа хувьцааг хасч тооцно" гэж зохицуулжээ. Харин хараат компанийн эзэмшиж

байгаа толгой компанийн хувьцаа саналын эрхтэй болохоор хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг тооцохдоо оруулах, /"хараат компанийн эзэмшиж байгаа хувьцаа" гэдэг үндэслэлээр хасч тооцохгүй байх/-аар заасан гэж үзэж болно.

Хувьцаа эзэмшигчийн эрх шилжих. Хараат болон охин компани нь толгой компанийнхаа хувьцааг эзэмшиж байгаа тохиолдолд хуулиар тогтоосон журам, арга хэлбэрт нийцүүлэн бусдад шилжүүлж болно. Ийнхүү эзэмшиж байгаа хувьцааг гуравдагч этгээдэд шилжүүлсэн тохиолдолд хувьцааг шилжүүлэн авсан этгээдэд хувьцаа эзэмшигчийн бүх эрх шилжинэ. Хуулийн энэ зохицуулалттай холбоотойгоор хуульд хэрэглээний талаас дараах зүйлд анхаарах хэрэгтэй.


- Хараат болон охин компани гуравдагч этгээдэд толгой компанийн эзэмшиж байгаа хувьцаагаа шилжүүлэхдээ хуулиар тогтоосон журам арга, хэлбэрт нийцүүлэх шаардлагатай болно. Тухайлбал: Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, хуульд нийцсэн компанийн дүрэмд тодорхойлсон хязгаарлалт, хориглосон заалтыг зөрчихгүйгээр гуравдагч этгээдэд хувьцаагаа шилжүүлэх эрхтэй.

- Хараат болон охин компани нь толгой компанийн хувьцааг эзэмшиж байгаад гуравдагч этгээдэд шилжүүлсэн тохиолдолд хувьцааг шилжүүлэн авсан этгээдэд "хувьцаа эзэмшигчийн эрх шилжинэ". Энэхүү



"бүх эрх" гэсэн ойлголтыг Компанийн тухай хуульд /34/ заасан хувьцаа эзэмшигчийн эрхийн хүрээнд ойлгож хэрэглэх нь зүйтэй гэж үзнэ.

8. Компанийн нэгдэл
Компаниудын нэгдэл, түүний эрх зүйн ерөнхий ойлголтыг хуулийн 6.13-д тодорхойлжээ.



Хуульд зааснаар бол компанийн нэгдэл гэх ойлголтыг тодорхойлоход **"нэг этгээд"**-ийн эрх зүйн төлөөлөлд үндэслэж байна. Энэ ойлголт толгой компани, хараат компани, охин компани, гуравдагч компанитай холбоотойгоор бий болох эрх зүйн зохицуулалт юм.

9. Эдгээр "хамаарал" бүхий компаниудын хувьцааных нь багцыг нэг этгээд эзэмшдэг, эсхүл нэг этгээд нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг улмаар компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл хэмээн томъёолон нэрлэж байна.

Компани нэгдлийг бий болгох аргын хувьд: а) нэг этгээд хувьцааны багцыг дангаараа эзэмших, б) нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран

хувьцааны багцыг эзэмших замаар компанийн нэгдэл бий болно.

Компанийн нэгдлийн хамгийн чухал үзүүлэлт бол удирдлагын шийдвэрийг тодорхойлох, хийгээд нэгдэлд оролцогч компанийн удирдлагын шийдвэрт нөлөөлөх эрх зүйн боломж юм. Эрх зүйн ийм боломжийг олж авах үндсэн асуудал бол компанийн хувьцааны хяналтын багцыг эзэмших явдал байдаг.

10. Компанийн удирдлага гэх ойлголтыг Компанийн тухай хуулийн есдүгээр бүлэгт зохицуулсан хүрээнд ойлгогдож байна. Компанийн удирдлага гэдгийг хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багт хамааруулан ойлгож тэдгээрээс гаргах шийдвэрийг тодорхойлох боломжийн хүрээнд компаниудын нэгдэл гэх ойлголтыг тодорхойлно.

11. Хяналтын багц Энэ ойлголт бол компанийн гаргасан энгийн хувьцаанд хамааралтай байдаг. Тухайлбал: Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд "Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг, түүнээс дээш хэмжээний хувьцаагаар хяналтын багцыг тодорхойлно.

12. Зэргэлдээ компани
Компанийн нэгдэлтэй холбоотойгоор зэргэлдээ компани гэсэн ойлголтыг Компанийн тухай хуульд заасан байдаг. Зэргэлдээ компани бол нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудад хамааралтай.



Ойлголтыг хялбаршуулан үзүүлбэл:



13. Нэгдэлд оролцогч компани.

Компанийн тухай хууль /6.15/-д энэ тухай заажээ. Компанийн нэгдэлд хамаарагдаж байгаа бүх компаниудыг компанийн нэгдэлд оролцогч компани хэмээн хуульд томъёолон заажээ. Оролцогч компани гэдэгт толгой компани, хараат компани, охин компани, зэргэлдээ компаниуд бүгд хамаатай бөгөөд аль нь ч байлаа гэсэн тэдгээрийг компанийн нэгдэлд оролцогч гэж үзнэ. Компанийн эдгээр ангилалд хуваан нэрлэсэн явдал нь тэдгээрийн харилцан хамаарал, эрх зүйн харилцааны нөлөөлөл, тэдгээрийн эдийн засаг-эрх зүйн харилцаанд хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзэж болно. Эдгээрээс гадна компани нь салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно.

7 дугаар зүйл. Компанийн салбар, төлөөлөгчийн газар

7.1 Компанийн салбар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно.

7.2 Компанийн төлөөлөгчийн газар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

7.3 Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно.

7.4 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргана.

7.5 Гадаад улсын хуулийн этгээдийн Монгол Улсад оршин байгаа салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

7.6 Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсад компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг тухайн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.7 Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд түүнийг байгуулсан компаниас баталсан журмын дагуу үйл



ажиллагаагаа эрхлэн явуулна.

7.8 Компанийн салбар, төлөөлөгчийн газрын эд хөрөнгийг түүнийг байгуулсан компанийн балансад тусгана.

7.9 Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан компанийн нэрийн өмнөөс явуулна.

7.10 Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанаас үүсэх үр дагаврыг хариуцна.

7.11 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ томилох бөгөөд тэдгээр нь компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

Тайлбар: Компанийн салбар, төлөөлөгчийн газар бол тухайн компанийн үндсэн чиг, үүргийг гүйцэтгэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлцэл хийх зэргээр эрх зүйн харилцаанд оролцдог компанийн нэгж байдаг. Эдгээр салбар, төлөөлөгчийн газар бол иргэний эрх зүйн хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын үндсэн шинжийг илэрхийлнэ.

Компани хуулийн этгээд мөн. Компани өөрийн дүрмээр тодорхойлсон зорилгоо хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн харилцаанд байнга оролцоно. Үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэн явуулна. Гэрээ, хэлцэл байгуулах гэх мэт иргэний эрх зүйн хуулийн этгээдийн шинжийг бүрэн оруулсан эрх зүйн чадвар бүхий байх ёстой⁷. Үүнээс уламжлан компани бол хуулийн этгээдийн шинжийг бүрэн хангасан байдаг. Иргэний хуулийн 25 дугаар зүйлд зааснаар компани өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, түүнийг эзэмших, ашиглах, дүрэмдээ заасны дагуу захиран зарцуулах эрхтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болсон үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг. Нэхэмжлэгч, хариуцагч байж чадах тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг, хуульд заасны дагуу зохион байгуулагдсан байхыг шаарддаг.

⁷ Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар. Иргэний хуулийн 26 дугаар зүйлд тодорхойлон зохицуулсан.



Иргэний хууль (29.1)-д “хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт заасан бол хуулийн этгээд өөрийн салбар төлөөлөгчийн газраа тогтоосон журмын дагуу байгуулж болно” гэж заасан байдаг. Иргэний эрх зүй дэх хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар гэсэн ойлголтыг дараах байдлаар хялбаршуулан оруулбал:



Эдгээр нь компанийн салбар, төлөөлөгчийн газрын эрх зүйн үндсэн шинж байдал, тэдгээрийн байгуулагдах, үйл ажиллагаагаа явуулах нийтлэг зарчмыг тодорхойлдог. Үүнээс улбаалан Компанийн тухай хууль, тухайн компанийн дүрэмд компанийн салбар төлөөлөгчийн газар байгуулан ажиллуулах, үйл ажиллагаагаа эрхлэн явуулах талаар тодруулан зааж журамлан зохицуулдаг байна.

Компанийн салбар. Компанийн

тухай хууль (7.1)-д компанийн салбар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж байх тухай компанийн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг гүйцэтгэж болох тухай, тус тус заажээ. Түүнчлэн компанийн салбар нь төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болохоор заажээ.

Компанийн төлөөлөгчийн газар. Компанийн тухай хуулийн (7.2)-д компани төлөөлөгчийн газар байгуулж болно. Компанийн төлөөлөгчийн газар нь тухайн компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж байх, мөн тухайн компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалдаг, компанийхаа нэрийн өмнөөс хэлцэл хийдэг гэх мэтээр эрх зүйн төлөөлөлийн үйл ажиллагаа явуулах үүргийг эрхлэн гүйцэтгэнэ гэжээ.

Хуулийн эдгээр зохицуулалтаас харахад “Компанийн оршин байгаа газар”, “эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа” гэсэн ойлголтуудыг анхаарах хэрэгтэй болно.

Компанийн оршин байгаа газар нь тухайн компанийн ерөнхий захиргаа байршин байгаа газрыг хамааруулан ойлгох бөгөөд түүний оршин байгаа газар гэнэ. Компани оршин байх нэг газартай, тухайн газартаа хууль ёсны хаягтай байдаг. Хуульд заасны дагуу оршин байгаа газраа бүртгүүлнэ. Энэ нь компанийн үйл ажиллагаагаа явуулах газраас өөр ойлголт болно.

Компанийн төлөөлөгчийн газар эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна гэх ойлголтод тухайн



төлөөлөгчийн газар байрлаж байгаа газар, орон нутаг, гадаад улсад компанийнхаа хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлцэл хийх, компаниас олгосон итгэмжлэлд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлэх зэргийг хамааруулан ойлгоно⁸.

Компани Монгол улсад, түүнчлэн гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно. Гадаад улсын хуулийн этгээд (компани) Монгол улсад салбар, төлөөлөгчийн газар байгуулж болох бөгөөд ийнхүү гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар байгуулагдсан тохиолдолд тус улсын бүртгэх байгууллагад салбар, төлөөлөгчийн газраа бүртгүүлэх журамтай.

Харин Монгол улсын компани гадаадад салбар, төлөөлөгчийн газар байгуулахад эрх зүйн дараах зохицуулалтанд үндэслэнэ. Үүнд:


а) Монгол улсын олон улсын гэрээнд заасан журмыг удирдлага болгох,

б) Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх болно.

Компани салбар, төлөөлөгчдийн

⁸ Компанийн эрх зүйн төлөөлөлийн үйл ажиллагааг ерөнхийд нь а) компанийн хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах, б) компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, в) төлөөлөлийн бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэсэн хэлбэрт ангилан судалж болно. Энэ тухай "хувьцаа эзэмшигчдийн эрх (гарын авлага) УБ 2014 он Зохиогч А.Доржготов, Б.Амарсанаа, Л.Ганзориг Х-12-13 талд үзнэ үү.

газар байгуулах шийдвэр гаргахдаа дараах үндэслэлд тулгуурлана.



Удирдлагыг томилох⁹. Хуульд (7.11)-д компанийн салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг томилох журмыг тодорхойлсон. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг томилно. Тухайн компани ТУЗ байхгүй бол удирдлагыг гүйцэтгэх удирдлага томилно. Компанийн дүрэмд салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг томилох талаар өөрөөр зааж болохоор тогтоосон. Тухайлбал: салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг зөвхөн ТУЗ томилох, эс бөгөөс хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилох гэх мэтээр заан тогтоосон байж болох юм.

Компанийн салбар, төлөөлөгчийн газар үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан компаниас баталсан журмын дагуу эрхлэн явуулна. Тэдгээр нь үйл ажиллагаанд Монгол улсын хууль тогтоомж, гадаад оронд байгуулагдсан бол тухайн орныхоо хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулах, сахин

⁹ Иргэний хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5-д "салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчид" хэмээн томъёолжээ.



биелүүлэх ёстой.

Салбар, төлөөлөгчийн газрын нийтлэг шинжүүдийг дурдан нэрлэвэл:

- Хуулийн этгээдийн эрх эдлэхгүй
- Эд хөрөнгө, тэдгээрийн талаар эрх эдлэхгүй
- Эд хөрөнгө нь тэдгээрийг байгуулсан компанийн тайлан тэнцэлд тусгагдана.
- Үйл ажиллагаагаа байгуулсан компанийн нэрийн өмнөөс явуулна.
- Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанаас үүсэх үр дагаварыг хариуцна.
- Салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг компаниас томилно. Энд ТУЗ, хэрэв байхгүй бол гүйцэтгэх удирдлага томилно. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар компанийн дүрэмд тодорхойлон заах ёстой.
- Салбар, төлөөлөгчдийн газрын удирдлага байгуулсан компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр ажиллаж, түүнд олгосон итгэмжлэлд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулна.

Жишээ нь: МИАТ компани, банк, төмөр зам, даатгалын компаниуд орон нутагт болон гадаад улс оронд салбар, төлөөлөгчийн газар байгуулах замаар тухайн орон, газар нутагтай үйл ажиллагаагаа эрхлэн хэрэгжүүлэх нь нийтлэг байдаг. Эдгээр компанийн байгуулсан салбар, төлөөлөгчийн газар нь иргэний эрх зүйн харилцаанд оролцож, гэрээ хэлцэл байгуулах,

байгуулсан гэрээ хэлцэлтэй холбоотой эрх зүйн маргаанд оролцох, шүүх, арбитраж нэхэмжлэгч, хариуцагчаар компаниа төлөөлөн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог. Компаниас олгосон итгэмжлэлд үндэслэн салбар, төлөөлөгчийн газрын удирдлагад олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд оролцож, тайлбар тодорхойлолт гаргах, мэтгэлцэх эрхтэй байна. Тухайлбал: банкны салбар зээл, тооцооны үүрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, мөн хөдөлмөрийн эрх зүйн маргаанд ажил олгогчийн хувьд оролцоно гэх мэт.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА БА ПРОКУРОРЫН ХЯНАЛТ



Т.Сүхбаатар

*Шихихутуг ИС-ийн Эрүүгийн эрх зүйн
тэнхимийн багш*

Монгол Улсын Их Хурал 2017 оны 5 дугаар сарын 18-нд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлан гаргасан нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокуророос тавих хяналтын эрх зүйн үндсийг шинээр тодорхойлсон явдал юм.

Гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хувь хүн, хуулийн этгээдийг олж тогтоон, шударгаар ял оногдуулах, гэм буруугүй нэг ч хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж тооцохгүй байх, хүний эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн

эрхийг сэргээхэд прокурорын байгууллагын үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлд: **" Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа** гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг" ойлгоно гэж заасан.

Прокурор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд оролцож байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч гол субъект болохыг харуулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа 24 төрлийн эрхийг хэрэгжүүлж ажиллахаар заасан хэдий ч чухамдаа 43 төрлийн эрхийг хэрэгжүүлж ажиллахаар болж байгаа бөгөөд шинээр зарим эрхүүд нэмэгдсэн байна. Тухайлбал:

ЭХХШТ.Хуульд зааснаар прокурор, гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах талаар гарсан санал хүсэлтийг шийдвэрлэх



/4.1 дүгээр зүйлийн 2.4/, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах /4.1 дүгээр зүйлийн 2.5/, хэрэг бүртгэлтийн хэрэг хаах/ 4.1 дүгээр зүйлийн 2.6/, эрүүгийн хэрэг нээж, яллагдагчаар татахаас татгалзах /4.1 дүгээр зүйлийн 2.6/, мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхийг мөрдөгчид олгох /4.1 дүгээр зүйлийн 2.10/, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцыг хянах /4.1 дүгээр зүйлийн 2.18/, хууль зөрчиж оролцогчид хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах /4.1 дүгээр зүйлийн 2.23/ зэрэг эрхийг шинээр хэрэгжүүлж ажиллахаар болж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.2 дугаар зүйлд “Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан энэ хуулийг хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, хууль зөрчсөн шийдвэрийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй болгож, хариуцлага тооцуулна. Прокурор нь шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шүүхийн өмнө нотлох үүрэг хүлээнэ.” гэж прокурорын үүргийг хуульчилж заасан нь чухал ач холбогдолтой.


Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг чухал хэсэг болсон мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөлтэй явуулах мөрдөн шалгах ажиллагаа /ЭХХШТ.Хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх заалт/ мөрдөгч бие даан явуулах мөрдөн шалгах

ажиллагаа, /ЭХХШТ.Хуулийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь заалт/ мөрдөн шалгах нууц ажиллагаа /ЭХХШТ.Хуулийн 26.7 дугаар зүйл/ гэж төрөлжүүлэн заасан нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай хүн, хуулийн этгээдийн гэм бурууг нотлох үүрэгтэй прокурор хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн өндөр, ур чадвар гаргаж ажиллах шаардлагыг тодорхойлж байна.

Учир нь ЭХХШТ.Хуулийн 22.4 дүгээр зүйлийн 5-д: мөрдөгч прокурорын зөвшөөрөлгүй мөрдөн шалгах ажиллагаа явуулсан тохиолдолд мөрдөгчөөс ирүүлсэн нотлох баримт, тайлбартай танилцсаны дараа прокурор **нэгдүгээрт:** мөрдөн шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох, **хоёрдугаарт:** мөрдөн шалгах ажиллагаа, нотлох баримтыг хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргахаар заасан нь прокурорын бүрэн эрхэд хамаарах чухал асуудал болсон байна.

Прокурор зөвхөн өөрийнх нь зөвшөөрөлгүй явуулсан мөрдөн шалгах ажиллагаанд холбогдох нотлох баримтыг хянаж шийдвэр гаргаад зогсохгүй мөрдөн байцаалт явуулсан хэргийн материалыг бүхэлд нь хянаж хэргийн талаар ЭХХШТ.Хуулийн 32.4 дүгээр зүйлд заасны дагуу дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

Хэргийг шүүхэд шилжүүлсэний дараа шүүх хэргийн материалыг хүлээн авсанаас хойш 3 өдрийн дотор шүүхийн урьдчилсан



хэлэлцүүлгийг явуулахаар заасан нь ЭХХША-ны шинэ зохицуулалт юм.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр ЭХХШт.Хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6-д дурьдсан 15 асуудлыг хянан хэлэлцэж, шийдвэр гаргахаар заасан нь ЭХХША-аа болон прокурорын хяналт хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан эсэхийг дүгнэх чухал үе шат болсон.

ЭХХШт.Хуулиар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд прокуророос тавих хяналтыг шинэчлэн тодорхойлж, зохицуулсан олон хэм хэмжээг тогтоосон нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны

явцад хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэжээ.

Гэвч хуулийн заалт амьдралд хэрхэн хэрэгжиж, эерэг болон сөрөг ямар нөлөө үзүүлэхийг цаг хугацаа харуулна.

Иймд багш, судлаачид хуулийн хэрэгжилт, явц байдлын талаар судалгаа хийж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд тавих прокурорын хяналтыг боловсронгуй болгох талаарх санал, дүгнэлтээ гаргана гэдэгт итгэж байна.



ӨМГӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

(Харьцуулсан судалгаа)



Ш. Баасанжав

БНСУ-н Сүншил их сургууль
Хууль зүйн сургуулийн докторант

BAASANJAV Shagdar

Soongsil University, Department of Law,
Doctor's course

Оршил

Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөө хууль ёсны ашгийг хамгаалж шударга ёсыг эрхэмлэн дээдлэн өмгөөллийн үйлчилгээг бие даасан, хараат бус хүртээмжтэй, чанартай үзүүлэх нь өмгөөлөх байгууллага өмгөөлөгчдийн үндсэн үүрэг бөгөөд нөгөө талаас өмгөөлөгчид нийгмийг анагаадаг төрийн тулгуур болж өгдөг гүнзгий агуулгатай ажил мэргэжил юм.

Хууль зүйн мэргэжлийн туслалцааны илэрхийлэл болох өмгөөллийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Өмгөөллийн тухай хууль шинэчлэгдэж байгаатайгаар холбогдуулан Монгол Улс болон БНСУ-н Өмгөөллийн тухай хууль болон өмгөөлөгчийн эрх зүйн байдлын талаар өмгөөлөгч мэргэшлийн чиг үүрэг, ёс зүй, түүхэн уламжлал, шинэчлэл, эрүү, иргэн, захиргааны хэрэгт өмгөөлөгч оролцох эрх зүйн үндэслэл, арга зүй, хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх хэлбэр, өмгөөллийн хуулийн этгээдийн ойлголт, тэдгээрийн онцлог байдалд харьцуулсан судалгаа хийж энэхүү өгүүлэлд тусгаж өгөхийг эрмэлзсэн юм.

Нэг. Өмгөөллийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс, түүхэн хөгжил

1.1. Өмгөөллийн үйл ажиллагааны онцлог

Өмгөөлөл гэдэг ойлголт нь "advocacy", "defense" латины adere-үйлчлэх үйл явц, ad defendendum-няцаалт хамгаалалт rep. rechtsanwalt гэсэн үгнээс гаралтай ба өмгөөлөл явуулах үндэслэл нь хүний халдашгүй эрх бөгөөд тухайн эрхийн үнэт зүйлийг бүрэн найдвартай хамгаалах нэн чухал баталгаа нь болж өгдөг онцлогтой. Өмгөөлөгч нь /Латин



"advocatus", Англи "Lawyer, advocate, Attorney at Law" Орос адвокат/-хувь хүн ба хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, шүүхэд тэдгээрийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөн эрх зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлдэг.¹ Өмгөөлөгч гэсэн нэр томъёо нь "advocatus" гэдэг нь "advoco" буюу урьж байна гэсэн утгатай латин гаралтай үг бөгөөд өмгөөлөгч нь хамгийн эртний мэргэжлийн нэг мөн. Өмгөөлөгч гэсэн мэргэжил анх эртний Римд бий болжээ. Оросын эрх зүйн түүхч Е. В. Васьковский: "Римийн анхны хуульчдыг патронууд ба хуулийн зөвлөх, өмгөөлөх гэсэн хоёр мэргэжлийн нэгдэл" байсан гэж тэмдэглэжээ.

Монгол Улсын өмгөөлөгч: Өмгөөллийн тухай хуульд 2002 оны 05 сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсоноор "хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад тэнцсэний дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэн өмгөөлөл хийх эрхтэй байсан ба 2003 онд "Хуульчийн сонгон шалгаруулах тухай хууль" батлагдсаны дагуу 2004 оноос эхлэн мэргэжлийн салбарт 2 жил дадлага хийсний дараа Хуульчийн сонгон шалгаруулалтанд орж тэнцсэн ба өмгөөлөгчийн шалгалт өгч тэнцсэн хуульчид өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгодог байсныг 2013 оны "Хуульчийн эрх зүйн

байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1-д зааснаар хууль зүйн сургууль төгссөн, хуульчийн шалгалтанд орох үед 2 жил мэргэжлийн дадлага хийсэн, энэ хуулийн 9.1-д заасан хуульчийн мэргэшлийн сургалтад 18 сараас багагүй хугацаагаар хамрагдсан иргэн хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж гэрчилгээ авсан хуульч нь өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтанд бүртгэгдсэний дагуу шүүхэд төлөөлөх эрхийн гэрчилгээ авч өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй болно.

БНСУ-н өмгөөлөгч: 2001 онд 3 дугаар сард Хуульчийн сонгон шалгаруулах шалгалтын хууль шинэчлэгдсэний дагуу тусгайлан заасан дээд сургуулиуд төгссөн байх ба хуулийн мэргэжлийн хичээл сонсож 35 аас дээш оноо авсан иргэн хуульчийн сонгон шалгаруулалтанд орох боломжтой ба гадаад улсын иргэн адил хуульчийн сонгон шалгаруулах шалгалт өгч болно гэж заасан байсан ба 2009 онд өмгөөлөгчийн шалгалт авах хууль нэмэгдэж батлагдсан байна. Хуульчийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн ба өмгөөлөгчийн шалгалт өгч тэнцсэн хуульч 2 жил хуульчийн дадлага сургалтыг дүүргэсний дараа өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтээ орон нутгийн өмгөөллийн хороогоороо дамжуулан Өмгөөлөгчдийн холбоонд бүртгүүлнэ. Мөн шүүгч, прокурор хийх эрх авсан иргэн, цэргийн хуулийн хэлтэст 10-дээш жил ажилласан хуульчийн хувьд өмгөөлөлийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй. 2017 онд хуульчийн сонгон шалгаруулах шалгалт хүчингүй болж

¹ С. Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" Dictionary of Law УБ., 2008он 348 дахь тал.



тусгай (лускор) системд хамрагдсан. Энэ систем нь БНСУ-д 2009 оноос эхлэн зарим их дээд сургуулийн хуулийн сургуулиуд “Хуульчийн мэргэшсэн сургууль” болж Лускор системд шилжсэн. Лускор систем нь хуулийн мэргэшсэн сургуульд 3 жил сурч төгсөх, магистр 4 жил сурч төгсөний дараа шүүгч, прокурор, өмгөөлөгчийн шалгалт өгөх ба өмгөөлөгчийн шалгалтанд тэнцсэн хуульч Өмгөөлөгчдийн холбоонд бүртгүүлж өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсаны дараа уг өмгөөлөлчийг хуулийн фирмийн туршлагатай өмгөөлөгч дээр 6 сар дадлага хийлгэнэ. Уг дадлагажуулсан өмгөөлөгч нь Өмгөөллийн холбоондоо тодорхойлж өгсөний дагуу шүүхэд төлөөлөх шаардлага хангасан гэж үзнэ.

Өмгөөллийн эрх зүйн эх сурвалж: Үндсэн хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шалгах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь өмгөөллийн эрх зүйн үндсэн эх сурвалж юм.

Үндсэн хуульд: Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл 13 дахь хэсэгт зааснаар “Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ” гэжээ.²

² Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл”

Мөн Үндсэн хуулийн мөн зүйлийн 14 дэх хэсэгт өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хуульчлахын хамт өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглосон байна.

Өмгөөллийн тухай хуульд: Өмгөөллийн тухай хуулийн 2 дугаар зүйлд зааснаар “Өмгөөллийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, өмгөөлүүлэх эрхийг хангахтай холбогдсон хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэжээ. Өмгөөллийн эрх зүйн хамгийн гол эх сурвалж болох “Өмгөөллийн тухай хууль” нь 6 бүлэг 34 зүйлтэй. Үүнд: Нийтлэг үндэслэл, Өмгөөллийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс, Өмгөөлөгчийн эрх зүйн байдал, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны эрх зүйн байдал, төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх хууль зүйн туслалцаа, бусад гэх 6 бүлэг тус бүрт хуульчилж өгсөн байдаг.

БНСУ –ын Үндсэн хуульд: БНСУ-н Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 4, 5 дугаар зүйлд өмгөөлүүлэх эрхийн талаар заасан байдаг.³ Өмгөөллийн тухай хууль нь 1949 онд батлагдсан бөгөөд 1982 он, 2000 онд бүхэлдээ өөрчлөгдсөн. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Өмгөөллийн тухай хууль” нь 11 бүлэг, 117 зүйлтэй байдаг. Үүнд: Өмгөөлөлийн үйл

эмхтгэлийн 1992. 1 дүгээрт

³ БНСУ-н Үндсэн хууль. 2/19 дэх тал.



ажиллагаа эрхлэх үүрэг хариуцлага, Өмгөөлөгчийн мэргэжлийн эрх, Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, Өмгөөлөгчийн эрх, үүрэг, Хуулийн этгээд (Хуулийн фирм), (Зургадугаар бүлэг 59-63дугаар зүйл хүчингүй болсон), Орон нутгийн Өмгөөлөгчдийн хороод, БНСУ-н Өмгөөлөгчдийн Холбоо, Хуульчийн ёс зүйн хороо ба гишүүдийг томилох, Өмгөөлөгчийн сахилгын шийтгэл болон өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, Шийтгэл зэрэг бүлэгтэй байна. Тухайлбал:

"Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл" гуравдугаар бүлэгт:

Өмгөөлөлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах нөхцөл, журам, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзах, өмгөөлөх үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр зэргийг заасан ба энэ бүлэгийн Долдугаар зүйл 7.1. зааснаар Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсч БНСУ-н Өмгөөлөгчдийн Холбоонд бүртгүүлнэ. Мөн хуулийн 7.2.-т зааснаар Орон нутгийн Өмгөөлөгчдийн хороогоор дамжууан бүртгүүлэх, 7.3.-зааснаар Өмгөөлөгчдийн Холбоо 7.2. заасны дагуу материал хүлээж авангуутаа өмгөөлөгчдийн нэрсийн жагсаалтад бүртгэж хүсэлт гаргасан хуульчид мэдэгдэнэ. Мөн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл татгалзах, Өмгөөлөгчдийн холбоо нь хянан шалгах зөвлөл байгуулах, зөвлөлийн бүрэлдхүүнийг томилох,

Өмгөөлөгчдийн холбооны дүрэм. боловсруулах, харьяалал солих бүртгэл, Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох, илтгэл тайлан гаргах зэргийг тусгаж өгсөнийг харахад өмгөөллийн бүх үйл ажиллагааг Өмгөөлөгчдийн холбоо зохицуулж шийдвэрлэрлэж байдаг нь харагдаж байна.

"Өмгөөлөгчийн үйл ажиллагаа түүний эрх, үүрэг" дөрөвдүгээр бүлэгт:

Өмгөөллийн хуулийн этгээд байгуулах, Хууль зүйн фирмийн туслах ажилчдын эрх зүйн байдал, Хууль зүйн зөвлөгөө өгөх байгууллагуудын зар сурталчилгаа, Өмгөөлөгчийн үйл ажиллагааны төрөл, өмгөөлөгчийн эрх, үүрэг, өмгөөллийн нууц, өмгөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл, зэргийг зохицуулжээ. **"Хуулийн фирм" тавдугаар бүлэгт:** "Хуулийн фирм" байгуулахад тавигдах шаардлага, өмгөөллийн хамтарсан фирмийн салбарыг байгуулах журам, бүтэц "Хуулийн фирмийн" үйл ажиллагааг зогсоох, "Хуулийн фирмийн" татвар зэргийг хуульчилж өгсөн байна. **"Шийтгэл" Арван нэгдүгээр бүлэгт:** Хууль тогтоомж зөрчсөн өмгөөлөгчид хууль зүйн дагуу эрүүгийн хариуцлага тооцож ял шийтгэл хүлээлгэх журмыг хуульчилж өгсөн байна. Хоёр орны өмгөөллийн тухай хууль тогтоомжийг харьцуулан үзэхэд хууль зүйн зарчмын



хувьд төстөй тал байгаа боловч бүлэг, хэм хэмжээг хууль тогтоомжид тусгах, болон хуулийн зүйл заалтуудын хувьд онцлог тал их байна. БНСУ-н Өмгөөллийн тухай хуульд өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй өмгөөлөгчдийн үүрэг хариуцлагыг хамгийн түрүүн тусгаж өгсөн ба Өмгөөлөгчдийн холбооны дүрмийг зөрчих, ажлын алдаа гарган өмгөөлөгчдийн нэр хүндийг сэвтүүлж гэмт хэрэг үйлдсэн бол Өмгөөллийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна. Сахилгын шийтгэл нь: сануулах, 30сая вон хүртэл торгох, 3хүртэл жилийн хугацаагаар үйл ажиллагаа явуулах эрхийг тогсоох, Холбооноос хөөх, тодорхойгүй хугацаагаар Холбооноос хөөх зэрэгээр шийтгэнэ.

Мөн өмгөөлөгч бус этгээд өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд Өмгөөллийн тухай хуулийн 112 дугаар зүйлд зааснаар 3 хүртэл жил хорих ял, 20сая вон хүртэл торгох ял шийтгэл хүлээлгэх ба хорих ял болон торгох ялыг давхар хүлээлгэж болно гэж заажээ.⁴ БНСУ-н өмгөөллийн тухай хуульд хууль зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд дээр хүртэл хариуцлага тооцож шийтгэл хүлээлгэхээр өмгөөллийн хуулиндаа хуульчилж өгсөн нь онцлог юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагаанд оролцогч-өмгөөлөгчийн эрх зүйн байдлын чухал эх сурвалж мөн. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тавдугаар бүлэгт зааснаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулахаар заажээ.

Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Тавдугаар бүлэг 3 дугаар зүйлд өмгөөлөгч оролцуулах:

1. Дараах шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй:

1.1. Хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн, эсхүл хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй

1.2. Өсвөр насны

1.3. Монгол хэл, бичиг мэдэхгүй

1.4. Бүх насаар хорих ял оногдуулж болох

1.5. Хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой шүүгдэгчийн нэг нь өмгөөлөгчтөй байгаа бол бусад шүүгдэгч

1.6. Төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан

2. Энэ зүйлийн 1 дэхь хэсэгт заасан шүүгдэгчийн хүсэлтээр, эсхүл зөвшөөрснөөр энэ хуулийн 5.2дугаар зүйлийн 3дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч сонгоогүй бол шүүх,

⁴ Лак Сын Уг. Өмгөөлөгчийн нэр хүнд" 2008., 110дэх тал.



прокурор нь томилогдсон өмгөөлөгч оролцуулна гэж заасан бол

БНСУ-н Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг 33дугаар зүйлд Шүүхээс томилогсон өмгөөлөгч (Улсын өмгөөлөгч) оролцуулах талаар:

1. Дараахь шүүгдэгч оролцох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй:

1.1. Шүүгдэгч таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хоригдож байгаа

1.2. Өсвөр насны

1.3. 70 наснаас дээш

1.4. Хэлгүй дүлий

1.5. Сэтгэцийн өвчтөй

1.6. Цаазын ял ба бүх насаар хорих, 3 дээш жил ганцаарчлан хорих ял авах магдлалтай

2. Төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан тохиолдолд өмгөөлөгч томилох зэргээр хуульчилсан байна.⁵

БНСУ-н эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Шүүгдэгч таслан сэргийлэх арга хэмжээ авагдан хоригдож байгаа болон 70 наснаас дээш, хэлгүй дүлий иргэнд заавал өмгөөлөгч томилдогоороо онцлог юм.

Америкийн Нэгдсэн улсад Шүүхийн өмнөх шатанд төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагчид өмгөөлөх үйл ажиллагааг хангаж өгдөг. Төлбөрийн чадваргүй байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд

ноцтой хор уршиг тарина гэж үзэж, АНУ-д энэ асуудлаар холбооны болон мужууд улсын төсвөөс ихээхэн хэмжээний мөнгө зарцуулдаг байна. Олон нийтийн өмгөөлөгчийн институци XIX зуунд байсан боловч 1964 оноос эхлэн төрийн төсвөөр санхүүжих болсон байна. Олон нийтийн өмгөөлөгч нь туслах ба нотлох баримт цуглуулах мөрдөгч болон бусад мэргэжилтнүүдтэй байна. 1980-аад оноос энэ салбарын дээд байгууллагын (Legal Services Corporation) жилийн төсөв 300 сая долларт хүрчээ. Өнөөдөр АНУ-д төлбөрийн чадваргүй иргэдийг хамгаалах байгууллага 4 хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна: 1) өндөр мэргэшил бүхий өмгөөлөгч 2) нэг дүүрэгт эрүүгийн хэргээр өмгөөлөх үйл ажиллагаа эрхэлж байгаа өндөр зэрэглэлийн мэргэшсэн өмгөөлөгч 3) өөрийн мэргэжлийн үүрэгт бус харин материаллаг ашиг сонирхолд тулгуурласан (бага хэмжээний зөвөлгөөг олон хүнд өгсөнөөр багагүй мөнгө олох боломжтой); 4) өмгөөлөх зөвшөөрлийг шинээр авсан буюу хууль зүйн сургууль дөнгөж төгссөн хүмүүс өмгөөлөх үйл ажиллагаа эрхлэх гэх зэрэг. Харин АНУ-д шүүн таслах ажиллагаанд оролцогч-өмгөөлөгчийн эрхийг бэхжүүлсэн эрх зүйн хэм хэмжээний акт бараг байхгүй гэж хэлж болно. Өмгөөлөгчийн эрх нь зан заншил, дрецедент эрх зүй, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээнд тусгалаа олно. АНУ-ын Үндсэн хуулийн эхний арван нэмэлт буюу Эрхийн тунхаглалын IV засварт: "Хувь хүн,

⁵ Шин Дун Үн. "БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шалгах тухал хууль" 2009., 89дэх тал.



орон байр, бичиг баримт, эд хөрөнгө халдашгүй байх ард түмний эрхийг зөрчиж үндэслэлгүй нэгжлэг хийх буюу баривчлах зэрэгээр хүний эрхийг зөрчиж болохгүй бөгөөд зөвшөөрлийн бичиг тангараг буюу албан ёсны мэдэгдлээр баталгаажуулалгүйгээр нэгжлэг хийх, баривчлах, эд зүйлийг хураах зэрэг эрхийг тодорхой заасан хангалттай үндэслэлгүйгээр олгож болохгүй” гэж заажээ. Мөн шүүхэд эрүүгийн хэрэг хэлэлцэх ажиллагаанд оролцогч-өмгөөлөгчийн оролцооны үндсэн нөхцлийг Эрхийн тунхаглал VI засварт тусгажээ.

Шүүх нь (1963 оны “Гидеон Уэйн-трайта-ын эсрэг”, 1966 оны “Миранда Аризона муж улсын эсрэг”; 1977 оны “Брюер Вильямсын эсрэг” зэрэг хэрэг болон бусад хэргүүд) хөгжсөн. Шударга шүүхийн суурь, зайлшгүй байх нөхцөл бол өмгөөлөгч оролцуулах явдал юм. Хорих ял оногдож болох гэмт хэрэгтэн бүр өмгөөлөгчтэй байх, өмгөөлөгч нь “яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлж асуудал шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эсрэг талын нотлогоог үгүйсгэж мэтгэлцэх, зөвлөгөө өгөх” зэрэг процессын ажиллагаанд оролцох зарчмыг тусгажээ.

БНХАУ-д өмгөөллийн эрх авахын тулд орон нутгийн хууль зүйн албаны байгууллагад хандах бөгөөд энэ байгууллага нь 30 хоногийн дотор өргөдлийг хүлээн авч судлан, шаардлагыг хангасан эсэхийг шалгана. Хятад Улсын хуулиар тусгай зөвшөөрөл авах гурван үндсэн

шаардлага, тухайлбал: өмгөөлөгчийн шалгуурт тэнцсэн байх, өмгөөллийн үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх, ёс суртахууны шалгуур гэх зэрэг юм. БНХАУ-ын хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар тусгай зөвшөөрөл өгөхийг татгалзах хэд хэдэн нөхцөл байдал бий. Үүнд: өмнө нь ял шийтгүүлж байсан ба хуульд заасанаас бусад гэмт хэрэг үйлдсэн, тусгай зөвшөөрлөө хураалгасан этгээд дахин хүсэлт гаргасан ба төрийн албаас халагдсан этгээдэд тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон заалтууд байна. 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн БНХАУ-ын Өмгөөллийн тухай хуульд зарим нэмэлт өөрчлөлт орсон. Тухайлбал: өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ чөлөөтэй уулзах, мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн материалтай танилцах ба нотлох баримт цуглуулах зэрэг нэмэлт орсон байна. Тухайн хуульд зааснаар мөрдөн шалгах байгууллагаас албадлагын арга хэмжээ авсан буюу сэжигтнийг байцаасан өдрөөс өмгөөлөгчийн үнэмлэх, тусгай гэрчилгээ болон итгэмжлэл (эсхүл эрх зүйн зөвөлгөө өгөх тухай албан ёсны захидал) бүхий өмгөөлөгч нь сэжигтэн яллагдагчтай уулзах болон хэргийн холбогдолтой мэдээлэл авах эрхтэй. Түүнээс гадна өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагчтай ганцаарчлан уулзах бөгөөд хөндлөнгөөс чагнаж болохгүй гэж хуульд тусгайлан заажээ. Өмгөөлөгч хэргийн материалтай танилцах эрхийг улам сайжруулахын тулд хэргийн материал



хувиран авах ба танилцах боломжийг тусгасан заалтыг уг хуулиар шинээр нэмж тусгажээ. Ардын шүүхэд хэрэг шилжиж ирсэн үеэс эхлэн өмгөөлөгч нь хэргийн материалтай танилцах, тэмдэглэл хөтлөх, хувилах эрхтэй болсон байна. Мөн “хувь хүн болон байгууллагын зөвшөөрлөөр” нотлох баримт шинжлэн судлах шаардлагын үүднээс хувь хүн буюу байгууллагын зөвшөөрөл авах практик урд өмнө байхгүй байсан зэргийг харгалзан, зайлшгүй шаардлагатай тохиолдолд эрх бүхий өмгөөлөгч нотлох баримтыг цуглуулах, шинжлэн судлахтай холбогдуулан ардын прокурор болон ардын шүүхэд хандан гэрчийг дуудаж хэрэг хэлэлцэх боломжтой гэсэн зүйл заалт шинээр нэмсэн байна.

ХБНГУ-д Өмгөөлөх байгууллагын зохион байгуулалт болон өмгөөлөх үйл ажиллагааг тусгай хуулиар зохицуулна. Тухайлбал, 1959 онд батлагдсан “Өмгөөлөх байгууллагын тухай” холбооны хууль, 1957 онд батлагдсан “Өмгөөлөгчийн үйлчилгээний төлбөрийн тухай Холбооны дүрэм” зэргийг дурдаж болно. Эртний Римийн үед чөлөөт мэргэжил байсан бөгөөд ямар нэгэн хамтын үйл ажиллагаа эрхэлдэггүй байв. Шүүх мэргэжлийн өмгөөлөгчдийн хамтын нэгдэл анх МТӨ Римийн эзэнт гүрний үед үүсчээ. Хуульч- өмгөөлөгчдийн тухай анхны баримтаас үзэхэд: орлогын тухай бичгээр мэдүүлэх; хууль зүйн шалгалт өгөх хоёр шалгуурыг дурдсан байна. Энэ нь орчин үеийн өмгөөлөх мэргэжлийн шалгуурын гол

үндэс болон уламжлагджээ. ХБНГУ-д өмгөөлөх үйл ажиллагаа эрхлэх хүсэлт тавьсан итгэнд дараах шаардлага тавигдана. Германы шүүхийн тухай хуульд зааснаар шүүгчийн чиг үүргийг гүйцэтгэхэд таарч тохирох иргэнд өмгөөлөх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоно. Энэ нь өмгөөлөгчид нэр дэвшигч хууль зүйн факультетэд хууль зүйн шинжлэх ухааныг 8 улирал үзэж улсын шалгалт өгсөн байх шаардлага юм. Төгсөгч нь шүүх эрх мэдлийн байгууллагад (шүүх, прокурор, наториат, өмгөөлөх) 2-3 жилийн хугацаанд дадлага хийнэ. Энэ хугацааны цалинг муж улсын захиргааны байгууллагын сангаас төлнө. Дадлагын хугацаа дууссаны дараа дахин улсын шалгалт өгч шүүгч, өмгөөлөгч, хуулийн зөвлөх болох зэрэг асуудлыг шийдвэрлэнэ. Дээрхи шаардлагыг хангасан этгээд нь өөрийн амьдран суугаа ХБНГУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу муж улсын хууль зүйн удирдах газарт өргөдөл гаргана. Хууль зүйн удирдах газар нь өргөдлийн дагуу шийдвэрлэхдээ түүний дадлага хийсэн газрын өмгөөлөгчдийн танхимын удирдлагын саналыг авна. Хуульд зааснаар өргөдөл гаргасан этгээдийн хүсэлтийг хангахгүй орхих эрхтэй.

Тухайлбал: өргөдөл гаргасан этгээд нь шүүхийн шийдвэрээр төрийн албанд ажиллах эрх нь хасагдсан бөгөөд энэ шийдвэр гарснаас хойш 8 жил өнгөрөөгүй бол; шүүхийн шийдвэрээр үндсэн хуулийн зарчмыг зөрчсөнөөс шүүгчийн албан тушаалаас болон сахилгын



шийтгэлийн замаар шүүх эрх мэдлийн байгууллагаас халагдсан, эрх зүйн зөрчил гаргасны улмаас өмгөөлөлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй болсон, эрүүл мэндийн улмаас өмгөөлөх үйл ажиллагааг зохих ёсоор гүйцэтгэх чадваргүй болсон, өмгөөлөх үйл ажиллагааг хамтруулан гүйцэтгэх боломжгүй албан тушаалд ажиллаж зэргээс шалтгаалан өмгөөлөх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл өгөхөөс татгалзана гэж заажээ.

1.2. Өмгөөлөх үйл ажиллагааны түүхэн хөгжил

Монгол Ардын Намын гуравдугаар Их хурал 1924 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 15 дугаар хуралдаанаараа "Хуулийн байгууллагын ажлын тухай" хэлэлцэх явцдаа уг асуудалд маш нухацтай шүүмжлэлтэй хандаж байсны дотор хүний эрхийн олон зөрчлийн талаар тавьж байсны нэг нь "мөрдөн байцаах явдлыг шүүн таслахаас салган тусгаарлах, туршлагатай байцаагч нарыг даруй бэлтгэж, ардын төлөөлөгч болон өмгөөлөгчтэй болох хэрэгтэй" гэсэн үг төлөөлөгчдийн анхааралд хүрч, их хурлаас гарах шийдвэрт зохих тусгалаа олжээ.⁶ Хурлын тогтоолд "Шүүн таслах газрын аливаа хэргийг удирдах зөвлөл байгуулж, бүх хэргийг удирдуулах дүрэм хэмжээ тогтоож гүйцэтгэвэл зохино" гэх буюу аливаа шүүх таслах газруудын дүрэмийг өөрчлөж шүүн таслах хэрэгт ардын төлөөлөгч нарыг оролцуулан жинхэнэ ардын шүүн таслах газрыг шинэчлэн байгуулахад

цагийн байдалд нийцүүлж зүй зохистой эрхлэн явуулбал зохино" гэсэн заалтын жинхэнэ утга нь шүүн таслах үйл ажиллагааны бүх шатанд оролцогчдын эрх хэмжээг ялган зааглаж боловсронгуй хэлбэрээр бий болгох, шинэ дүрэм, журмын дагуу ажиллуулах тухай төрийн бодлогыг илэрхийлжээ.⁷

Монгол Улсад 1924 оны анхны Үндсэн хуулийн үзэл санааны дагуу 1926 онд батлагдан гарсан "Монгол улсын шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль"-ийн 65 дугаар зүйлд: "Аливаа хэрэг байцаан шийтгэхэд яллагчийг оролцуулахаар тогтоосон бөгөөд тухайн хэрэгтэн хүсвэл төлөөнөө заалдагч хүнийг шүүн таслах газраас томилох буюу уг хэрэгтэний хөлсөөр урьж ирүүлэн суулгаваас зохино" гэж заасан нь Монгол Улсад өмгөөлөх үйл ажиллагаа үүсэх хууль зүйн үндэслэлийг бий болгожээ. Тухайн үед мэргэжсэн буюу өмгөөлөх дадлага туршлагатай хүн ховор байснаас өмгөөлөх үйл ажиллагааг эрхэлсэн өмгөөлөгчдийн байгууллага нэн даруй байгуулагдаагүй боловч өмгөөлөх үйл ажиллагаа нь амьдралын шаардлагаар хэрэгжиж эхэлсэн байна.⁸ Тухайлбал: 1926 оны 7 дугаар сард манай анхны нэрт хуульчдын нэг Ц.Гүрсэдийн даргалсан цаг зуурын шүүх хурлаар Бароны цэргийн дарга Санжаа-Галдановын хэргийг таслан шийдвэрлэхдээ анх удаа төлөөлөн

⁶ Монгол Ардын Намын III их хурлын материал. УБ.,1960

⁷ Монголын өмгөөлөгчдийн байгууллагын түүхэн замнал. УБ.,2009. 8дахь тал.

⁸ Улсын үндэсний түүхийн архив. Фонд 264. Н/х5 хуудас. 31-32.



заалдагч буюу өмгөөлөгч хэмээх хүнийг шүүх хуралд оролцуулсан баримт байдаг. Энэ хэрэгт хэрэгтэн С.Галданов өөрийн өмгөөлөгчөөр Цогт-Бадамжав буюу Бадамцэрэн-Балсановыг томилж өгөхийг хүсч байснаар батлагдаж байна. Монгол Улсын Засгийн газрын 1928 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолын 3-р зүйлд “Саяхан Шүүх явдлын яамнаас Улсын дээд шүүх таслах тухай олон ардад тусламж үзүүлэх бүлгэмийн дүрмийг 5 бүлэг 28 зүйлтэй төлөвлөн зохиож ирсэн нь зүйтэй” гэж байснаас үзвэл өмгөөлөх байгууллагыг байгуулах дүрмийн төслийн санаачлагч нь Шүүх явдлын яамны сайд, Улсын дээд шүүх таслах газрын дарга Ц.Гүрсэд байжээ. 1940 онд хоёр дахь Үндсэн хууль батлагдан түүний үзэл санааг баталгаажуулж Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүх хуралд өмгөөлөгч оролцуулах журмыг маш тодорхой заасан байна.⁹ Ийнхүү шүүн таслах ажиллагаанд оролцогч субъектийн нэг нь өмгөөлөгч хэмээх албаны хүмүүс бий болсноор энэ ажлыг эрхлэх байгууллагыг Шүүх яаманд “Өмгөөлөх хэлтэс” нэртэйгээр байгуулжээ. Энэ нь Монгол Улсад өмгөөлөх ажлыг эрхлэх албан ёсны анхны байгууллага болсон бөгөөд тус хэлтсийн даргаар ахмад ажилтан Донойн Ханд томилогдон ажиллаж байсан байна. Д.Ханд Өмгөөлөх хэлтсийг тэргүүлж байсан болон анх удаа өмгөөлөл явуулж байсан хэрэг, заргын асуудлын талаар бичсэн дурсамж нь 1967 онд өмгөөлөх

байгууллагаас анх удаа “Зөвлөгч” хэмээх бичмэл сэтгүүлд бичигдсэн байна. Монголын Өмгөөлөгчдийн Холбоо нь 1995 онд Олон улсын барын холбооны гишүүнээр элссэн.¹⁰

БНСУ-н Өмгөөлөх үйл ажиллагаа
Японы эзлэн түрэмгийлэлд орсон үе 1905 оны 11 сарын 8-ны өдөр Өмгөөллийн тухай дүрэм тунхаглаж өмгөөлөгчийн шалгалт авах журам тогтоосноор өмгөөлөгчдийг бүртгэж нэрсийн жагсаалтад бүртгэж эхэлсэн байна. 1907 оны 6 сарын 24-нд Хууль зүйн яамнаас анх удаа өмгөөлөгчийн шалгалт авсан ба 1907 оны 9 сарын 3-ны өдөр Хансон нэртэй Өмгөөллийн хороо байгуулагдаж орон нутгуудад салбар байгуулах гэтэл улс даяар 10 өмгөөлөгчөөс хэтрэхгүй байсан болохоор орон нутгуудад өмгөөлөгчдийн нэгдэл холбоо байгуулалгүйгээр Жон Жусон өмгөөлөгчдийн их чуулган нэртэйгээр байгуулж шаардлага гарахаар цугладаг байв. 1909 онд Кёнсон өмгөөллийн хороо, 1945 онд Жусон өмгөөллийн хороо, 1948 онд Сөүлийн нэгдсэн өмгөөллийн хороо гэх зэргээр өмгөөллийн хороодын нэр солигдож байгаад 1952 онд Бүгд найрамдах өмгөөлөгчдийн холбоо нэртэй болж Үүнээс хойш 1980 онд Сөүлийн нэгдсэн өмгөөллийн хороо шинээр байгуулагдаж 1983 онд Сөүлийн орон нутгийн өмгөөллийн хороо нэртэйгээр өдий болтол үйл ажиллагаа явуулсаар ирсэн байна. 1945 оны 8 дугаар сарын 15 ны өдөр Солонгос Улс Японы эзлэн түрэмгийлэлээс

⁹ Монголын төр эрх зүй сэтгүүл. 1998 1.24 дэх тал.

¹⁰ Монголдын Өмгөөлөгчдийн байгууллагын түүхэн замнал. УБ., 2009.



чөлөөлөгдөн. 1948 оны 7 сарын 17-ны өдөр үндсэн хууль батлагдсаж 1948 оны 8 дугаар сарын 15-ны өдөр засгийн газараа байгуулсан. 1949 оны 11 сарын 7-нд анх Өмгөөллийн тухай хууль батлагдсан. Өмгөөлөгчид нэгдэж ардчилсан нийгмийн төлөө гэсэн уриан доор 1970-1980 онуудад хүний эрхийн өмгөөлөгчид зонхилж байв. 1988онд хүний эрхийн өмгөөлөгчдийн байгууллага байгуулж Сөүл хотод хүний эрхийн өмгөөлөгчдийн байгууллагын төв нь байдаг ба 7 орон нутагт хүний эрхийн өмгөөлөгчдийн байгууллагын төвийн салбарууд ажиллаж байна.

1.3 Өмгөөлөх байгууллагын чиг үүрэг, өмгөөлөх байгууллагын тогтолцоо

Анх 1928 онд "Олон ардад тусламж үзүүлэх бүлгэм" нэртэйгээр байгуулагдаж байсан Монголын Өмгөөлөгчдийн Холбоо өдгөө мэргэжлийн өмгөөлөгчдийг эгнээндээ нэгтгэсэн төрийн бус байгууллага болон өргөжиж байна.

Монголын Өмгөөлөгчдийн Холбоо нь Өмгөөллийн тухай хууль тогтоомжид тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг. Зохих болзол хангасан хүн журмын дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг авч Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүнээр элсэнэ. Өнөөдөр 1500 шахам өмгөөлөгч нэгдэж мэргэжлийн үйл ажиллагааг эрхэлж байна. Өмгөөлөл нь хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн хууль зүйн мэргэжлийн, төдийгүй төрийн байгууллагын үйл ажиллагааг

боловсронгуй болгох, алдаа дутагдлыг нь засан сайжруулахад чиглэгддэг. Үүнд: 1) Өөрийн эгнээнд нэгдсэн өмгөөлөгчдийн эрх ашгийг бүх чиглэлээр хамгаалах, тэдний нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлэх, 2) Өмгөөллийн үйл ажиллагааны бүх төрлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, 3) Өмгөөлөгчдийн ажиллах нөхцлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх, 4) Өмгөөлөгчдийн мэдлэг, мэргэжил, ажлын ур чадварыг дээшлүүлэх, энэ зорилгоор сургалт, давтан сургалт, үзүүлэх сургууль, семинар, зөвлөгөөн, туршлага солилцох уулзалт зэрэг бүх арга хэлбэрийн үйл ажиллагааг зохион байгуулах, 5) Өмгөөлөгчдийг ажил хэргийн шаардлагатай мэдээллээр хангах, 6) Өмгөөлөгчдийн эгнээг өргөтгөх, 7) Өмгөөлөгчдийн нэр хүндийг өргөх, тэднийг алдаршуулах, 8) Өмгөөлөгчдийн сонгон шалгаруулалт, аттестатчиллыг зохион байгуулахад оролцох, 9) Өмгөөлөгчдийг гадаад, дотоодын мэргэжил нэгт өмгөөлөгч, өмгөөллийн товчоо, байгууллагатай ажил төрлийн холбоотой тогтоох, өмгөөлөх байгууллага болон олон улсын өмгөөллийн үйл ажиллагааны нийтлэг жишгийн хэмжээнд өмгөөлөгчдийн үйл ажиллагааг хүргэхийг зорьж ажиллах. Холбооны дэргэд Мэдээллийн төв, Ахмадын хороо зэрэг салбар нэгжүүд мөн ажилладаг. Өмгөөлөгчдийн Холбоо үйл ажиллагаагаа Монгол Улс даяар



нийт 21 аймагт дамжуулан хэрэгжүүлж байна.

БНХАУ-ын Өмгөөллийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар Хятадын өмгөөлөгчдийн зөвлөл нь өмгөөлөгчийн үйл ажиллагааны эрх зүйн байдлыг хангах, өмгөөлөгчийн ажлын туршлагыг нэгтгэн дүгнэж, дэлгэрүүлэх, өмгөөлөгчийн мэргэжлийн бэлтгэл, сургалтыг зохион байгуулах, өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүй болон үйл ажиллагааны сахилгыг шалгах, хяналт тавих, гадаадын адил төрлийн байгууллагуудтай харилцаагаа хөгжүүлэх, өмгөөлөх үйл ажиллагатай холбогдон гарсан маргааныг зохицуулах, мөн түүнчлэн өмгөөлөгчийг шагнаж урамшуулахаар тодорхойлох болон сахилгын арга хэмжээ авах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Хятад улсын Өмгөөллийн тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар өмгөөллийн хуулийн этгээд нь өмгөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохион байгуулалтын хэлбэр бөгөөд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа өмгөөлөгчийн үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ. БНХАУ-д өмгөөллийн хуулийн этгээд байгуулахын тулд дараах нөхцлийг хангасан байна: Өөрийн нэр, хаяг, дүрэмтэй байх, 100 мянган юаниас илүү өмч хөрөнгөтэй байх, Хууль заасан тооны өмгөөлөгчтэй байх. Хятад улсын Өмгөөллийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар өмгөөллийн хуулийн этгээд байгуулах тухай өргөдлийг муж, автономит район буюу төвд шууд харъяалах

болон түүнээс дээш ач холбогдол бүхий хотын түвшинд ардын засгийн газрын захиргааны байгууллага авч хэлэлцэнэ. Хуульд зааснаар энэ байгууллага нь өргөдөл гаргаснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэж зөвшөөрөл олгох буюу зөвшөөрөл олгохоос татгалзалсан тухайгаа бичгээр мэдэгдэнэ. Хуулийн 20 дугаар зүйлд зааснаар өмгөөллийн хуулийн этгээд нь өөрийн салбарыг дээр дурдсан захиргааны байгууллагын зөвшөөрлийн дагуу байгуулж болох бөгөөд тухайн салбарын хариуцлагыг өөртөө хүлээнэ. Хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар өмгөөллийн хуулийн этгээд болон өмгөөлөгч нь бусад өмгөөлөгчийг талаар худал цуурхал тараах, зуучлалын хөлс төлөх болон аж ахуйн нэгжийн өрсөлдөөний шударга бус арга хэрэглэхийг хориглоно. Өмгөөллийн хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Өмгөөлөгчдийн холбоо нь өмгөөлөгчдийн бие даасан, хууль ёсны, хуулийн этгээдийн эрх бүхий олон нийтийн байгууллага мөн. Хуулийн 37 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар улс орны хэмжээнд бүх Хятадын өмгөөлөгчдийн холбоо байгуулахаар тогтоожээ. Муж, автономит район болон төвд шууд удирдагдах хотод өмгөөлөгчдийн холбоо байгуулагдах бөгөөд зайлшгүй шаардлагатай бол хотын дүүрэгт орон нутгийн өмгөөлөгчдийн холбоог байгуулсан байна. Хуулийн 39 дүгээр зүйлд зааснаар өмгөөлөгч нь орон нутгийн өмгөөлөгчдийн холбоонд харъяалагдах ёстой. Орон нутгийн



өмгөөлөгчдийн холбоонд багтсан өмгөөлөгч нь нэгэн зэрэг бүх Хятадын өмгөөлөгчдийн холбооны гишүүн байна. Өмгөөлөгчийн холбооны гишүүн нь холбооны дүрэмд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Өмгөөлөгчдийн холбоо нь дүрэмд заасны дагуу өмгөөлөгчдийг шагнах болон сахилгын арга хэмжээ авах эрхтэй. 1996 оны аравдугаар сарын 6-ны өдөр Бүх Хятадын өмгөөлөгчдийн холбоо нийт өмгөөлөгчдөөс заавал биелүүлэх "Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүй болон үйл ажиллагааны сахилгын хэм хэмжээ" хууль батлан гаргасан. **Өмгөөлөгч нь:** БНХАУ-ын Хууль зүйн яамнаас 1992 оны аравдугаар сарын 22-ны өдөр "Өмгөөлөгчдөд сахилгын хариуцлага хүлээлгэх тухай дүрэм"-ийг баталсан. **Үүнд:** Донгодох, Үйл ажиллагааг түр зогсоох, Өмгөөлөх зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг сахилгын арга хэмжээ авахаар заажээ.

ХБНГУ-д өмгөөлөгчдийн коллегийг нутаг дэвсгэрийн зарчмаар, тухайн орон нутгийн шүүхийн зохион байгуулалтын дагуу байгуулна. Хэрэв үйл ажиллагаа эрхэлж байгаа өмгөөлөгчийн тоо 500 давсан тохиолдолд муж улсын Хууль зүйн яам болон хууль зүйн удирдах газар нь тухайн тойргийн нутаг дэвсгэрийн хоёр дахь түвшиний коллеги байгуулах зөвшөөрөл өгч болно. Тус улсын өмгөөлөгчдийн холбоод нь Өмгөөлөгчдийн холбооны танхимд нэгдэнэ. Коллегийн дээд байгууллага нь бүх гишүүдийн нийтийн хурал мөн. Хурлыг коллегийн даргын санаачлагаар болон өмгөөлөгчдийн

коллегийн 10-аас доошгүй хувийн шаардлагаар хуралдана. Хурлын дэг журмыг тухайн коллегийн дотоод журам болон дүрмээр тогтооно. Нийтийн хурлын шийдвэр нь олонхийн саналаар шийдэгдэх бөгөөд санал тэнцсэн тохиолдолд даргын санал шийдвэрлэх үүрэгтэй байна. Нийтийн хурал нь коллегийн удирдлагыг сонгож, гишүүдийн татварын хэмжээг тогтоож, коллегийн гишүүд түүний гэр бүлийн нийгмийн асуудал, мөн томилолтын болон коллегийн хэрэгцээний мөнгө хөрөнгийг хувиарлах, удирдлага болон өмгөөлөгчийн нэр төрийн шүүхийн зардлыг тооцох зэрэг асуудлыг шийдвэрлэнэ. Коллегийн гүйцэтгэх байгууллага нь удирдах алба бөгөөд ихэвчлэн 7 хүнээс бүрдэнэ. Гэвч өмгөөлөгч бүр коллегид нэгдэхгүй. ХБНГУ-ын хуулиар өмгөөлөгчдийн коллеги нь "нийтийн эрх зүйн корпораци"-ийн хэлбэрт багтах учраас түүний гишүүнчлэл нь сайн дурын хэрэг байна. Гэвч коллегийн гишүүн бус өмгөөлөгч нь Холбооны дээд шүүхэд хэрэг өмгөөлөгчөөр оролцох эрхгүй.

АНУ-ын муж улс бүрд муж улсын өмгөөлөгчдийн холбоо ажиллана. Ихэнх муж улсад өмгөөлөх үйл ажиллагаа эрхэлж байгаа өмгөөлөгч бүр тухайн хобооны гишүүн байхыг шаардана. Гэвч зарим муж улсад өмгөөлөх үйл ажиллагаа эрхлэхийн тулд заавал холбооны гишүүн байхыг шаардахгүй. Эдгээр муж улсад өмгөөлөгчдийн холбоо нь сайн дурын байгууллагын түвшинд ажиллана.



Сайн дурын гишүүнчлэлийн үндсэн дээр байгуулагдсан өмгөөлөгчдийн үндэсний байгууллага бол Америкийн хуульчдын холбоо юм. Хуульчдын холбоо нь хоёр үндсэн зорилготой: нэгдүгээрт, эрх зүйг хөгжүүлэх, шүүх эрх мэдлийг бэхжүүлэхэд туслах, иргэдийн эрх зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх; өөрийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах, америкийн хуульчдын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, хуульч мэргэжлийг боловсронгуй болгох гэх зэрэг. Холбооны өөр нэг зорилт бол өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ тогтоох, сахилгын арга хэмжээ авах, өмгөөлөх үйл ажиллагааны стандарт тогтоох, эрх зүйг хөгжүүлэх, шүүх эрх мэдлийг бэхжүүлэхэд туслахад оршино. Хууль зүйн холбооны гишүүдийн татвар нь хууль зүйн ямар байгууллага, ямар фирмд ажиллаж байгаа болон хуульчдын орлоготой холбоогүй байна. Өмгөөлөгчдийн холбооны гишүүд нь зөвхөн өмгөөлөх үйл ажиллагаа эрхэлж байгаа эсэхээс үл хамааран прокурорт ажиллаж байгаа болон хуулийн зөвлөгч нар гишүүн байж болно. АНУ-ын өмгөөлөгчдийн бараг тал хувь нь ганцаараа эсхүл багаар хамтарч ажиллана. Гэвч америкийн өмгөөлөгчдийн хамтын ажиллагааны хамгийн гол хэлбэр бол өмгөөлөгчдийн фирм (50-иас дээш өмгөөлөгчдийг өөртөө багтаасан) байна. Эдгээр фирмүүд нь ихэвчлэн эрүүгийн хэрэгт оролцохгүй, үйлчлүүлэгч-корпорацийг хууль зүйн талаас дэмжих зорилготой. Эдгээр

фирмийн эздийг хамтрагч гэж нэрлэнэ. Хамтрагч нь өргөн дадлага туршлагтай, өндөр дээд цалин пүнлүүтэй, тухайн фирмийн оролгын ихэнх хэсгийг эзэмших эрх бүхий өмгөөлөгч байна. Өмгөөлөгчийн хоёр дахь хэсэг нь өөрийн цөөн харилцагчтай, эсхүл огч үйлчлүүлэгчгүй ассоциатор гэж нэрлэгдэх залуу өмгөөлөгчид байна. Ассоциатор нь тухайн фирмээс цалинжина. Эдгээр фирмд ажиллаж байгаа ассоциатор нь 8 жилажилласны дараа партнер болох, эсхүл фирмээс халагдах нөхцөлтэй. Өмгөөлөгчдийн зарим хэсэг нь муж улсын төсвөөр ажиллах байгууллага болох "нийтийн өмгөөлөгчдийн (хамгаалагчдын)" албанд ажиллаж, ядуу, хөрөнгө орлого бага яллагдагчдыг үнэ төлбөргүйгээр өмгөөлнө. Мөн орлого бага хүмүүст холбооны төвөөр хууль зүйн туслалцаа үзүүлэх өөр нэг байгууллагууд бий. Эдгээр албадыг толгойлох байгууллага нь Конгрессоос санхүүжиж, түүнээс байгуулагддаг Хууль зүйн туслалцаа үзүүлэх Корпораци юм. Олон өмгөөлөгчид олон нийтийн, өөрийн зорилгоо шүүх эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлэхэд тулгуурласан байгууллагын хууль зүйн албадад ажиллана. Эдгээр байгууллагуудын хамгийн томоохонд Иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах Америкийн зөвлөл, Өнгөт арьстыг хөгжүүлэхэд туслах Үндэсний холбоо, Үндсэн хуулийн эрхийг хамгаалах төв, Байгалийн нөөцийг хамгаалах Үндэсний зөвлөл, Улс төр, арьс өнгөөр хэлмэгдүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөл зэргийг дурдаж болно.



Францын өмгөөлөгчид нь Холбоонд (орден) нэгдэнэ. Шүүхийн тойрог бүрд нэг холбоо ажиллана. Бүс нутгийн 181 шүүхийн адил тоотой холбоо байна гэсэн үг. Холбоо бүр бүрэлдэхүүний хувьд өөр өөр, хамгийн бага нь гэхэд 7 барристер, хамгийн том нь 11 мянган барристераас бүрдэнэ. Холбоо өөрийн эд хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны дотоод журам бүхий бүр хараат бус, бие даасан байгууллага байна. Өмгөөлөгчдийн холбооны тэргүүн нь холбооны гишүүдийн нууц санал хураалтаар 2 жилийн хугацаагаар сонгогдсон тэргүүн байна. Тэргүүн нь холбооны ашиг сонирхлыг төрийн ба төрийн бус байгууллагын өмнө төлөөлөх, өмгөөлөгчдийн хоорондын маргааныг шийдвэрлэх, холбооны өмгөөлөгчид сахилгын арга хэмжээ авах, холбооны албадыг удирдах бүрэн эрхтэй бөгөөд мөн холбооны зөвлөлийг даргална. Холбооны зөвлөл нь холбооны гишүүдийн нууц саналаар 3 жилийн хугацаагаар сонгогдоно. Холбооны зөвлөл нь холбооны үйл ажиллагааны бүхий л салбарыг удирдана. Францын үндэсний хэмжээний байгууллага нь холбооны гишүүдээс сонгогдсон Өмгөөлөгчдийн холбооны зөвлөл байна. Францын өмгөөлөгчдийн холбооны зөвлөлийн үндсэн үүрэг бол өмгөөлөгчдийг бэлтгэх сургалтын төвүүдийн үйл ажиллагааг зохицуулах, төр болон олон нийтийн өмнө өмгөөлөгчдийн хамтын нийгэмлэгийг төлөөлөх, мөн бүхий л мэргэжлийн сахилгын болон ёс зүйн хэм хэмжээг боловсруулах

зэрэг байна. Францын өмгөөлөгчид нь бие дааж буюу бусад өмгөөлөгчтэй хоршин хамтарч ажиллаж болно. 1992 оноос өмгөөлөгчид аж ахуйн нэгжид ажиллах эрх олгожээ. Түүнээс гадна өмгөөлөгч нь бусад өмгөөлөгчийг хөлсөлж болно. Бусад өмгөөлөгчид хөлсөөр ажиллаж байгаа өмгөөлөгч нь өөрийн үйлчлүүлэгчтэй байж болохгүй. Энэ тохиолдолд иргэний эрх зүйн бүх хариуцлагыг хөлслөгч-өмгөөлөгч хариуцана. Өмгөөлөгчдийн хамтын ажиллагааны хэлбэр туйлын олон янз учраас тэдгээрийг өмгөөлөгчийн хариуцлага болон хөлсний хэлбэрээр ангилна. Хамгийн түгээмэл хэлбэр бол өмгөөлөгчдийн холбоо болон иргэний-мэргэжлийн нөхөрлөл байна. Өмгөөлөгчдийн холбоод нь өөрийн үйлчлүүлэгч бүрийн өмнө шууд хариуцлага хүлээсэн өмгөөлөгчдийн нэгдэл мөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

2.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч ба өмгөөлөгчийн эрх зүйн байдал

Өмгөөлөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн цагаатгах буюу түүний хариуцлагыг хөнгөрүүлэхийн тулд хуульд заасан бүхий л арга хэмжээг авах бөгөөд энэ нь хэргийн бодит үнэнийг тогтоох, нийгмийн шударга ёсыг хангуулахад чиглэнэ.¹¹ Эрх зүйн байдал нь нийгмийн бүтэц, ардчиллын түвшин, хууль ёсны байдалтай нягт холбоотой улс төр, хууль зүйн хамгийн чухал ухагдахууны нэг мөн. Эрх зүйн

¹¹ Ж. Бямбаа. Монгол Улсын эрүүгийг байцаан шийтгэх эрг зүйн үнсэн асуудлууд. УБ. ,2008. 100 дахь тал.



ерөнхий байдал нь Үндсэн хуулиар тодорхойлогдох бөгөөд бүх хүмүүст нийтлэг, нэгдмэл байна. Эрх зүйн тусгай байдал гэдэг нь өөрт ногдсон тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх боломж олгож байгаа тодорхой хэсэг хүмүүсийн байдал мөн. Мөн эрх зүйн субъектээр нь бие хүний эрх зүйн байдал ба хуулийн этгээдийн эрх зүйн байдал, эрх зүйн салбараар нь үндсэн хуулийн эрх зүйн, захиргааны эрх зүйн, мөн эрүүгийн эрх зүйн гэх зэргээр ангилж болно.¹²

ХБНГУ-д Эрүүгийн хэрэгт яллагдагч болон шүүгчдэгчийн эрхийг хамгаалах

Мөн эрүүгийн процессын хүрээнд хохирогчийн ашиг сонирхлыг төлөөлж болно. Өмгөөлөгч нь хуульд заасан үндэслэл журмын дагуу үйлчлүүлэгчийнхээ эд хөрөнгийг захирах удирдах тухай гэрээ байгуулж болно. Харин өмгөөлөгч нь тусгай гэрээний дагуу хуулийн зөвөлгөө өгөх чиг үүргийг гүйцэтгэж болох боловч, “шүүх эрх мэдлийн хараат бус байгууллага”-ын хувьд Холбооны хуульд заасны дагуу орон тооны өмгөөлөгч байж болохгүй.¹³

2.2 Шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгч оролцох онцлог

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулж байгаа нь сэжигтэн, яллагдагч шүүгчдэгчийг өмгөөлүүлэх

эрхээр хангах нь чухал баталгаа мөн.

Өмгөөлөгч бол тухайн хэргийн талаар үйлчлүүлэгчийн нууцыг мэдэж байдгийн хувьд мөрдөн байцаалтын явцад алдаа гарахаас сэргийлсэн хүсэлт, санал гомдлыг хуульд заасан үндэслэл журмын дагуу гаргаж өгдөг. Өмгөөлөгч үйлчлүүлэгч хоёрын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэхэд чиглэгдэн өмгөөлөл нууц байх, өмгөөлөгчийг гэрчээр байцаахыг хуулиар хориглосон байдаг тул үйлчлүүлэгч нь өмгөөлөгчдөө үнэнийг хэлдэг.¹⁴

АНУ-ын эрүүгийн процесст өмгөөлөгч нь сэжигтний эрх, ашиг сонирхлыг цагдаагийн байгууллагаас сэжигтэнд холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж эхэлсэн, баривчлах болон байцаалт авах үеэс эхлэн хамгаалж эхэлнэ. АНУ-ын эрүүгийн процесст цагдаагийн байгууллага мөрдөх явцад сэжигтэн, яллагдагчийн ашиг сонирхлыг хамгаалах талаар байцаан шийтгэх баталгааг өргөжүүлэхэд чиглэсэн *Miranda v. Arizona* хэргийн шийдвэр ихээхэн ач холбогдолтой. Энэ прецедентээс үзэхэд

Өмгөөлөгч нь: 1) үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг түүнийг баривчлах буюу албадан саатуулах үеэс эхлэн хамгаалах, 2) өөрийн үйлчлүүлэгчийг байцаахаас нь өмнө болон цагдаагийн мөрдөн мөшгөлтийн бүхий л үе шатанд уулзаж, хууль зүйн зөвөлгөө өгөх, 3) байцаалт, танин олуулалт, үзлэг нэгжлэгийн үед байлцах, 4) яллах материалтай танилцах зэрэг эрхтэй

¹⁴ Н. Ламжав. Өмгөөлөллийн үйл ажиллагааны аргын зарим асуудлууд. УБ., 2010. тал

¹² Э. Зууннаст. Монгол Улс, БНМАУ-н Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дахь өмгөөлөгчийн эрх зүйн байдлын харьцуулалт. “Өмгөөлөл судлал. I боть. УБ., 2011. 379 тал.

¹³ “Нью-Йорк Таймс”. КПК использует статью 306 Уголовного Кодекса для ущемления прав адвокатов // www.epochtimes.ru



байна.¹⁵ Өмгөөлөгч нь цагдаагийн мөрдөлтийн бүхий л үе шатанд үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцон үйлчлүүлэгчийн дараах эрхийг хамгаална. баривчлагдсан болон саатуулагдсан үйлчлүүлэгчтэйгээ уулзах, байцаах, мэдүүлэг авах үед байлцах, үзлэг нэгжлэг хийх үед нь байлцах, хэргийн нотлох баримттай танилцах, эд зүйлсийн зургийг авах болон баримт бичгийг хуулбарлан авах зэрэг эрхтэй байна. АНУ-ын эрүүгийн процессын цагдаагийн мөрдөлтийн үе шатанд мэтгэлзэх зарчмын хүрээнд өмгөөлөгч нь өөрийн "өмгөөлөх мөрдөлт"-ийг явуулах эрхтэй.¹⁶ Урт удаан хугацааны туршид хэргийг урьдчилан хэлэлцэх үед сэжигтэн яллагдагч нь өөрийхөө эсрэг мэдүүлэг өгөх боломжтой байсан учраас энэ асуудал шүүмжлэлд ихээхэн өртдөг. АНУ-д нэг жил хүртэл хугацаагаар гянданд хорих буюу 1000 доллараас багаар торгох ялтай нийгмийн хор аюулын хувьд бага эрүүгийн хэргүүдийг ихэвчлэн АНУ-ын тойргийн шүүхүүдэд ажиллаж байгаа магистратууд урьдчилан хэлэлцэнэ.

Магистратаар хэргийг урьдчилан хэлэлцэх үе шатанд өмгөөлөгч нь:

1) цагдаагийн цуглуулсан нотлох баримтын хууль ёсны байдалд үзлэг шалгалт хийхийг шаардах, 2) яллах талаас яллах үндэслэлд нэмэлт болгож

гаргасан "хувийн билль- акт"-ын талаар магистратад өргөдөл гомдол гаргах, 3) яллах талд яллагдагчийг цагаатгах шинжтэй нотлох барим байгаа бол түүнийг өгөхийг тэднээс шаардах, 4) цагаатгах нотлох баримтыг гаргах, 5) нотлох бүх баримтыг шинжилсэн тухай протокол хөтөлсөн эсэх талаар магистрат-шүүхэд гомдол гаргах, 6) өөрийн өмгөөлөх талын гэрчийг дуудах, асуулт тавих, 7) өөрийн үйлчлүүлэгчийг хамгаалах зорилгоор гэрчийн мэдүүлгийг гаргаж тавих гэх зэрэг эрхтэй. Цагдаагийн мөрдөлтийн олон хэлбэрүүд шүүх эрх мэдлийн хяналтан дор хэрэгжинэ. Цагдаагийн байгууллагаас баривчлах, үзлэг нэгжлэг хийх, нүүрэлдүүлэн байцаах, утсан харилцаа чагнах болон цахим хяналт явуулахын тулд мөрдөн байцаалт явуулах хангалттай үндэслэл байгаа гэсэн цагдаагийн байгууллагын нотолгоо, тангарагт тулгуурлан магистрат-шүүгч зөвшөөрөл өгнө. Холбооны түвшинд баривчлах болон үзлэг нэгжлэг хийх зөвшөөрлийг шүүхээс өмнөх шатанд байцаан шийтгэх ажиллагаа явуулах эрх бүхий холбооны тойргийн шүүхийн АНУ-ын магистрат-шүүгч (US Magistrates) өгдөг бол утсан харилцаа чагнах болон цахим хяналт явуулах зөвшөөрлийг зөвхөн тойргийн шүүхийн шүүгч (US District Judges) холбооны прокурорын дэмжиж, гаргасан үндэслэл бүхий өргөдлийн дагуу өөрөө өгнө.¹⁷ Холбооны мөрдөн байцаах товчооноос сөрөх тагнуулын

¹⁵ В.М.Никола Судебные системы западных государств. Под ред. Тумановой В.А. .М., 1991г.

¹⁶ Судебные системы западных государств. Под ред. Тумановой В.А. .М., 1991г.

¹⁷ Ч.Нямсүрэн. Судебная власть и разведывательный орган в Монголии // Криминологический журнал БГУЭП. Иркутск., 2011. 3.



ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай байгаа утсан харилцаа чагнах болон цахим хяналт явуулах зөвшөөрлийг Холбооны тусгай шүүх өгнө. Их суудлын тангарагтны шүүх (Grand Jury) болон магистрат-шүүгчийн урьдчилан хэлэлцэхийн ялгаатай тал нь гэвэл Их суудлын тангарагтны шүүхийн тангарагтнууд ихэвчлэн яллах талын нотлох баримтыг авч үздэгт оршино. Мөрдөн байцаах болон хэргийг шүүхэд шилжүүлэх онгой байгууллага бол тангарагтны өргөжүүлсэн (анхан шатны тангарагтны шүүхтэй хаьцуулахад илүү олон бүрэлдэхүүнтэй, шүүхийн онцлогоос шалтгаалан 12-23 хүний бүрэлдэхүүнтэй) шүүх болох Их суудлын тангарагтны шүүх мөн. Их суудлын тангарагтны шүүх нь хүнд гэмт хэрэг үйлдсэнтэй холбоотойгоор хуралдана. Энэ хуралдаан дээр төрийн яллагч гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдэж байгаа үндэслэл бүхий материалыг танилцуулж, гэрчийг байцааж, шинжээчийн дүгнэлттэй танилцана. Их суудлын тангарагтны шүүхийн мөрдөн байцаалтын үр дүнд яллах дүгнэлт хийж, энэ үндсэн дээр яллагдагчийг шүүхэд шилжүүлнэ. Ийм ч учраас Их суудлын тангарагтны шүүх нь АНУ-ын Үндсэн хуульд зааснаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны иргэдийн оролцооны институцийн хувьд муж улс болон холбооны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд ажиллана. Магистратын шүүхээр урьдчилан хэлэлцэхээс ялгаатай нь өмгөөлөгч Их суудлын тангарагтны

шүүхэд өөрийн үйлчлүүлэгчийн талд ашигтай нотлох баримтыг танилцуулахгүй. Хуульд зааснаар өмгөөлөгч нь Их суудлын тангарагтны шүүхийн мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцохгүй. Ийм ч учраас америкийн хуульчид энэ үндэслэлийн эерэг, сөрөг талаар өөр өөр байр суурьтай байдаг. Гэвч яллагдагчийн өмгөөлөгч Их суудлын тангарагтны шүүхийн мөрдөн байцаалтын үр дүнд нөлөөлөх зарим эрхтэй. 1) яллагдагчийн өмгөөлөгч нь хэрэв түүнд тангарагтанууд шударга бус байх эргэлзээ төрвөл хэргийг хэлэлцүүлэхээр өөр дүүрэгт шилжүүлэх тухай хүсэлт гаргах, 2) яллагдагчийн өмгөөлөгч нь Их суудлын тангарагтны шүүхийн зарим гишүүдийг татгалзан гаргах болон тангарагтны нэрийн жагсаалтыг бүхэлд нь татгалзах эрхтэй. Их суудлын тангарагтны шүүхийн бүх гишүүдийг татгалзан гаргах шалтгаан нь тангарагтны шүүхийн бүрэлдэхүүний нэрсийг сугалаагаар тодорхойлох, дуудах зэрэг нь хууль тогтоомж зөрчсөн гэх эргэлзээ өмгөөлөгчид төрсөн зэрэг байж болно. Энэ тохиолдолд татгалзан гаргах хүсэлтийг зөвхөн бичгээр зарлана. Мөн хуулиар тогтоосон тангарагтны шаардлагыг хангаагүй байх, сэтгэцийн байдлаас болж өөрийн үүргээ зохих ёсоор биелүүлж чадахгүй гэж үзсэн тохиолдолд өмгөөлөгч нь Их суудлын тангарагтны шүүхийн тодорхой гишүүнийг татгалзан гаргаж болно. Тодорхой гишүүнийг татгалзан гаргах ажиллагааг амаар зарлаж болно. Холбооны дүрэмд зааснаар өмгөөлөгч



Их суудлын тангарагтны шүүхийн тангарагтнууд тангараг өргөхөөс өмнө татгалзан гаргах тухай зарлах эрхтэй, 3) яллагдагч болон түүний өмгөөлөгч Их суудлын тангарагтны шүүхээр хэргийг хянуулахаас татгалзаж болно.¹⁸

2.3. Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох нь

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.10 дугаар зүйл

Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцож нотлох баримт шинжлэн судлах, шүүх хуралдааны явцад гарсан асуудлаар хүсэлт гаргах, шүүгдэгчийг цагаатгах, түүний хариуцлагыг хөнгөрүүлэх байдлын талаар дүгнэлт гаргах, Шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг өмгөөлөгч бусдыгаа төлөөлж болох, Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бусдыгаа төлөөлж байгаа өмгөөлөгч бусад өмгөөлөгчтэй зөвлөлдөх зорилгоор шүүхээс шүүх хуралдааныг завсарлуулахыг хүсч болох, Энэ зүйлийн 5.3 дугаар зүйлийн 1 дэхь хэсэгт зааснаас бусад тохиолдолд шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлт бичгээр гаргасан бол хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж болох, Хохирогч, иргэний нэхэмжлэгч иргэний хариуцагчийн өмгөөлөгчид энэ бүлэгт заасан шүүгдэгчийн өмгөөлөгчийн эрх, үүрэг нэгэн адил

гэж тус тус зааж өмгөөлөгчийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох үндсийг тус тус тодорхойлж өгсөн байна. Өмгөөлөгч нь шүүгчийн өмнө хараат бус байж шүүгчдэгчийн гэм буруутай эсэхийг нотлохын тулд талуудтай өрсөлдөх хэлбэрээр оролцож байгааг маргаан шийдвэрлэх ажиллагааны нэг төрлийг мэтгэлцээн гэнэ. Шүүх хуралдаан мэтгэлцээний үндсэн дээр явагдана.¹⁹ Хуучин эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаас үзэхэд мэтгэлцэх зарчим нь зөвхөн анхан болон давж заалдах шатны журмаар хэрэг хянан хэлэлцэхэд үйлчилэх ба оролцогчид тэгш эрхтэй байж харилцан эсрэг сонирхолтой талуудын хооронд явагдана гэж заасан байна.²⁰ Шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шүүгдэгчид хохиролтой ямар нэг зөрчил гаргахгүй, хуулийг зөв хэрэглэх, гэмт хэрэг үйлдээгүй нэг ч хүнийг үндэслэлгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйг зорих явдал мөн.²¹ Шүүх хуралдаанд хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт бичиг гаргаж өгөх, нотлох баримт шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, үг хэлэх адил эрхтэйгээр мэтгэлцэх ёстой. Мэтгэлцээний дээрх хэлбэрүүд практикт хэрэгжиж байгаа болон зарим ач холбогдолтой зүйлүүдийг

¹⁹ Д. Зүмбэрэлхам. Шүүхийн мэтгэлцээн. УБ., 2002. бдахь тал.

²⁰ Б. Мөнхжаргал. Эрүүгийн байцаан шийтгэх ажилгааны мэтгэлцээнд өмгөөлөгч оролцох нь // Өмгөөлөл судлал. 16-р тал. УБ., 2011.

²¹ Б. Бат-Эрдэнэ. Анхан шатны шүүх хуралдааны ажиллагаа ба мэтгэлцээн // Хуульчийн ур чадвар сургалтын гарын авлага. УБ., 2007. 42 дахь тал.

¹⁸ Фридман Л. Введение в американские право. М.: Прогресс-Универс, 1992. С. 57.



хуульд заагаагүй байна.²²

2.4. Өмгөөлөгчийн эрх зүйн байлдгыг боловсронгуй болгох зарим асуудал

Доктор профессор С.Нарангэрэл “Хүний эрх, өмгөөлөл” номондоо “Өмгөөлөгчдийн ёс зүйн хэм хэмжээг мэргэжлийн мөн чанартай холбогдох, үйлчлүүлэгчидтэй харьцах, бусад өмгөөлөгчдөд хандах, бусад хуульчидтай харьцах” хэмээн оновчтой авч үзсэн байна.²³ Түүнчлэн Японы нэрт өмгөөлөгч Моригива Ясумото “Хуульчийн ёс зүй” бүтээлдээ өмгөөлөгчийн ёс зүйг өргөн утгаар нь Иргэний хэрэг, Захиргааны хэрэг, Эрүүгийн хэрэг дээр ажиллах үед баримтлах ёс зүй гэх мэтээр авч үзсэнээс гадна өмгөөлөгч хүний ёс зүйг нарийвчлан судалсан нь ач холбогдолтой болжээ.²⁴ Өмгөөлөгч хүн ёс зүйн журмын мөн чанарыг ухамсарлаж түүнийг мөрдөх арга барилыг зөв эзэмшиж, энэ талаарх хууль дүрэм, журмаа сайтар баримталж шударга ёсыг эрхэмлэж дэмжиж ажиллах ёстой. Үүнтэй холбогдуулж өмгөөлөгчийн бие даасан, хараат бус чөлөөт байдлын тухай томъёолол, тодорхойлолтыг ямагт бодолцож үйл ажиллагааныхаа нэгэн чухал зарчим болгох нь зүйтэй гэж үзэж байна. Хүний иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад “Хүн шаардлагатай үедээ

хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах тухай” заасан бөгөөд НҮБ-аас хүний эрхийг хамгаалах хуульчдын эрх, үүргийг тодорхойлон улс орнуудын Засгийн газарт анхаарвал зохих зүйлийн талаар зөвлөмж гаргасан байдаг. Үүний дагуу орчин үед олон улсын хэмжээнд өмгөөлөгчдийн бие даасан хараат бус байдлыг хангах, тэдний энэхүү байдлыг баталгаажуулахад үлэмж анхаарч байна.²⁵ Гадаадын ихэнх оронд сүүлийн жилүүдэд нийгмийн сайн сайхны төлөө үнэ төлбөргүй туслалцаа үзүүлдэг үйлчилгээ хүчтэй хөгжиж байна. Энэ үйлчилгээг рго ьопо гэж нэрлэдэг. АНУ-ын Барын холбооны дүрэмд зааснаар хуульч бүр жилд 50 цагийн рго ьопо үйлчилгээг төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй үзүүлэх нь мэргэжлийн үүрэг байдаг. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар иргэний хэргийн нэхэмжлэгч, хариуцагч болон эрүүгийн хэргийн хохирогч, иргэний хариуцагч нар үнэ төлбөргүй өмгөөлүүлэх эрх байдаггүй. Рго ьопо үйлчилгээ бол эрх зүйн салбарын хязгаарлалт байхгүй, иргэдэд тулгарч байгаа бүх төрлийн асуудыг хамаардгаараа нийгэмд ач холбогдолтой үйлчилгээ болох юм. Рго ьопо үйлчилгээ нь иргэдийн эрх ашгийн төлөө үйлчилгээ боловч нөгөө талаас тухайн өмгөөлөгчийг иргэдэд сурталчилах мэдлэг үр чадварыг мэдрүүлэх, нийгэмд эзлэх байр суурийг өргөжүүлэх, бэхжүүлэх

²² Н. Лхамжав. Шүүх хуралдаан, түүний шүүмжлэлийн үе//Өмгөөлөл судлал. Иботь. УБ., 2011. III дэх тал.

²³ С. Нарангэрэл Хүний эрх өмгөөлөл. УБ., 1998.

²⁴ Моригива Ясумото. Хуульчийн ёс зүй. УБ., 2006.

²⁵ Г. Наранбаатар. Өмгөөлөгчийн гаргадаг нийтлэг алдаа юу вэ. “Өмгөөлөл судлал”. Иботь. УБ., 2011. 280дахь тал.



төдийгүй үйлчлүүлэгчийг олноор татах ач холбогдолтой.²⁶

ДҮГНЭЛТ

Гадаадын зарим орнуудад өмгөөллийн үйл ажиллагааг Өмгөөллийн холбоо удирдан зохион байгуулж бүхий л ажиллагаанд нь хяналт тавьдаг нь харагдаж байна Жишээлбэл:

БНСУ-н Өмгөөллийн тухай хуульд Өмгөөлөгч бүс этгээд өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд Өмгөөллийн тухай хуулийн 112дугаар зүйлд зааснаар 3 хүртэл жил хорих ял, 20сая вон хүртэл торгох ял шийтгэл хүлээлгэх ба хорих ял болон торгох ялыг давхар хүлээлгэж болно гэж заажээ. Үүнээс харахад Өмгөөллийн тухай хуулиндаа өмгөөлөгчдийн эрх зүйн байдлыг хангах талаар маш оновчтой тусгаж өгсөн байгаа юм. Мөн өмгөөлөгчдийн сахилгын шийтгэлийн талаар зүйлчилж өгсөн байдаг ба хууль зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд дээр хүртэл хариуцлага тооцож шийтгэл хүлээлгэхээр өмгөөллийн хуулиндаа хуульчилж өгсөн нь онцлог юм.

Манай өмгөөлөгчид хугацаагаа барихгүй, хоцорч ирснээр шүүгчдэд зэмлүүлэх ийм байдлаар нэгэнт үнэлэмж нь буурсан тул өмгөөлөгчийн үгийг шүүгч нар үл тоох байдал гарч байна. Түүчлэн өөрт ашигтай асуулт тавьж мэдүүлэг авах өмгөөлөгчийн чадвар хангалтгүй байх тохиолдол ч гарч байдаг. Мөн шүүх хуралдааны явцад өмгөөлөгч өөрийн үйл

хөдлөл, биеэ авч явах байдалдаа хяналт тавьдаггүй зэрэг дутагдал ажиглагдаж байна. Өмгөөлөгчдийн тухайд дээр дурдсан алдаа дутагдалд онцгой анхаарч цаашид Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос өмгөөлөгчдийн мэргэжлийн ур чадвар, ёс зүйн талаар анхаарал тавих арга хэмжээ авна хэмээн найдаж байна. Түүнчлэн өмгөөлөгч бүр ийм зөрчил, алдаа дутагдлыг гаргахгүйг хичээн ажиллах нь зүйтэй юм.

Шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрх хангагдаж байгаагаас гадна өмгөөлөгчөө өөрсдөө сонгох эрхээ хэрэгжүүлж байна. Хохирогч нар шүүх хуралдаанд ихэнхи тохиолдолд өмгөөлөгчгүй оролцож байна. Өмгөөлөгч нар шүүх хуралдаан эхлэхийн өмнө л хэргийн материалтай танилцдаг, боловч шүүх хуралдаанд бэлтгэл муутай оролцдог. Өмгөөлөгч нар яллагч буюу мэтгэлцэгч талаас асуулт асуух зэргээр мэтгэлцдэггүй.

Өмгөөлөгч мэтгэлцээнд идэвхигүй оролцож, шүүгдэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн гүйцэд хамгаалж чаддаггүй. Асуултаа тодорхой, оновчтой тавьж чаддаггүй.

Төлбөрийн чадваргүй иргэдийг өмгөөлөхөөр томилогдсон өмгөөлөгч нарын идэвхи сул байгаа байдал харагдаж байна.

²⁶ Шүүх хуралдааны ажиглалтын тайлан// Нээлттэй Нийгэм Форум. УБ.,



МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙН БАТАЛГАА НЬ ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ТОГТООМЖООР ТОМЬЁОЛОГДОХ НЬ

(Нийтийн болон хувийн эрх зүйн хүрээнд)



Е.Болормаа

Шихихутуг ИС-ийн Иргэн, Бизнесийн
эрх зүйн тэнхимийн багш

Хөдөлмөрлөх эрх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжоор хөдөлмөрийн харилцаа үүсэхийн өмнөөс дуусгавар болсоны дарааг хүртэл¹ тус эрхийг баталгаатай ханган эдлүүлэх, хамгаалах асуудлыг

¹ Мильтон Фридман Рөүз Фридман "Хувь заяагаа сонгох нь", УБ хот., 2007 он 196 дахь тал. "Чөлөөт зах зээлийн нэг шинж нь өрсөлдөөний гүйцэтгэх үүрэг мөн", Хүрээд очиход нь ажилд авах өөр бусад ажил олгогч байдаг учраас л ажилчин өөрийн ажил олгогчоос хамгаалагдсан байна. Ажил олгогчид цаана нь авч ажиллуулах өөр бусад ажилчид байгаа учраас ажилчдын зүгээс дарамтанд орохоос хамгаалагдсан байдаг. Үйлчилж буй худалдагчаас гадна өөр бусад худалдагчид цаана нь байгаа учраас л хэрэглэгч хамгаалагдсан байдаг юм гэжээ.

онол, практикийн үүднээс авч үзэхэд илтгэлийн зорилго нь оршино.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж нь хөдөлмөрлөх харилцааг бүхэлд нь хамарч үйлчлэх, нэгдмэл байдлаар зохицуулахтай холбоотойгоор хууль хэрэгжилтийн явцад хийсвэр, хоосон орон зайг бий болгож, хөдөлмөрлөж буй хэн нэгэн субъектын хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж буй явдал юм.

1. Хөдөлмөрийн харилцаа үүсэх үндэслэлийн хүрээнд,

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.4-т 4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй, 17.2-т ...хөдөлмөрлөх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэж хуульчлагдсан. Мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 23 дугаар зүйл 1 "Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй" гэж заагдсан. Нийгмийн харилцааг зохицуулахаар эрх бүхий байгууллагаас батлагдсан хууль², хуульчилсан актын зорилтоор тухайн

² Фредерик Бастиа "Хууль". УБ хот, 2001 он., 2 дахь талд. "Хууль бол хууль ёсны хамгаалалтанд багтах хувь хүмүүсийн эрхийн хамтын нийлбэр байгууламж мөн".



хууль тогтоомжийн үйлчлэх хүрээ нь тодорхойлогдох нь зүйн хэрэг юм. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль³-ийн зорилт нь хөдөлмөрийн гэрээ⁴-ний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг байдлыг хангахад оршино гэж томъёологдсон. Мөн түүнчлэн “Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс бусад өөр төрлийн гэрээ байгуулахыг хориглоно”/24.1/. Эндээс байнгын ажлын байр гэдэг нэр томъёоны тодорхойлолтыг гаргасны зэрэгцээ ажил олгогч нь ажил албан тушаалын жагсаалтыг гаргахдаа байнгын ба байнгын бус гэж нэмэлт тодруулга хийх шаардлага гарч ирнэ.

Харин байнгын бус ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс өөр төрлийн гэрээ байгуулж, байнгын ажлын байранд зөвхөн хөдөлмөрийн гэрээгээр иргэнийг авч ажиллуулах тухай ойлголт байхын зэрэгцээ хуульд заасан “хөдөлмөрийн контракт”-ыг ч бас хориглосон гэж үзэж болох юм.

Гэтэл Шинэчилсэн найруулга хийгдэж буй Хөдөлмөрийн тухай хуулийн зорилго нь:

1.1. Энэ хуулийн зорилго нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааны суурь хэм хэмжээг тогтоож, ажилтан ба ажил олгогч болон тэдгээрийн төлөөлөгчдийн

хоорондын хөдөлмөрийн харилцааны зохистой тэнцвэрт байдлыг дэмжихэд оршино. Мөн 4.1.5. “Хөдөлмөрийн гэрээ” гэж хөдөлмөр эрхлэлтийн харилцааны хүрээнд ажил олгогчийн удирдлага, хяналт дор хувь хүний ажиллах хүчийг хөлслөн ажил үүрэг гүйцэтгүүлэх, цалин хөлс олгох, хөдөлмөр эрхлэлтийн болон бусад нөхцөлийн талаар ажил олгогч, ажилтан хоорондоо харилцан тохиролцсон тохиролцоог;

Эндээс Шинэчилсэн найруулгын хүрээнд хуулийн зорилтоор хүрээг нь өргөжүүлсэн мэт боловч харилцаа үүсэх нь “Хөдөлмөрийн гэрээ”-ээр хязгаарлагдаж байгааг харж болох юм.⁵

Харин хөдөлмөрийн харилцааг бие даасан хуулиар зохицуулж ирсэн уламжлал⁶ буюу хуулиудын зорилтыг авч үзэхэд /хавсралт №1/⁸ хуулиудын зорилтууд нь тухайн нийгмийн онцлогтой холбоотойгоор гэрээний болон гэрээний бус ерөнхий байдлаар хөдөлмөрийн харилцааг зохицуулахаар хуульчлагджээ.

⁵ Н.Лүндэндорж “Jurisprudence”, УБ хот., 2011 он “Role of law буюу эрх зүйд захирагдах ёс зогсонги, царцанги зүйл биш”...нийгэм болоод хүний танин мэдэхүйн хөгжлийг дагаж байнаг хөгжил хөдөлгөөнд оршдог.

⁶ Монгол Улсын хөдөлмөрийн хуулиуд 2003 он, БНМАУ-ын хүчнээс үнэлэгчдийн хууль /1930 он/ 13 дахь талд, Хүчин үнэлэхүйн тухай хууль /1933 он/, 30 дахь талд, Хүчин үнэлэхүйн тухай хууль /1934 он/, 37 дахь талд, БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль /1941 он/, 50 дахь талд, БНМАУ-ын Хөдөлмөрийн хууль /1973 он/, 83 дахь талд, Хөдөлмөрийн хууль /1991 он/, 133 дахь талд

⁷ Хөдөлмөрийн хуулиудын зорилтуудыг он дараалал Хавсралт №1

⁸ Он оны хөдөлмөрийн хуулиудын зорилтод дүн шинжилгээ хийсэн болно.

³ www.legalinfo.mn /Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль /1999 он, нийтдээ 2016 оны байдлаар 13 удаа нэмэлт өөрчлөлт орсон/

⁴ www.legalinfo.mn /Ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон үүрэг бүхий бүлэг гэрээний нэг төрөл. ӨХ, Ажил гүйцэтгэх гэрээ ИХ 343, Хөлсөөр ажиллах гэрээ ИХ 359, Хөдөлмөрийн гэрээ ИХ 369/



Гадаадын зарим орны Хөдөлмөрийн хуулийн зорилтыг авч үзвэл, ОХУ-ын Хөдөлмөрийн тухай хууль, 2001 оны 12-р сарын 21-ний өдөр батлагдсан⁹ Нэгдүгээр зүйл. Энэхүү хуулийн зорилт нь иргэдийн хөдөлмөрлөх эрх, эрх чөлөө, хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бий болгох, ажилтан, ажил олгогчийн эрх, ашиг сонирхлыг төрөөс баталгаажуулахад оршино. Герман Улсын хөдөлмөрийн хууль¹⁰ ажил эрхлэлтийн гэрээний үндсэн дээр үүссэн харилцааг зохицуулахад оршдог. Чех Улсын Хөдөлмөрийн тухай хууль¹¹ Нэгдүгээр хэсэг, ажилтан ажил олгогчийн хооронд үүсэх хөдөлмөрийн болон үүргийн гүйцэтгэлийн харилцаа, хамтын гэрээ, хэрэгжилт ... холбоотой ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг тэдгээртэй холбогдох хариуцлагын харилцааг тус тус зохицуулахад оршино. БНХАУ-ын Хөдөлмөрийн тухай хууль¹² Нэгдүгээр зүйл. Энэхүү хуулийг хөдөлмөр эрхлэгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, социалист зах зээлд нийцсэн хөдөлмөрийн тогтолцоог бий болгож хамгаалах, нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд оршино. Хоёрдугаар зүйл. Энэхүү хууль нь БНХАУ-ын хилийн дотор үүссэн нэг талаас компани буюу ажил олгогч нөгөө талаас ажилтан

нарын хооронд үүссэн хөдөлмөрийн харилцааг зохицуулна.

Эндээс хөдөлмөрийн хуулийн зорилт нь ерөнхий байдлаар томъёологдсон байгааг харж болох юм. Энэ нь тухайн хуулийн үйлчлэх хүрээ нь өргөн агуулгаар илэрхийлэгдэх боломжтой гэж үзэж болно.

Монгол Улсын хувьд хөдөлмөрийн эрх зүйн харилцаа хувийн болон нийтийн эрх зүй, бусад хүрээнд ямар үндэслэлээр үүсэх вэ? гэдгийг нарийвчлан тодорхойлох нь чухал юм.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа юуг үндэслэн /гэрээний үндсэн дээр, гэрээний бус /амаар тохиролцох, ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээр/, сонгогдсоноор, томилогдсоноор ӨХ, батламж бичиг гардан авсанаар, тангараг өргөсөнөөр,..../, хаана /төрийн албанд, төрийн байгууллагад, хувийн хэвшилд, иргэдийн хооронд, малчид.../ үүсэж байгаагаас хамаараад хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд оролцогч субъектүүдийн хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах үндсэн нөхцөл нь бүрдэх юм. Өөрөөр хэлбэл,

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь:

- зөвхөн хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үүсдэг үү?
- хөдөлмөрийн гэрээгүйгээр тус харилцаа үүсдэг үү?
- иргэний эрх зүй дэх төсөөтэй гэрээгээр үүсэх боломжтой юу /

⁹ (<http://www.ilo.org/dyn/natlex/docs/WEBTEXT/60535/65252/E01RUS01.htm>)

¹⁰ Хөдөлмөрийн контрактын онол, практикийн зарим асуудал, 2006., Ё.Болормаа /магистрын ажил 32 дахь талд

¹¹ (http://www.mpsv.cz/files/clanky/3221/Labour_Code_2012.pdf)

¹² (http://www.china.org.cn/living_in_china/abc/2009-07/15/content_18140508.htm)



ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ/

- нэрлэгдээгүй гэрээний үндсэн дээр харилцаа үүсэх үү?
- томилогдсоноор үүсдэг үү?
- сонгогдсоноор үүсдэг үү?
- эд хөрөнгө, хөдөлмөрөө нэгтгэн ажиллаж буй талууд хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөхөөр тохиролцсоноор үүсдэг үү?
- захиргааны эрх зүй /Төрийн алба/, иргэний эрх зүйн харилцаатай холимог байдлаар хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсэх үү? зэрэг маргаантай асуудал байсаар байгаа нь тус хуулийн үйлчлэх хүрээг нэрлэгдсэн, нэг төрлийн гэрээгээр хязгаарласан хэрэг юм. Харилцааг гэрээгээр хязгаарласан нь өөр бусад байдлаар хөдөлмөрийн харилцаа үүсэх нөхцөл байдлыг хязгаарлаж чадахгүй нь хуурай хуулийн сургамж¹³-ыг илэрхийлсэн хэрэг гэж үзэж болохоор байна.

Эндээс хууль хэрэгжилтийн явцад хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан үүсэж¹⁴ шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо өмнөх жилүүдээс өссөн үзүүлэлттэй байна. Хөдөлмөрийн харилцаа үүссэн үндэслэлээс хамааран хэргийн зүйлчлэл нь талуудын /ажил олгогч, ажилтны/ эрх ашигт нөлөөлөх төдийгүй, ажилдаа эргүүлэн тогтоолгох, нийгмийн даатгал,

ээлжийн амралт, ажилгүйдлийн тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, учирсан гэм хорыг арилгуулах зэрэг үүргээс шалтгаалан зэрэг болоод сөрөг үр дагавар гардаг.¹⁵

Асуудлыг хөндвөл,

1. Тухайн хуулийн зорилтоор харилцааныхаа хүрээг тодорхойлох нь зөв үү эсвэл? "Хүний эрхийг зөвхөн гэмт хэрэгтэн, засаг хоёр л зөрчдөг"¹⁶ гэдгээс үзвэл батлагдсан хууль ямар байхаас харилцаанд оролцогчдын эрх, ашиг сонирхол хамаарна гэж үзэж болох юм.

- Хөдөлмөрийн гэрээ байгуулж харилцаа үүсээгүй тохиолдолд хөдөлмөрийн гэрээг хийсвэрлэж хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх,¹⁷ энэхүү УДШ-ийн холбогдох зохицуулалтыг нийтлэг зохицуулалт байдлаар хуульчлах нь зүйтэй юм.

- Нөгөөтэйгүүр хөдөлмөрийн хуулиар зохицуулагдаагүй харилцааг шүүхээс шийдвэрлэхгүй орхиж болох уу гэдэг асуудал нь Хөдөлмөрийн хуульд байна уу ..., эсвэл хууль хэрэглэгч субъектэд байна уу...

¹⁵ Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн байдал /хавсралт №2, 3/

¹⁶ Айн Рэнд "Капитализмыг өмөөрөх нь", УБ хот., 2005 он.

¹⁷ УДШ-ийн тогтоол 2006 он, №33 Ажил олгогч хөдөлмөрийн гэрээ байгуулахгүйгээр ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлсэн тохиолдолд тэдний хоорондох маргааныг Хөдөлмөрийн тухай хуулийг баримтлан шийдвэрлэх бөгөөд харин хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй нь ажилтны буруугаас болсон нь тогтоогдвол маргааныг Иргэний хуулийн /369 дүгээр зүйлийн 369.3., гэм хор, гэх мэт/ дагуу шийдвэрлэнэ.

¹³ Дэвид Бэргланд Нэгэн хичээлд багтаасан либертари үзэл, 2005 он., 167 дэх талд

¹⁴ <http://www.judoinstitute.mn/main/198--2017-1-.html>



Тэгвэл, гэрээг хийсвэрлэж харилцааг шийдвэрлэж болох эсэх нь тухайн харилцааны онцлог шинжээр¹⁸ илэрхийлэгдэж болох юм. Мөн Иргэний хуулийн 4.1-д Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. 4.2-д төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна гэдгээр тухайн хөдөлмөрийн маргаантай харилцааг шүүхээс шийдвэрлэхгүй орхиж болохгүй юм.

•Эндээс, жинхэнэ хөдөлмөрийн харилцаа гэж юу вэ...?, Ер нь хуулийн "Хууль тогтоомж"-ийн заалт нь ямар ач холбогдолтой вэ?¹⁹

¹⁸ Хөдөлмөрийн эрх зүйн харилцааны хөдөлмөрийн дотоод журам дагаж мөрдөх, ХХДХ-г мөрдлөг болгодог гэх мэт... байж болох юм.

¹⁹ 2 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж 2.1.Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2 дугаар зүйл. Иргэний хууль тогтоомж 2.1. Иргэний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.


2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хууль тогтоомж 2.1. Төрийн албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Хөдөлмөрийн хууль тогтоомжид байдаггүй тийм хуулийг хэрэглэх нь зөв үү

- Үндсэн хууль-Хөдөлмөрийн хууль
- Иргэний хууль - Хөдөлмөрийн хууль
- Төрийн албаны тухай хууль - Хөдөлмөрийн хууль тус хуулиар зохицуулагдаагүй


Хөдөлмөрийн харилцаанд Хөдөлмөрийн хуулийг хэрэглэнэ.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлийг хуулиар тодорхойлж, хуулийн системчлэлийг бий болгосноор хөдөлмөрлөх эрхийг хэрэгжүүлэх механизм бүрдэнэ.



Зарчим нь харилцааг бүхэлд нь хамарч үйлчлэх, зарчмын дагуу хууль хэрэгжих ёстой.

2. Хөдөлмөрийн харилцааг зохицуулах хууль тогтоомжийн үйлчлэл, зарчмыг үнэлэх асуудлын хүрээнд,





Хуульчилсан акт /Төвлөрсөн зохицуулалтын арга/

/УИХ-ын тогтоол, ЗГ-ын тогтоол, сайдын тушаал хэлбэрээр хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд нийтээр дагаж мөрдөхөөр батлагдсан дүрэм, журам, жагсаалт/

Хуульчилсан акт /Төвлөрсөн бус зохицуулалтын арга/

/Тухайн байгууллагад мөрдлөг болгохоор дээр дурьсан хууль, хуульчилсан актад нийцүүлэн гаргасан дүрэм, журам, жагсаалт, гэрээ/

Нийгмийн харилцаа өөрчлөгдөхийн хэрээр хөдөлмөрийн хууль тогтоомж нь өөрчлөгдөж боловсронгуй болсоор өнөөг хүрсэн.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцааг /1925, 1930, 1933, 1934, 1941, 1973, 1991, 1999/ онуудад батлагдсан хууль, хуульчилсан актуудаар зохицуулсаар ирсэн. Тус харилцааг зохицуулж буй хууль тогтоомж нь бусад салбартай харьцуулахад хуульчилсан акт ихтэй байдгаараа онцлог юм. Тухайлбал, Хөдөлмөрийн хууль 79.1-тэй холбоотойгоор ээлжийн амралт олгох заавар, ээлжийн амралт олгох журам хэрэглэгддэг. Энэ нь тухайн салбар эрх зүйн зохицуулах зүйлийн хүрээ өргөн, хуульчилсан актгүйгээр харилцааг зохицуулах боломж хомс

байдагтай холбоотой юм.

Монгол Улсад хөдөлмөрлөх харилцааг зохицуулж буй дагнасан хууль нь Хөдөлмөрийн тухай хууль мэт **/хэлбэрийн хувьд/** харагдах боловч хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбоотой харилцаа нь бусад хуулиудаар төрөлжсөн байдлаар, нарийвчлагдан зохицуулагдах байдлаар хуульчлагдсан²⁰ мөн түүнчлэн **Авлигын эсрэг хууль**,²¹ **Боловсролын хууль**,²² **Дипломат албаны тухай**,²³ Дээд боловсролын

²⁰ Төрийн албаны тухай хууль, Иргэний хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай....

²¹ 30.6.Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ээлжийн амралтын үндсэн хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд гүйцэтгэх ажил эрхэлсэн, түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажилласан 5 жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

²² 43.1.2 багш, ажиллагчдын ээлжийн үндсэн амралтын хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна. Хөдөлмөрийн онцлогийг харгалзан багшид ажлын 33, захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, хичээлийн зохицуулагч, нийгмийн ажилтан, арга зүйч, дадлагын болон байрны багш, цэцэрлэгийн туслах багшид ажлын 15 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно. Хөдөлмөрийн тухай хуулийн 79.5, 79.6-д заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан бусад нэмэгдэл амралт дээрх албан тушаалтанд хамаарахгүй;

²³ 22.2. Дипломат төлөөлөгчийн газарт ажиллагчид Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, холбогдох бусад хуульд заасан үндсэн болон нэмэгдэл амралтыг эдлэх бөгөөд цаг уурын хүнд нөхцөл, дайны байдал бүхий улсад ажиллах үедээ эхний 1-4 жилд ажлын 5, цаашид ажиллах 3 жил тутам ажлын 2 өдрийн нэмэгдэл амралт эдэлнэ. Мөн 231.3.Энэ хуулийн 231.1-д заасан ажил олгогч татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар



тухай²⁴, Жижиг, дунд үйлдвэрийн тухай²⁵ Захиргааны ерөнхий хууль²⁶ Иргэний бүртгэлийн тухай²⁷, ИХШХШТХ²⁸, Компанийн тухай²⁹ Прокурорын байгууллагын тухай³⁰, Тагнуулын байгууллагын тухай³¹, Татварын ерөнхий хууль³², Төмөр

албан тушаалын орон тоо цөөрсөн, хасагдсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 27.2.3, 27.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1-д заасны дагуу зохицуулна.

²⁴ 19.5.Дээд боловсролын сургалтын байгууллагад эчнээ, оройн хэлбэрээр суралцагчид ажлын газар нь улирлын болон төгсөлтийн шалгалт өгөх, дипломын ажил бичиж хамгаалахад зориулж цалинтай чөлөө олгоно.

²⁵ 5.1.1.контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;

5.1.2.контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн;

²⁶ 105.2.2.албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

²⁷ 29.1.14.Монгол Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэний;

²⁸ 82.1.2.хөдөлмөрийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан;

²⁹ 84.5.Компанийн эрх бүхий албан тушаалтан компанитай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд өөрөөр заагаагүй бол албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш гурван жилийн туршид энэ хуулийн 84.4.6-д заасан үүргийг хүлээнэ.

³⁰ 35.10.Прокурорын ээлжийн амралтын үндсэн хугацааг Хөдөлмөрийн хуулиар⁷, нэмэгдэл амралтыг Хөдөлмөрийн тухай хууль болон энэ хуулиар тус тус тогтооно. Прокуророор ажилласан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт эдэлнэ. 44.1.1.сануулах; 44.1.2.албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; 44.1.3.албан тушаал бууруулах; 44.1.4.ажлаас халах.

³¹ 23.1.Тагнуулын ажилтанд жил бүр ажлын 15 өдрийн амралт олгоно. 23.2.Тагнуулын ажилтанд төрийн алба хаасан 5 жил тутамд ажлын 2 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

³² 38.2.Татварын улсын байцаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, ажлын үр дүнгийн

замын тээврийн тухай хууль³³, Төр, сүм хийдийн харилцааны тухай³⁴, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай³⁵, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт³⁶, Хөрөнгө оруулалтын сангийн тухай³⁷, Цагдаагийн албаны тухай³⁸, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль³⁹, Шүүхийн захиргааны тухай⁴⁰, Эвлэрүүлэн зуучлалын тухай⁴¹....бусад

шагнал, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ.

³³ 30.2.1.сануулах; 30.2.2.үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; 30.2.3.төмөр замын хөдөлгөөний бус ажилд 1 жил хүртэл хугацаагаар шилжүүлэх; 30.2.4.ажлаас халах.

³⁴ 9.Сүм хийдэд гэрээгээр ажиллагсдын хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

³⁵ 19 дүгээр зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээ

³⁶ 17.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

³⁷ 21.2.5.хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулалтын санд ажилтан авч ажиллуулах;

³⁸ 77.5.Албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид ажлын үр дүнг харгалзан үндсэн цалингийнх нь 40 хүртэл хувиар урамшил олгоно. Мөн 81.4.1.сануулах; 81.4.2.албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; 81.4.3.албан тушаал бууруулах; 81.4.4.цагдаагийн цолыг бууруулах; 81.4.5.цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

³⁹ 18.2.Шүүгч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж болно. 37.1.2.зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах

⁴⁰ 30.2.Ёс зүйн шаардлагыг зөрчсөн шүүхийн захиргааны ажилтанд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл ногдуулна.

⁴¹ 31.1.Хөдөлмөрийн эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь ажил олгогч болон ажилтны хооронд гарсан хөдөлмөрийн



хуулиудыг авч үзэхэд,

1. хуулийн үйлчлэлийг сулруулсан,

Төрийн албаны тухай хууль, бусад хуульд тухайн хуулиар зохицуулагдаагүй хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбоотой харилцааг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна гэж заасан нь тус хуулийг нөхөн зохицуулалтын шинжтэй болгож байгаа байна.

2. үйлчлэх хүрээ нь тодорхойгүй,

Хийсвэрлэгдсэн гэрээ болон гэрээний бусаар харилцаа үүссэн тохиолдолд маргааныг шийдвэрлэхэд хууль хэрэглээний асуудалд хүндрэл үүсэх талтай.

3. хууль хоорондын уялдаа нь алдагдсан,

Хуулийн "Хууль тогтоомж"-ийн зохицуулалтын ач холбогдлыг үнэлэхтэй холбогдон үүсэх боломжтой.

4. давхардсан, өөр байдлаар хуульчлагдсан,

5. хуулийг нөхөн зохицуулсан шинжтэй.

Хөдөлмөрийн хуулийн институт, дэд институт, зүйл, заалт нь бусад хуулиудад давхардаж, өөр, өөр байдлаар хуульчлагдсан байгаа нь хөдөлмөрлөх харилцаатай холбоотой асуудлыг нэгдмэл байдлаар хуульчлаагүйгээс талуудад хуулиар олгогдсон боломж нөхцлийг эдлэх, хөдөлмөрийн эрх зүйн харилцааны хэрэгжилтийн явцад тушаал, захирамжын эрх зүйн үндэслэлийг оновчтой тодорхойлох, хууль хэрэглээний явцад нэгдмэл бус актын эрх зүйн сөрөг үр дагавар үүсгэх талтай. Энэ үр дагавар нь ямар байх бол гэдгээс үл хамааран "хууль байх ёстой" гэсэн үзэл давамгайлах болжээ. Хууль тогтоогчид энэ үзэлд туйлын сэтгэл ханамжтай байна. Хууль үр дүнгээ өгөх үү гэж тэд бараг асуудаггүй⁴² гэдгийн илрэл мэт.

Хөдөлмөрийн тухай хууль нь нийтийн эрх зүйн /төрийн алба/ хүрээнд нөхөн зохицуулсан шинжтэй үйлчилдэг.⁴³ Тиймээс хууль байгаа болохоор түүнийг дагаж мөрддөг биш, хууль байх хэрэгтэй учраас түүнийг бий болгодог.⁴⁴ Мөн түүнчлэн, хөдөлмөрийн эрх зүйн харилцаа юуг үндэслэн, хаана үүссэн, үүсээгүй байхаас хамаараад хэргийн зүйлчлэл хийх, хэргийн харъяаллыг тогтоох

⁴² Дэвид Бэргланд Нэгэн хичээлд багтаасан либертари үзэл, 2005 он., 191 дэхь талд

⁴³ www.legalinfo.mn 11.5.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно. 11.6.Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

⁴⁴ М.Хатанзориг. Эдийн засгийн эрх зүйн шинжлэх ухааны философи, 2015 он., 33 дахь талд



хандлагатай байна. Тухайлбал, үр дүнгийн гэрээг хөдөлмөрийн контракттай адилтган үзэж болно гэсэн зөвлөмж⁴⁵ нь нэгдмэл байдлаар зохицуулж чадахгүй байгаагийн илрэл байсан.

Хөдөлмөрийн харилцааг зохицуулахаар батлагдсан хуульчилсан акт нь хуулиасаа даруй 3 дахин их байхаар эмхэтгэгдсэн байдаг. Тиймээс судалгааны ажилдаа зөвхөн бусад хуулиудыг судалж, хөдөлмөрлөх харилцааг зохицуулсан байдлыг тойм байдлаар түүвэрлэсэн болно.

Хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэглэхэд зарчмыг үнэлэх асуудлын хувьд,

Эрх зүйн хувьд	Хувийн эрх зүйн хүрээнд	Нийтийн эрх зүйн хүрээнд	Хувийн эрх зүйн хүрээнд
Хуулиуд Зарчим	Хөдөлмөрийн тухай хууль ⁴⁶	Төрийн албаны тухай хууль	Иргэний хууль ⁴⁷
Суурь зарчим	✓ ⁴⁸	✓	✓
Салбарын зарчим	?	✓ ⁴⁹	✓ ⁵⁰
Салбар дундын	✓	✓	✓
Институтын зарчим	✓ /Хамтын гэрээ, цалин/	-	-

⁴⁵ www.legalinfo.mn

⁴⁶ 4.3.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

4.4.Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай болон бусад хуулиар зохицуулна.

⁴⁷ 4.2.Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна

⁴⁸ Монгол Улсын Үндсэн хууль 4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;

⁴⁹ 7 дугаар зүйл.Төрийн албаны зарчим

7.1.Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:

7.1.1.ард түмэнд үйлчлэх;

7.1.2.мэргэшсэн, тогтвортой байх;

7.1.3.улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх;

7.1.4.Монгол Улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжоор хангагдах;

7.1.5.төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;

7.1.6.ил тод байх;

7.1.7.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

7.1.8.захирах, захирагдах ёсыг баримтлах.

⁵⁰ 1.2.Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ.



Дээрхи хүснэгтээс хөдөлмөрийн хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа харилцаанд зарчмыг үнэлэх харилцан хамаарлыг харж болох юм. Өөрөөр хэлбэл,

- Хувийн эрх зүйн хүрээнд дангаар үйлчлэх хөдөлмөрийн хуулинд салбарын зарчим нь хуулинд томъёологдоогүй учраас Иргэний хуулийн зарчмыг шууд болон шууд бус байдлаар үнэлэх боломжтой.
- Харин нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн /Төрийн алба/ хөдөлмөрлөх харилцаанд мөрдлөг болгох зарчим нь Төрийн албаны тухай хуулинд хуульчлагдсаныг хувийн эрх зүйн хүрээнд дэх хөдөлмөрийн харилцаанд үнэлэх боломжтой юу?
- Хөдөлмөрийн хуулинд хуульчлагдсан институтын зарчмыг Төрийн албанд үнэлэх боломжтой

Эндээс,

Зарчим>хууль

Шинжлэх ухаан >зарчим

Сэтгэлгээ, үнэт зүйлс>шинжлэх ухаан гэсэн хамаарлаас зарчмын үнэ цэнийг харж болно.

Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд салбарын зарчмыг тодорхой томъёолж өгсөнөөр хөдөлмөрлөх эрхийг хангаж хэрэгжүүлэх суурь концепци нь болж өгөх юм.

Олон улс дахь хөдөлмөрлөх эрхийн хөгжлийн чиг хандлагыг авч үзвэл:

Хөдөлмөр эрхлэлттэй холбогдон дэлхий дахинд тулгамдаж буй асуудлуудын хүрээнд хөдөлмөрлөх эрхүүдийн дараах үндсэн чиг хандлагуудыг тодорхойлсон байна.⁵¹ Үүнд,

1. Хөдөлмөрлөх эрхийн олон улсын ач холбогдлыг олж тогтоох болон хөдөлмөрийн эрх зүйн цар хүрээг өргөжүүлэх

2. Хувь хүний цогц хөгжлийг баталгаажуулах болон хөдөлмөрлөх эрхийн агуулга дахь тэнцвэртэй, үнэ цэнэтэй байдал

3. Ажилчдын хөдөлмөрлөх, хөрвөх чадварын талаарх “улс үндэстний дотор” болон “үндэстэн дамнасан” хөдөлмөрийн харилцааны зүйл заалтууд хангагдсан байдал

4. Хөдөлмөрийн харилцааны хууль эрх зүй болон хөдөлмөрлөх эрхийн хамгаалалт хоёрын нэгдэл дэх уян хатан байдал /ялгавартай байдал болон бодьгалчилал/

5. Нийгмийн түншлэлийн талаарх өргөн хүрээнд хувь хүний болон хамт олны хөдөлмөрлөх эрхүүдийн нийцлийг хангах.

6.Хөдөлмөрийн эрхийн талаарх олон улсын стандартуудын тэргүүлэх асуудлууд

Дээрхи хандлагуудыг ч хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгыг хийхэд анхаарч үзэж болох талтай.

⁵¹ Lushnikov Andrey Mikhailovich, Mediterranean Journal of Social Sciences MCSER Publishing, Rome-Italy Vol 5 No 24 November 2014., "Trends in the Development of Labour Rights in the Beginning of the XXI Century"



Дүгнэлт, санал

Эхний асуудлын хүрээнд

1. Хөдөлмөрийн тухай хуулийн үйлчлэх хүрээг тодорхой болгох, /Хуулийн зорилтыг тодорхой гэрээгээр хязгаарлахгүйгээр ерөнхий байдлаар томъёолон, гадаад орнуудын зохицуулалтуудыг судалж, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр, өөрийн орны онцлогт нийцүүлэн шинэчлэн найруулах/

2. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлийг тусгайлан хуульчлах /жагсаалт болгон/ Тухайлбал, дараах асуудалд хариулт өгөхөөр байж болох юм.

Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа нь:

- зөвхөн хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үүсдэг үү?
- хөдөлмөрийн гэрээгүйгээр тус харилцаа үүсдэг үү?
- иргэний эрх зүй дэх төсөөтэй гэрээгээр үүсэх боломжтой юу /ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ/
- нэрлэгдээгүй гэрээний үндсэн дээр харилцаа үүсэх үү? /менежментийн гэрээ, зөвлөхөөр ажиллуулах гэрээ/
- томилогдсоноор үүсдэг үү? /тангараг өргөснөөр/
- сонгогдсоноор үүсдэг үү, /санал асуулгаар/
- эд хөрөнгө, хөдөлмөрөө нэгтгэн ажиллаж буй талууд хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөхөөр тохиролцсоноор

үүсдэг үү?

- захиргааны эрх зүй /Төрийн алба/, иргэний эрх зүйн харилцаатай холимог байдлаар,

3. Хуулийн “Хууль тогтоомж” хэсгийн ач холбогдлыг цаашид онолын үндэслэлтэйгээр үнэлэх шаардлагатай байна. ӨХ, практикт хөдөлмөрийн маргааны шийдвэрлэхдээ Үндсэн хууль нь хөдөлмөрийн хуулийг, Иргэний хууль нь хөдөлмөрийн хуулийг, хөдөлмөрийн хууль нь төрийн албаны тухай хууль, бусад хуулийг нөхөн зохицуулсан шинжтэй байдал үүсэж байна.

- Үндсэн хууль-Хөдөлмөрийн хууль
- Иргэний хууль – Хөдөлмөрийн хууль
- Төрийн албаны тухай хууль – Хөдөлмөрийн хууль тус хуулиар зохицуулагдаагүй

Хөдөлмөрийн харилцаанд Хөдөлмөрийн хуулийг хэрэглэнэ.

Хоёрдугаар асуудлын хүрээнд,

1. Хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хуулиудын уялдаа холбоог хангах нь чухал. Хөдөлмөрийн тухай хуулиас гадна хөдөлмөрлөх харилцааг нийтлэг байдлаар зохицуулж буй хуулиуд, бусад салбарын хуулиудад хөдөлмөрийн тухай хуульд зааснаас өөрөөр, давхардсан байдлаар гэх мэт хуульчилсан байдлыг системийг нь алдагдуулахгүйгээр уялдаат байдлыг хангаж өгөх нь тухайн нийгмийн харилцааг зохицуулахад нэн чухал үүрэг гүйцэтгэнэ.



Жишээ нь, харилцаа үүсэх үндэслэл, сахилгын шийтгэлийн хэлбэрүүд, цалин хөлсний нэмэгдэл, ээлжийн амралтын нэмэгдэл амралтын хугацаа гэх мэт.

2. Хуулийг дагаж гарсан хуульчилсан актыг хуультай нь уялдуулж, тоог цөөрүүлэх бодлого баримтлах

3. Хөдөлмөрийн хуулиар тухайн салбарын зарчмыг тодорхойлж өгөх шаардлагатай. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл, мөрдлөг болгох зарчим нь тодорхой байх нь⁵² хөдөлмөрлөх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангаж хамгаалахад суурь нь болж өгөх юм.

4. Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгад эрх зүйн бүл, дотоодын болон гадаадын эрдэмтдийн онол, хандлагыг авч үзэх нь чухал.

⁵² С.Нарангэрэл "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо", УБ хот. 2001 он 14 дэхь талд, "Хүний өрнөн хөгжиж байгаа хувь чанараас эрх зүйд тавьж байгаа хамгийн жинтэй шаардлагуудын нэг бол эрх зүйн хэм хэмжээ тодорхой байх түлхүү шаардлага мөн"



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХҮНД СУРТАЛ БА ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ



Ц.АМАРСАНАА

Шихихутуг ИС-ийн Төр,
захиргааны эрх зүйн тэнхимийн багш,
хууль зүйн ухааны докторант

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн¹ гэж заасан. Ардчилсан ёсны зарчмын гол агуулга нь ил тод², нээлттэй, хүртээмжтэй байх

¹ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл /1992/ №1

² Нарангэрэл.С. Эрх зүйн эх толь бичиг, нийгэмд ач холбогдолтой процедур ба үйл явцыг /төлөөлөгчийн ба гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, шүүх, нутгийн өөрийн удирдлагын байгууллага, холбогдох байгууллагыг сонгох буюу бүрдүүлэх журам, хуулийн төслийн хэлэлцүүлэх,

зарчмуудыг өөртөө багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Энэ утгаараа төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа ил тод нээлттэй, хүртээмжтэй байх учиртай.

Сүүлийн үед хийгдсэн судалгаануудаас үзэхэд “хүнд суртал” гэх ойлголтыг төрийн захиргааны байгууллагатай холбон тайлбарлах хандлага түгээмэл ажиглагдах болсон. Төрийн байгууллагаас иргэдтэй харилцах харилцааны явцад хүнд суртал үүсэж байна³ гэх судалгааг хийжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т⁴ заасны “Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэж заасны дагуу төрийн захиргааны байгууллагын албан тушаалтнууд иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.

төрийн бус байгууллагын үйл ажиллагаа зэрэг/ дээд зэргээр нээлттэй байлгах ба тэдгээрийн талаар хүн амд арган мэдээлэхийг тэмдэглэсэн эрх зүйн ерөнхий нэр томъёо.УБ.,2008. Адмон 227 дах тал.

³ Солонго.Д хамтын бүтээл. Төрийн захиргааны байгууллага дахь хүнд суртал.Монгол улсын ерөнхийлөгчийн тамгын газар. Хүний эрхийн Үндэсний Комиссоос тухайн сэдвээр судалгаа хийлгэсэн. Судалгааны тайлан.УБ., 2008. 9 дэх тал.

⁴ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл.1992, №1



Төрийн захиргааны байгууллага дахь хүнд суртал хүний эрхийг⁵ хэрхэн зөрчиж, иргэдэд хүндрэл чирэгдэл учруулж буй байдлыг төрийн захиргааны байгууллагын хууль, тогтоомж, үйл ажиллагааны явцад үүсэж буй хүнд суртал, чирэгдлийн талаар судлан бичиж, хүний үндсэн эрхийг хамгаалах, төрийн захиргааны байгууллага дахь хүнд сурталыг буруулах арга замыг эрх зүйн зохицуулалтын хүрээнд тодорхойлон, судалгааны үндэслэлд тулгуурлан дүгнэлт хийж тодорхой санал дэвшүүлэхийг зорьж бичсэн болно.

Энэхүү судалгааны ажлыг норматив⁶, баримт бичгийн, дискритив⁷, харьцуулалын арга зүйг ашигласан болно.

1. Хүнд суртал, түүний шалтгаан, уг сурвалж.

Хүнд суртал гэдэг нь "Бюрократизм" /Bureuacrat/ гэдэг үгний оновчтой бус орчуулга юм. Энэ нь Францаар "бюро" /bureau/ буюу "бичгийн ширээ" "крати" /cratie/ хэмээх

⁵ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7 дугаар зүйл. "...Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй...", Нэгдсэн Үндэсний Байгууллагын ерөнхий Ассамблейн 217 АIII тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26 дугаар зүйл зааснаар "...Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиас тэгш хамгаалуулах эрхтэй..." энэ пактад Монгол улс 1974 онд нэгдсэн.

⁶ Нормативизм ...байх ёстой зүйлийн хийсвэрлэн томъёолсон хэлбэржсэн байдлын тусгагдахуун..., Баярсайхан.Д. "Эрх зүйн онол". УБ., 2010. Экимто. 233 дахь тал.

⁷ Байгаа зүйлийн хүрээнд судлах арга.

төгсгөлөөс бүрдэх /грекв. Kratos буюу засаглал, эрх мэдэл гэсэн үгнээс үүдэлтэй/ "захиргааны засаглал" гэсэн утгатай үг⁸. Нэг төрлийн, бодитой дүрэм журмын дагуу үйл ажиллагаа явуулдаг, пирамид хэлбэрийн шатлан захирах ёсны зохион байгуулалттай албан тушаалтнуудын мэргэжлийн корпус⁹. Төрийн захиргааны мөн чанар буюу бюрократ тогтолцоо нь XIX, XX зууны эхээр байгууллагуудад бюрократ арга барил хөгжиж байгааг Германы социологич Макс Вебер¹⁰ судалж байв. Макс Вебер "бюрократ"-г хууль ёсны засаглалын рациональ хэлбэр хэмээн эерэг байдлаар тодорхойлсон байдаг. Учир нь бусад хэмжээгүй эрхт засаглалыг түшмэдийн засаглалын үед хуулийг баримтлах ёстой тул хэн нэгнийг дээгүүр эсхүл доогуур үзэх зэргээр дураар авирлах явдлыг зогсоох боломжтой". Макс Вебер энэхүү тогтолцоог зохион байгуулалтын хамгийн дээд идеал

⁸ Солонго.Д. Хамтын бүтээл. Төрийн захиргааны байгууллага дахь хүнд суртал. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар. Хүний Эрхийн Үндэсний Комиссоос тухайн сэдвээр судалгаа хийлгэсэн. Судалгааны тайлан. УБ., 2008

⁹ Britannica. нэвтэрхий толь. "Хүнд суртал" гэх үгийн хайлт. 3718 дахь тал.

¹⁰ Тэрээр 1913 оны өөрийн социологийн гол бүтээл болох "Эдийн засгийн ба нийгэм" гэх нэртэй бүтээлээ бичсэн бөгөөд тус бүтээлд /1. Рациональ, ухаалаг, зохистой/ буюу хуулар олгогдсон эрх мэдэл, албан ёсоор бичгээр гаргасан эрх зүйд тулгуурладаг. Энэ эрх зүйг бүх иргэд төдийгүй байгууллагын шатлалын янз бүрийн түвшинд эрх мэдлээ хэрэгжүүлж байгаа удирдах ажилтнууд ч дагаж мөрдөх ёстой. /2 Уламжлагдсан эрх мэдэл, 3 Харисматик эрх мэдэл гэж ангилжээ. Мөн эдгээр эрхүүд нь амьдрал дээр дангаар оршдоггүй харин холимог хэлбэрээр оршин байдаг гэжээ/ Батсүх.Ш. Макс Вебер ба бюрократ онол. Төрийн захиргаа сэтгүүл. 2002 №1. 18 дахь тал.

¹¹ On Weber: Watson, Tony. J. 1980. Sociology Work and Industry. Routledge.



хэлбэр гэж үзсэн.

Бюрократ тогтолцоотой байгууллага дараах долоон зарчмыг удирдлага болгодог гэж үзжээ. Үүнд:

1. Албан ажил байнгын үргэлжлэн явагддаг.

2. Үйл ажиллагаа дүрэм журмын дагуу хязгаарлагдмал байна.

3. Албан хаагчийн хариуцлага ба эрх мэдэл дээрээс буусан босоо хяналт, хариуцлагын тогтолцоотой байна.

4. Албан хаагч ажил гүйцэтгэх нөөцөө үл өмчлөх ба зөвхөн албан үүрэг гүйцэтгэхдээ хэрэглэнэ.

5. Албан ба хувийн ажил болон орлого хатуу зааглагдсан байна

6. Албан өрөө, ажлын байр өмчлөгдөж, өв залгамжлагдаж, худалдагдахгүй

7. Албан ажил, бичиг хэрэг хөтлөгдөнө гэсэн хэдий ч бюрократ тогтолцоо сонгодог хэлбэрээр амьдрал дээр хэрэгжиж чадаагүй. Эргээд сөрөг олон үр дагаврыг бий болгосон.

Макс Веберээс гадна хүнд суртлын оршин тогтнох дүрмийг Сэр Антони Жей дараах байдлаар тусгасан байна¹².

- Хариуцлагыг тарааж оногдуул. Аливаа буруу шийдвэрийн хариуцлагыг танаас нэхэхгүйн тулд нэгээс илүү хүн, эсхүл том хороогоор гаргуулах хэрэгтэй.

- Өргөн хүрээнд зөвлөлд. Аливаа зүйлийн гадуур үлдсэн хамтран ажиллагсад яамд, гадны бусад байгууллагаас ихэнхи эсэргүүцэл ирдэг тул тэднийг оролцуулах хэрэгтэй.

- Нууцлан чандал.

Өөрийн хариуцдаг бүхий л үйл ажиллагааг хөшүүн дүрэм журамд захируул.

- Буруутгах магадлалтай нөхцөл байдалд, бүх зүйлийг цаасан дээр буулгах

- Эрсдлээс зайлсхийх

- Аливаа өөрчлөлт, шинэ санаачлага, яарах байдлаас зайлхийх.

Монгол улс дахь хүнд суртлын үүсэл.

Монголчуудын хувьд бюрократын тухай ойлголт бол цоо шинэ зүйл биш. Хаант төрийг шүтэх үзэл ноёолж байсан. Хүлцэнгүй номхон байхыг сургадаг шашин өөрөө хамгийн бюрократ шинжтэй¹³. Коммунист буюу эрх баригчдыг шүтэх үзэл бол энэ ёс тохирдог. Карл Марксын тодорхойлж байснаар "Төр бол нэг ангиас нөгөө ангиа дарангуйлах машин" болж анги давхаргаар ялгаж, үзэл суртлаар нь хүмүүсээ ялгаварлан хэлмэгдүүлж байсан.

Ардчилсан үзэл санаанд хүн бүхэн тэгш эрхтэй бол бюрократ ёсонд зэрэг дэвийн ялгаа, захиран тушаах ёс гол

¹² 199 оны 6 дугаар сарын 7-нд Daily Telegraph 168 дах талаас дэлгэрэнгүй үзнэ үү.

¹³ Ганхуяг.Д."Монгол менталитет". Gankhuyag.wordpress.com/2008/01/25/das



байдаг.¹⁴ Ардчилсан ёс¹⁵ нь иргэдийг төрийн шийдвэр гаргахад өргөнөөр ороцуулахад чиглэдэг бюрократ ёсоор олон нийтийн үзэл бодлоос илүү даргын тушаал заавар илүүтэй байдаг. 1990 оноос хойш шинэ нийгэмд монголчууд захиргааны засаглал нь хүнд суртлыг бий болжээ. Энэ нь улмаар захиргааны байгууллага, албан тушаалтнаас¹⁶ гаргаж буй эс

үйлдэхүй¹⁷ хамааран энэхүү нөхцөл бүрдэж байна.

Хүнд суртлын илрэх хоёр шалтгаантай гэж үздэг¹⁸. Үүнд:

1. Хүнээс буюу төрийн албан хаагчдаас хамаарсан. /доороос гаргасан санал гомдол, шүүмжлэлийг дарах, олон шат дамжлага буй болгож тэдгээрт алба хааж буй түшмэдүүд нь идэвхигүй дамжуулагчийн үүрэг гүйцэтгэх, олон дарга бий болох, албан хаагчид нь шүүмжлэлийн үр дагвараас болгоомжлох/
2. Хууль тогтоомж, дүрэм, журмаас хамаарсан /голдуу хориглох хандлагатай олон тооны дүрэм, журам, тогтоол гаргах, дүрэм, журамд заагаагүй л бол ямар ч дэвшилттэй асуудал, санал санаачлагыг үл дэмжих гэх мэт зүйлсээс хүнд суртал гэх ойголт гарч байна/

¹⁴ Denhard.R."Public administration: An action Orientation"USA,2006.page 19

¹⁵ Хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хуульчлан хамгаалж, төрийн эрх мэдлийг хуваарилж, иргэний чөлөөт сонгууль, иргэнлэг ёс, эрх зүйт төр, нийгмийн тэгш эрх, шударга ёсыг тогтоон бэхжүүлсэн байдал, хүн, нийгмийн хөгжлийн эрхэм дээд сонголт, эрх зүйт ёсны дэг журам, зарчим, үнэт зүйлс зэрэг багтана.Төрболд.Б. Эхлэл:УБ., 2010. 36 дахь тал

¹⁶ Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйл. Захиргааны байгууллага

5.1.Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно:

5.1.1.төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;

5.1.2.хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага;

5.1.3.захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд;

5.1.4.үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа;

5.1.5.нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага.

5.2.Захиргааны байгууллага байнгын бус, нэг удаагийн шинжтэй асуудлыг шийдвэрлэж зохицуулахаар байгуулагдаж болох бөгөөд татан буугдсан тохиолдолд түүнийг байгуулсан, томилсон эрх бүхий этгээд эрх зүйн үр дагаврыг хариуцна.

5.3.Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх, прокуророос хуульд заасан эрх мэдэл буюу

хууль тогтоох, гэмт хэрэг, эрх зүйн маргаан хянан шийдвэрлэх онцгой бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрээс бусад захиргааны чиг үүрэг, шийдвэртэй нь холбогдуулан уг байгууллагыг захиргааны байгууллагад тооцно.

5.4.Нийтийн эрх зүйн асуудлаар бие даан, өөрийн нэрийн өмнөөс дангаар захиргааны шийдвэр гаргах бүрэн эрх хуулиар тусгайлан олгогдсон албан тушаалтныг захиргааны байгууллага гэж үзнэ.

¹⁷ Захиргааны ерөнхий хуулийн 37.3. Эс үйлдэхүй гэж иргэн, хуулийн этгээдээс эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалуулахаар гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүргээ захиргааны байгууллага хуульд заасан хугацаанд биелүүлээгүй, эсхүл шийдвэрлэхгүй орхигдуулсныг ойлгоно.

¹⁸ Сангарагчаа.Ч.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах нь хүнд суртал авлигатай тэмцэх нэн тэргүүний арга хэмжээ мөн. УБ.,2008. "Хүний эрх ба Хүнд суртал" үндэсний чуулган. 2 дах тал.



2. Хүний эрх ба хүнд суртлын эрх зүйн асуудал

Хүний эрхийн тухай ойлголт нь хүний төртэй харьцах, түүний эдийн засгийн нийгэмшлийн, улс төрийн соёлын хүрээн дэх боломж ба шаардлагын эрх зүйн байдлыг тодорхойлсон ухагдахуун¹⁹. Мөн түүхэн эх сурвалжуудын хувьд хүний эрхийг хамгаалахад Английн 1266 оны Хүний эрхийн билль, Америкийн Нэгдсэн Улсын 1776 оны Тусгаар тогтнолын тунхаглал, Францын 1789 оны Хүний ба иргэний эрх чөлөөний тунхаглал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт 1966 он, Европын холбооны Үндсэн эрхийн тунхаг бичиг, Европын хүний эрхийн конвенц, Европын нийгмийн харт гэх зэрэг олон баримт бичгүүдэд хүний эрхийн суурь зарчмуудыг хамгаалсан билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх үүрэгтэй. Мөн хуулийн 14-т "...Монгол улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх..." гэж заасан. Энэхүү эрхийн хамгаалалт

нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар зохицуулжээ.

Хууль тогтоомж, дүрэм, журмаас хамаарсан хүнд суртлын²⁰ шалтгаан:

1. Хууль тогтоомжид заасан төлбөр хураамж
2. Зөвшөөрөл, лиценз олгох

Төрийн албаны зөвлөлөөс төрийн захиргааны албан хаагчдыг сонгон шалгаруулж авдаг хэдий ч ёс суртахуун, зан харилцааны хувьд сул, төрийн албан хаагчийн шаардлагыг хангаагүй ажилтнууд их байна. Иргэдийн дунд явуулсан судалгааны үр дүнгээс харахад 2.5% төрийн албан хаагчдын зан харилцаа хангалттай хэмжээнд гэсэн бол 41.4% нь боломжийн 54.3% нь муу, 1.8% нь хэлж мэдэхгүй байна гэсэн хариултыг өгсөн²¹.

Англи улсын 1996 оны Төрийн албаны тухай хуульд зааснаар төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг дараах байдлаар зохицуулжээ.

1. Төрийн албан хаагч албан тушаал болон үүрэгт ажлаа гүйцэтгэж байх үедээ авсан мэдээллийг өөрийн болон бусдын хувийн ашиг сонирхолд нийцүүлэх замаар гуйвуулан ашиглаж болохгүй.
2. Удирдлага хооронд танилцуулсан эсхүл бусдаас нууцаар

²⁰ Хавсралт №1-ээс харна уу

²¹ Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалтын газраас хийсэн "Хүнд суртлын индекс 2015". УБ.,2015.8 дах тал.

¹⁹ Нарангэрэл.С. "Эрх зүйн эх толь бичиг". УБ.,2009. 11 дэх тал.



хүлээж авсан мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусдад мэдээллэхийг хориглоно.

3. Сайд, хууль тогтоох байгууллагын бодлого, шийдвэр үйл ажиллагааг бүтэлгүй болгох тэдэнд нөлөөлөх зорилгоор сайд, хууль тогтоох байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу арга хэмжээ авахаас татгалзаж болохгүй.

ХБНГУ-ын хувьд: төрийн албан хаагчид олон нийтийн эрх зүйт төрийн алба болон захиргааны байгууллагын өмнө үнэнч байх үүргийг хүлээдэг.²² Герман улсын төрийн зохион байгуулалтын бүтцээс шалтгаалан захиргааны байгууллагууд нь орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, холбоо, муж улсууд анхан шатны шүүх нэгжүүд юм. Төрийн албан хаагчдыг насан туршид нь төрийн албанд томилдог хэлбэр нь хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын гол арга хэлбэр болдог байна.

²² Төрийн албан хаагчдийн хөдөлмөрийн харилцаа нь түүхэн хөгжил талаас нь авч үзвэл: Хаадын зарцаас төрийн зарц болсон 18-р зууны үеэс эхлэн тавигдсан. Ингэснээр тухайн үед хүчин зүтгэж байсан албатуудын үүрэг "төрийн төлөө" болон өргөжсөн. Ийнхүү олны тусын төлөө ажиллах болсон эрх зүйн энэ хамгаалалт нь хожмоо улс төрийн намууд, парламент, засгийн газрын өмнөх болон өргөжих төрийн албан хаагчдын онцгой статус олноо хүлээн зөвшөөрөгдөх болсон. 19-р зуунд захиргааны алба илүү мэргэшиж төрийн албаны орчин үеийн үндэс тавигдаж эхэлсэн. Хаант засаглал төгсгөл болсны дараа 1919 оноо батлагдсан Ваймарийн эзэнт улсын Үндсэн хуульд улс төрийн намуудаас хараат бус төрийн алба, иргэдийн эрхийн талаар 130-р зүйлд "Төрийн албан хаагч нар бол нийгмийн зарц нар мөн. Аль нэг намын зарц биш. Бүх төрлийн албан хаагч нар улс төрийн эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх эрхтэй" гэж заасан байдаг.

Японы төрийн албаны системд насан туршын байх, дэвшүүлэх шалгууртай байх, нэр хүндтэй байх, цалин тодорхой байх, сургалтын тогтолцоотой байх гэсэн тодорхой стандартуудыг тусгасан байдаг²³.

Дүгнэлт /санал/

Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон бусад хуулиудад заасан хүний үндсэн эрхийг хамгаалах, хүнд суртал, олон шат дамжлагыг багасгах, бууруулах арга замыг хууль, эрх зүйн актуудад тодорхой түвшинд зохицуулалт бий боловч үр дүн эерэг гарахгүй байна.

Иймд хүнд сурталыг бууруулахад судлаачийн зүгээс дараах саналыг тусгасан болно.

1. Төрийн албанд сонгон шалгаруулж авахдаа тухайн хүн хэнд хэрхэн үйлчлэх ёстойг чиг үүргийнх дагуу үнэн бодит, шударга сонгон шалгаруулах, цаашлаад зан харилцаа, ёс суртахууны байдлыг нь харгалзан үзэх. Япон болон Герман улсын төрийн албаны жишиг болгон хуульчлах.
2. Хууль тогтоомж, дүрэм журам, тогтоол шийдвэрийг үндэслэлтэйгээр баталж, мөрдүүлэх. Хууль тогтоомж нь нийгмийн харилцааг зохицуулах гол хөшүүрэг хэдий ч хэтэрхий

²³ Бат-Эрдэнэ.С. Төрийн албанд иргэнийг сонгон шалгаруулж авах Япон улсын туршлага ба монгол улсын төрийн албаны нөхцөл байдлын зарим асуудал". УБ., 2013 он



- олон, адилхан хэм хэмжээг зохицуулсан зохицуулалтууд нь давхардаж ихсэх тусам иргэдийг тэр хэмжээгээр хүндрэл учруулна.
3. Хууль болон хуулийн дэд актуудын харилцан уялдаагүй зөрчилтэй байдлаас болж иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөж, захиргаа иргэдийн хоорондын харилцаанд хүндрэл учирч байна. Тухайлбал шинээр батлагдсан хуультай уялдуулан холбогдох дүрэм, журмуудыг өөрчилж гаргах шаардлагатай байна.
4. Төрийн хяналт шалгалтын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах. Улсын байцаагч эрх хэмжээ үүргийг нарийвчлан тогтоох
5. Төрийн албан байгууллагуудын хүнд сурталыг багасгах үүднээс өөрийн үйл ажиллагааны талаар иргэдээс санал авах. Захиргааны ерөнхий хуульд заасан сонсгох ажиллагааг явуулах.
6. Төрийн албаны хууль болон холбогдох хуулиудад төрийн захиргааны албан хаагчийн үйл ажиллагааны эрх, үүрэг хэрэгжих эрх зүйн орчинд тодорхой хугацаа, процедурыг тогтоож өгөх.



ЯЛЫН ФИЛОСОФИ БА ЭРХИЙГ ҮЛ ҮНЭЛЭХ ҮЗЭЛ

/Албадлагын арга хэмжээний хүрээнд/



О.БАТСУХ

*Шихихутуг ИС-ийн Эрүүгийн эрх зүйн
тэнхимийн багш, хууль зүйн магистр*

Оршил

Түүхийн аль ч цаг үед ял шийтгэл нь нэг зорилго, нэг утга санааг илэрхийлж байгаагүй бөгөөд нийгмийн байдал, ард иргэдийн сэтгэлгээ, түүхэн уламжлал, хөгжил зэргээс хамааралтайгаар улс орон бүр өөрсдийн гэсэн онцлог ял шийтгэлийн арга хэмжээтэй байсан. 2002 оны Эрүүгийн хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2017 онд тус тус баталсан. Ийнхүү эрүүгийн хуулийг

шинэчлэн баталсантай холбоотойгоор эрүүгийн зарим институтуудын онол, шинжлэх ухааны үндэслэл нь нэлээдгүй өөрчлөгдсөн институт бол албадлагын арга хэмжээ юм. Тиймд, албадлагын арга хэмжээний тухай ойлголт, онцлогыг судалж, гадаадын зарим улс орны эрх зүйн зохицуулалттай харьцуулахыг энэхүү судалгаагаараа зорьсон билээ. **Нэг.** Албадлагын арга хэмжээний тухай ойлголт, онцлог Ялын ойлголт, зорилго, мөн чанар, төрөл, хэмжээ хязгаар, ял ногдуулах болон эдлүүлэх асуудлыг судалдаг хоёр шинжлэх ухаан байдаг бөгөөд энэ нь Пенологи¹, Пенитенциар шинжлэх ухаан юм. МЭӨ IV – III зуунд Эртний Египэт, Вавилон, Энэтхэгт ялын тухай үзэл сургааль анх бий болсон бөгөөд ялын үүсэл, оршин байх үндэслэлийг ял, шашин хоёрын хоорондын уялдаа холбооны хүрээнд тайлбарладаг байжээ. 1950-аад он хүртэл хүчтэй нөлөөтэй байсан ялын цээрлүүлэх үзэл баримтлал 1960-аад оноос эхлэн хүчтэй шүүмжлэлтэй тулгарсан бөгөөд гэмт этгээдийг нийгэмшүүлэх зорилго бүхий эрүүгийн эрх зүйн шинэлэг хандлагыг бий болгоход хүргэсэн байна. Энэ нь гэмт этгээдийг хүмүүжүүлэх, засахад үндэслэгдэх бөгөөд философич Ж.Ж.Руссогийн "Эмиль" хэмээх суут бүтээлд хамгийн

¹ Ял шийтгэл, түүний зорилго, арга хэрэгслийг пенологи гэж нэрлэхийг XIX зууны дунд үед Америкийн хуульч Ф.Либер санаачилжээ.



тод илрэлээ олсон байдаг. Түүний үзэж байгаагаар тухайн этгээдэд ногдуулсан ял шийтгэл бус харин түүнийг нийгмийн амьдралд хөлөө олоход нь төрөөс үзүүлж буй дэмжлэг байх ажээ. Эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх гол хэлбэр бол ял болон албадлагын арга хэмжээ юм². Үүнтэй холбогдуулан профессор Г.Совд агсан "Эрүүгийн хариуцлага нь эрүүгийн хуулиар тогтоосон ялын болон ялын бус албадлагын хэлбэртэй байна. Ялын бус эрүүгийн хариуцлага нь уг этгээдийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд шүүх дүгнэлт өгсөн боловч биеэр болон эд хөрөнгийн талаар эрхийн ямар нэг хязгаарлалтыг шууд хүлээдэггүй боловч эрүүгийн хариуцлага хүлээсний үр дагавар нь тодорхой хугацаанд тулгагдахад бэлэн байдаг онцлогтой³" гэжээ. Энд зохиогч ялын бус эрүүгийн хариуцлага хүлээлгэх үед гэмт хэрэг үйлдсэн этгээд биеэр болон эд хөрөнгийн ямар нэг хязгаарлалт хүлээхгүй гэснээс үзэхэд энд зөвхөн эмнэлгийн болон хүмүүжлийн шинжтэй албадлагын арга хэмжээнээс бусад тухайлбал, насанд хүрээгүй этгээд, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах хэмжээнүүдийг хамааруулсан нь тодорхой байна. Эрүүгийн хариуцлагыг хэрэгжүүлэх нэг хэлбэр бол эмнэлгийн болон

хүмүүжлийн шинжтэй албадлагын арга хэмжээ юм⁴. Албадлагын арга хэмжээ нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон этгээдэд хүлээлгэх ялын бус шинжтэй Эрүүгийн хуульд заасан төрийн нөлөөллийн чанартай албадлага юм⁵. Энэхүү арга хэмжээг 2002 оны Эрүүгийн хуульд "Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ" гэж томъёолон хуульчилж байсан. 2015 оны Эрүүгийн /шинэчлэн найруулсан/ хууль батлагдахаас өмнө манай улсын эрдэмтэд албадлагын арга хэмжээг "Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ" гэх утгаар ойлгон "эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ" гэсэн хоёр төрөлтэй гэж үзэж байсан юм⁶. Албадлагын арга хэмжээ нь ялаас ялгаатай бие даасан ойлголт хэдий ч ялтай харилцан нөхцөлдсөн, уялдаа холбоо бүхий ойлголт байна⁷. Албадлагын арга хэмжээ нь ялаас дараах шинжээрээ ялгагдана:

⁴ С.Жанцан. "Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол /ялын тухай сургаал/. УБ., 2014. Т-109-110.

⁵ С.Жанцан. "Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол /ялын тухай сургаал/. УБ., 2014. Т-129.

⁶ Доктор Ц.Цэлмэг. "Эрүүгийн хариуцлагыг ял ба эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ гэж ангилна. Эрүүгийн хариуцлагын арга бусад арга хэмжээ нь эмнэлгийн болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ гэсэн хоёр төрөлтэй". /Ц.Цэлмэг. "Эрүүгийн эрх зүй". УБ., 2004. Т-100./

Судлаач доктор Ж.Болдбаатар, Б.Бодбаатар нар "Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг- эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ; - хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ гэж төрөл болгон ангилна" гэжээ. /Ж.Болдбаатар, Б.Болдбаатар. "Эрүүгийн эрх зүйн үндэс". УБ., 2004. Т-88./

⁷ Хууль зүй, дотоод хэргийн яам. "Монгол улсын хууль. /сургагч багш нарт зориулсан гарын авлага/. УБ., 2017. Т.74.

² Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002. Т-59.

³ Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002. Т-60.



- Албадлагын арга хэмжээ нь ял биш /ялын шинжийг агуулдаггүй/, ялын төрөл биш юм. Эрүүгийн хуульд заасан ялын зорилгод нийцүүлэн гэмт хэрэг үйлдэж, гэм буруу нь нотлогдсон хүнтэй үр дүнтэй ажиллах, хувь хүнд нөлөөлөх шинжтэй арга хэмжээ байна.
- Албадлагын арга хэмжээ нь эрүүгийн хариуцлагын нэг төрөл бөгөөд бие даасан ойлголт, ухагдахуун мөн.
- Ял, албадлагын арга хэмжээг оногдуулах үндэслэл, журам өөр байдаг.
- Гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан төрөл, хэмжээний дотор ял оногдуулдаг бол тусгай ангийн санкцад албадлагын арга хэмжээ, түүний төрөл, хэмжээг хуульчилж өгөөгүй.
- Шүүх ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Өөрөөр хэлбэл, шүүхээс гарах энэхүү шийдвэр нь сонголттой байна.

2015 оны Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлд албадлагын арга хэмжээний дараах гурван төрлийг хуульчилж өгсөн байна:

- Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ
- Эмнэлгийн чанартай албадлагын

арга хэмжээ

- Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ юм.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний хувийн байдал гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан энэ бүлэгт заасан журмын дагуу ял оногдуулж, оногдуулсан ял дээр нэмж, эсхүл ял оногдуулахгүйгээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно” гэж хуульчилсан байна. Мөн уг хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Шүүхээс арван найман насанд хүрсэн ба хорин нэгэн насанд хүрээгүй хүнд энэ бүлэгт заасан үндэслэл, журмаар ял оногдуулж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэж болно” гэж тусгасан байна.

Харин хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу

- Эрх хасах албадлагын арга хэмжээ
- Татан буулгах албадлагын арга хэмжээ
- Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж хэрэглэж болохоор заасан байна.

Дээрх бүх албадлагын арга хэмжээг нэгтгэвэл долоон төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэх боломжтой юм.



Ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн тодорхой эрх, эрх чөлөөг хязгаарлахад чиглэгддэг бөгөөд ял бүрийн хязгаарлах эрх, эрх чөлөөнд нь өөр буюу тодорхой зорилго бүхий байх ёстой. Тухайлбал, Торгох ял нь тухайн этгээдийн эдийн засгийн эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтооход чиглэгддэг.

Гэтэл Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүх ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж албадлагын арга хэмжээг хэрэглэж болно гэж

хүлээлгэж, хязгаарлалт тогтооно. Үүнд:

Үүрэг хүлээлгэх	Эрх хязгаарлах
- Гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах; - Зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах; - Тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх; - Оршин суух газар, ажил сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх.	- Тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах; - Галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох; - Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох; - Тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох.

Хуулийн этгээдэд оногдуулах албадлагын арга хэмжээ

2015 оны Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт заасны дагуу гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болохоор хуульчилсан байна.

- Эрх хасах албадлагын арга хэмжээ;
- Татан буулгах албадлагын арга хэмжээ;

Эрүүгийн хуульд заасан байгаа нь албадлагын арга хэмжээний мөн чанар, зорилгыг үгүйсгэж байна.

Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ нь эрх хасах ялтай зарим талаараа давхацсан, ижил байгаа нь ял болон албадлагын арга хэмжээг ижил түвшинд ойлгож гэм буруутай этгээдийн ямар эрх, эрх чөлөөг хязгаарлах асуудлыг нэг мөр болгоогүй байна.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, эрхийн хязгаарлалтыг тогтоож болно. Шүүхээс дараах үүрэг

- Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.

Эрх хасах албадлагын арга хэмжээ: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Аж ахуй үйл ажиллагааны тусгай



зөвшөөрлийн тухай хуульд⁸ заасан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулах эрхийг л хязгаарлах боломжтой байна.

Татан буулгах албадлагын арга хэмжээ: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь гэмт хэрэг үйлдсэн бол салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгаж болно. 2015 оны Эрүүгийн хуульд заасан хоёр төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан бөгөөд энэ нь террор үйлдэх, террор үйлдэхийг санхүүжүүлэх гэмт хэрэгт л хэрэглэнэ.

Хуулийн этгээдэд оногдуулах албадлагын арга хэмжээг тухайн этгээдийн онцлогт тохируулан хэрэглэхээр хуульчилсан боловч хуулийн этгээдэд авч болох эрх хасах болон татан буулгах албадлагын арга хэмжээг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиололд хэрэглэнэ гэж заасан нь албадлагын арга хэмжээг ялаас ялгах гол шинжийг үгүйсгэж байна.

Хоёр. Гадаадын зарим улс оронд албадлагын арга хэмжээг зохицуулсан байдал

Ялын системд эрүүгийн албадлагын арга хэмжээ болон ялын бус эрүүгийн зарим санкцууд зэрэг нь шууд бус хамаарлаар холбогдсон байдаг. Олон улс оронд ялаас гадна албадлагын арга хэмжээг давхар хуульчилж өгсөн

байна.

Судалгаанаас үзэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг 40 шахам оронд хэрэглэдэг бол насанд хүрээгүй этгээдэд хүлээлгэх хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг 30 шахам оронд түгээмэл хэрэглэдэг гэсэн мэдээ бий. Түүнчлэн гэмт хэргийн орчин бүрдүүлсэн байгууллага, газарт хориг арга хэмжээ авах, хяналт тогтоох, мэргэжлийн үйл ажиллагааг тодорхой хугацаанд зогсоох, гэмт хэргийн улмаас олсон хууль бус орлогыг хураах, эд хөрөнгийн баталгаат битүүмжлэл тогтоох гэх мэт эрүүгийн шинжтэй (ял бус) арга хэмжээг түгээмэл хэрэглэдэг байна⁹.

Албадлагын арга хэмжээг улс орнууд өөр өөр байдлаар нэрлэн эрх зүйн хэм хэмжээндээ тусгасан байдаг байна. Тухайлбал, ХБНГУ-д "залруулга болон аюулгүй байдлын арга хэмжээ" гэж томъёолон Эрүүгийн хуулийн 61-70 дугаар зүйлд, "аюулгүй байдлын арга хэмжээ" гэдэг утгаар Итали (Эрүүгийн хуулийн 202-208 дугаар зүйлд), Испани (Эрүүгийн хуулийн 95-105 дугаар зүйлд), Сомали улс (Эрүүгийн хуулийн 162-180 дугаар зүйлд), харин Оросын Холбооны улсад "Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ" гэж Эрүүгийн хуулийн 90, 91, 97, 99, 104 дүгээр зүйлүүдэд заасан байдаг бол Австри улсад "урьдчилан сэргийлэх арга хэмжээ"

⁹ Понотарев П. Ильяшенко А. Уголовно-правовые средства защиты интересов семьи зарубежных опыты. М., 2002. С.34-27. /дам ишлэв. Д.Баярсайхан. "Харьцуулсан эрүүгийн эрх зүй". УБ., 2012. Т-132./

⁸ Төрийн мэдээллийн 2001 оны №6-т нийтлэгдсэн.



гэж Эрүүгийн хуулийн 21-25 дугаар зүйлдээ хуульчилж өгчээ¹⁰.

Унгар улс

Унгар улсын 2012 оны 7 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн¹¹ 8 дугаар бүлэгт Албадлагын арга хэмжээг хуульчилж өгсөн байна. Уг хуулийн 8 дугаар бүлгийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Албадлагын арга хэмжээ нь¹²:

1. Анхааруулах
2. Нөхцөлт шийтгэл буюу Ял тэнсэх
3. Нэмэлт ажил гүйцэтгэх
4. Хяналт тавих
5. Хураах /confiscation/
6. Эд хөрөнгийг хураах /confiscation of property/
7. Электрон мэдээлэл авах боломжийг хязгаарлах
8. Эмнэлгийн байгууллагад албадан эмчлэх
9. Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын тухай хуулийн эрүүгийн хариуцлага гэсэн хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийн эсрэг авах арга хэмжээ зэргийг хуульчилжээ.

Анхааруулах, ял тэнсэх болон нэмэлт ажил хийх арга хэмжээг бие даасан байдлаар, торгох ялын оронд хэрэглэж болно.

Анхааруулах

Аливаа этгээд нь шүүхийн үйл ажиллагааны үед болон бусад үед нийгэмд үлэмж хэмжээний хор хохирол учруулахуйц үйлдэл хийвэл Эрүүгийн хуульд нийцүүлэн ялыг өршөөсөн эсэхээс үл харгалзан эд хөрөнгийг хураах, хураах, электрон мэдээлэл авах боломжийг хязгаарлах анхааруулгыг өгнө.

Шүүхийн болон прокурорын зүгээс анхааруулга өгөхдөө, тухайн этгээдэд ирээдүйд ямар нэгэн гэмт хэргийн үйлдэл хийхээс татгалзах тухай зөвлөгөө өгнө.

Ял тэнсэх

Шүүх гэм буруутай нь тогтоогдсон нөхцөлд нөхөн сэргээлтийн зорилгод үйлчлэх үндэслэлтэй гэж үзвэл шүүхээс гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр бол хойшлуулж болно.

Туршилтын хугацаа нэгээс гурван жилийн хооронд байж болно. Хугацаа нь жил, эсвэл жил, сараар тодорхойлогдоно

Туршилтыг магадлагч ажилтны хяналтан доор байрлуулж болно. Хэрэв магадлан итгэмжлэлийн журмыг зөрчсөн бол нэг жилээс илүүгүй хугацаагаар нэг удаа сунгаж болно.

Нэмэлт ажил гүйцэтгэх

Шүүх нөхөн сэргээлтийн зорилгоор үйлчлэх боломжтой гэж үзвэл нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулсан буюу гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр нэмэлт

¹⁰ T.F.Miniazeva, A.V.Serebrenikova. "Security Measures in Russia and Germany: Comparative Legal Analysis". Mediterranean Journal of Social Sciences. Italy. 2015. P-1.

¹¹ <http://www.parliament.am/library/Qreakan/Hungary.pdf>

¹² <http://www.parliament.am/library/Qreakan/Hungary.pdf>



ажил гүйцэтгүүлж болно.

Нөхөн төлбөрт гүйцэтгэсэн ажлыг шалгалттай хамт туршилттай зэрэгцүүлэн захиалж болно.

Бүгд Найрамдах Чех улс

Бүгд Найрамдах Чех улсын хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль нь 2009 онд батлагдан 2011 онд нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд уг хуулийн 96-104 дүгээр зүйл заалтад "Хамгаалалтын арга хэмжээ" гэж албадлагын арга хэмжээг хуульчилсан байна¹³.

Тус улсын Эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлд Хамгаалалтын арга хэмжээний төрлийг хуульчилсан байх ба үүнд

- (1) Хамгаалах эмчилгээ,
- (2) Баривчлах хамгаалалт
- (3) Эд зүйлс эсхүл бусад үнэ бүхий зүйлийг хураах
- (4) Хамгаалалтын боловсрол гэсэн дөрвөн төрөлтэй байхаар тусгажээ.

Уг Хамгаалалтын боловсролыг ногдуулах нь насанд хүрээгүй хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулах ба Хамгаалах эмчилгээг баривчлах хамгаалалттай зэрэгцүүлэхийг хориглодог байна.

Хамгаалах эмчилгээ

Эрүүгийн хуулийн 40 (2) ба 47 (1) хэсэгт заасан тохиолдолд болон гэмт хэрэг үйлдсэн этгээд хариуцлага хүлээх чадваргүй, ял шийтгүүлээгүй бөгөөд сул чөлөөтэй байх нь аюултай бол хамгаалах эмчилгээний арга

хэмжээг авна.

Шүүх дараах тохиолдолд хамгаалалтын эмчилгээг авч болно

а) гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тус улсын хуулийн дагуу сэтгэцийн эмгэгтэй гэж тогтоогдсон бөгөөд сул үлдсэн тохиолдолд аюултай байж болохоор бол,

б) түүний үйлдэлд нөлөөлөх донтуулагч бодисыг хэрэглэдэг этгээд;

Шүүх нь тухайн этгээдийн өвчин болон эмнэлгийн боломжийн дагуу албадан эмчилгээг байгууллагын буюу амбулаторийн хэлбэртэйгээр авч болно.

Баривчлах хамгаалалт

Шүүх нь Эрүүгийн хуулийн 47 (2)-р зүйлд дурдсан тохиолдолд хамгаалалтанд албадан саатуулж, эсхүл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол баривчлах хамгаалалтыг авч болно.

Нийгмийн хамгааллыг хангах хугацаагаар баривчлах хамгаалалт үргэлжилнэ. Шүүх арван хоёр сар тутамд дор хаяж нэг удаа, насанд хүрээгүй хүмүүсийг зургаан сар тутамд нэг удаа үргэлжлүүлэх үндэслэл байгаа эсэхийг хянан.

Хамгаалах байранд тусгай хамгаалалт, эрүүл мэнд, сэтгэл зүйн, боловсрол, сурган хүмүүжүүлэх, нөхөн сэргээх, идэвхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Эд зүйлс эсхүл бусад үнэ бүхий зүйлийг хураах

Эрүүгийн хуулийн 70-р зүйл (1)

¹³ <http://www.legislationline.org/documents/section/criminal-codes>



-ын дагуу эд зүйл, бусад хөрөнгийн үнийг хураан авах ялыг ногдуулахгүй бол шүүх дараах этгээдийн эд зүйл буюу бусад эд хөрөнгийг хураахгүй:

а) Хэрэв тухайн этгээд ял шийтгүүлээгүй, хэрэг хариуцах чадваргүй этгээдэд хамаарах бол,

б) Шүүхээс ял шийтгүүлсэн этгээдэд хамаарах бол

в) Хэрэв хүн, эд хөрөнгийн аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах шаардлагатай бол, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан эд зүйл бол

Хэрэв дээрх дэд зүйл (1)-д заасан нөхцөлд хамаарахгүй бол шүүх гэмт хэрэг үйлдсэн, тэр ч байтугай шууд бусаар гэмт хэргээс олсон орлогыг хураан авч болно.

а) эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн эсвэл ийм үйлдэлд шагнал урамшуулал болгон олж авсан бөгөөд энэ нь гэмт этгээдэд хамаарахгүй байгаа бол;

б) гэмт хэрэг үйлдсэн этгээдээс эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг нь гэмт хэрэгт өртсөнөөс бусад этгээдээс авсан буюу ийм үйлдлийн шагнал нь худалдан авсан зүйл эсвэл бусад хөрөнгийг хураана.

Португал улсын эрх зүйн зохицуулалт

Португал улсын 1995 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуулийн¹⁴ 6-р бүлэгт "албадлагын арга хэмжээ"-г хуульчилсан байна.

Уг хуулийн 6-р бүлгийн 1-р хэсэгт "Ял оноохгүйгээр тусгаарлан хорих" гэсэн ойголтод "Шүүх нь гэмт хэрэг үйлдсэн этгээд нь сэтгэл мэдрэлийн өвчтэй болон бусад сэтгэцийн хэвийн бус байдлын улмаас гэмт хэрэг үйлдэх магадлалтай гэх үндэслэл байвал энэ хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах байгууллагад тусгаарлан хорьж болно" гэж заасан байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг чөлөөлөлөх нь хууль сахиулах буюу нийгмийн энх тайвныг хамгаалах шаардлагатайгаас бусад тохиолдолд хүний эсрэг үйлдсэн гэмт хэрэг буюу хорих ялаар шийтгэгдсэн нийтлэг гэмт хэрэгт хамаарах бол тусгаарлан хоригдох хугацаа нь гурван жил хүртэл байна.

Уг бүлгийн 2 дугаар хэсэгт саатуулахгүйгээр авах албадлагын арга хэмжээг зохицуулсан байна.

Эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлд Үйл ажиллагаа явуулахыг хориглохыг дараах байдлаар хуульчилсан байна.

Мэргэжлийн болон арилжаа, аж үйлдвэрийн үйл ажиллагаа эсхүл уламжлалт үүргээ ноцтой зөрчсөн гэмт хэрэгт яллагдаж байгаа этгээдийн үйлдсэн гэмт хэрэг болон түүний хувийн шинж чанарыг харгалзан тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно.

Энэ хариуцлагын арга хэмжээ нь 1-5 жил хүртэл хугацаагаар үргэлжлэнэ.

Тээврийн хэрэгсэл жолоодохыг хязгаарлах, зөвшөөрлийг цуцлах

¹⁴ <http://www.legislationline.org/documents/section/criminal-codes>



Тээврийн хэрэгслийг жолоодох үед, эсхүл түүнтэй холбоотойгоор жолоочийн үүргээ зөрчсөн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хязгаарлах буюу хүчингүй болгоно.

Дүгнэлт

2015 оны Эрүүгийн хууль батлагдсантай холбоотойгоор Эрүүгийн эрх зүйн зарим ухагдахуунуудад шинжлэх ухааны болоод онолын хувьд нилээдгүй өөрчлөлт орсон билээ.

Энэхүү арга хэмжээг 2002 оны Эрүүгийн хуульд "Эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ" гэж томъёолон хуульчилж байсан бол 2015 оны Эрүүгийн хуульд "албадлагын арга хэмжээ" гэх ойлголтыг бие даасан байдлаар бий болгож байна. Энэ нь энэхүү арга хэмжээг илүү өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай болгож байгаагаас гадна албадлагын арга хэмжээний өөрийн мөн чанарыг өөрөөр таньж мэдэх шаардлагыг бий болгоод байна.

Албадлагын арга хэмжээ нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон этгээдэд хүлээлгэх ялын бус шинжтэй Эрүүгийн хуульд заасан төрийн нөлөөллийн чанартай албадлага юм¹⁵. Шүүх ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж албадлагын арга хэмжээг хэрэглэж болно гэж

Эрүүгийн хуульд заасан байгаа нь албадлагын арга хэмжээний мөн чанар, зорилгыг үгүйсгэж байна.

Үндсэндээ албадлагын арга хэмжээ нь ялыг зорилгыг агуулахгүй бөгөөд гэмт хэрэг, зөрчлөөс олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн зорилго бүхий байна.

Түүнчлэн хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу эрх хасах албадлагын арга хэмжээ, татан буулгах албадлагын арга хэмжээ, Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж хэрэглэж болохоор заасан байна.

Дээрх байдлаар албадлагын арга хэмжээг тухайн этгээдийн онцлогт тохируулан хэрэглэхээр хуульчилсан боловч хуулийн этгээдэд авч болох эрх хасах болон татан буулгах албадлагын арга хэмжээг эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хэрэглэнэ гэж заасан нь албадлагын арга хэмжээг ялаас ялгах гол шинжийг үгүйсгэж байна.

Түүнчлэн үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ нь зорчих эрхийг хязгаарлах ялтай зарим талаараа төстэй байх бөгөөд энэ албадлагын арга хэмжээг зорчих эрхийг хязгаарлах ялтай давхар хэрэглэх тохиолдолд хэрхэх вэ? гэдэг асуудал тодорхойгүй байна.

¹⁵ С.Жанцан. "Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол /ялын тухай сургааль/. УБ., 2014. Т-129.



ҮНДСЭН ХУУЛИЙН ХАРИУЦЛАГА - ХАМГААЛАЛТ



М.Хатанзориг

Шихихутуг ИС-ийн Иргэн, бизнес
эрх зүйн тэнхимийн багш

*“Хэрэв ард түмэн өөрсдийгөө
удирдах чадваргүй болох аваас
эцсийн эцэст хэн нэгэн өөдгүй этгээд
захирагч болдог” Платон*

Монголын ард түмэн бид:
-улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт
байдлыг бататган бэхжүүлж,
-хүний эрх, эрх чөлөө, шударга ёс,
үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
-төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг
нандигнан өвлөж,
-хүн төрөлхтөний соёл иргэншлийн
ололтыг хүндэтгэн үзэж,
-эх орондоо хүмүүнлэг, иргэний
ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг
эрхэм зорилго болгоно. Үүний учир
Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо
зарлан тунхаглаж байна...¹

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэг

1992.01.13.11.35

1992.02.12.00.00

Та энэ тоог мэдэх үү? Эхнийх нь Үндсэн
хуулийг баталсан, удаах нь мөрдөж
эхэлсэн он, сар, өдөр, цаг, минут...²

Түүх, ёс заншил, эрх, эрх чөлөө,
ирээдүйн хөгжил, тусгаар тогтнолоо бид
Үндсэн хуулиндаа бататган тунхаглаж,
Үндсэн хуульт ёсыг төлөвшүүлэн хөгжүүлж,
Монгол Улсаа хүн төрөлхтний хөгжлийн
түүхэнд хүргэхийн зэрэгцээ, үр хойчдоо эх
орондоо сэтгэл түвшин амьдрах эрх чөлөөг
нь, халдашгүй дархан хил, ариун дагшин
газар нутагтай нь өвлүүлэн үлдээх их
зорилгыг эрхэм болгоод эдүгээ 23 жилийг
ардаа үдлээ.

Энэ хугацаанд алдсан, оносон нь бий
боловч алдаа болгоноосоо суралцаж,
тэдгээрийг засан залруулж чадсан уу
гэвэл харамсалтай нь хараахан тийм
биш. Их зохиолч Д.Нацагдоржийн
илэрхийлсэнтэй зүйрлэвэл өнөөгийн
байдал "...шалдар булдар, цагийн улирал
ороо бусгаа..." хэвээрээ мэт. Сайн сайхныг
үл тоомсорлож, муу муухайг сорчлон
харуулах гэж би хичээсэнгүй. Төрийн
өндөр албан тушаалтнууд Үндсэн хуулиа
зөрчсөн, түүний цаана хадгалагдаж буй
ард түмэн, улс орныхоо ирээдүйг умартаж,
өөртөө зориулсан, хувийнхаа явцуу
ашиг сонирхолд тулгуурласан хуулиудыг
батлуулахыг л улайрах мэт санагдам, ард
түмнээсээ тасарсан төлөөлөл нь хэн ч хянах
боломжгүй дархан эрхтэй болж, нийгмийн
ашиг сонирхол, итгэл найдвар шингэсэн
Үндсэн хуулиа зөрчсөн тохиолдолд ямар
хариуцлага хүлээх нь хүртэл булингартан
бүдгэрч, хатуухан хэлэхэд худалдагдсан
гэмээр түшээдтэй, хэзэх эрхгүй манаачтай
болоход тулаад байна.

² Б.Чимид. Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. УБ.,
2006 он. /Редактор академич Ж.Амарсанаагийн
бичсэн өмнөтгөл/



Нэг. Үндсэн хуулийн хариуцлагын үндэслэл.

Хөдөлмөрийн баатар, доктор Б.Чимид агсан: “Эрх зүйн үгүйсгэл бол нийгмийн эрх зүйн ухамсарт илэрдэг үзэл бодлын нэн хорлонтой урсгал юм. Албан ёсны буюу эрх зүйн ухамсрын дээд түвшний үгүйсгэлд засаг, төрийн дээд төв байгууллага өөрийн шийдвэр, үйл ажиллагаагаараа Үндсэн хуулийн алив нэг үндэслэл, заалтыг үл тоомсорлон дур зоргоор зөрчин гажуудуулдаг явдал хамаарна. Үүнээс дутуугүй аюултай үгүйсгэл нь Үндсэн хуулийн аль нэг заалтыг дургуйцэн үзэж, үгүйсгэн зөрчиж байгаа төдий бус, харин уг заалтыг бүхэлд нь, өөрөөр хэлбэл түүгээр бэхжүүлсэн ардчиллын үнэт зүйлс, үзэл баримтлал оршин буй засаг, төрийн байгууллагыг нийтэд нь үзэн ядаж үгүйсгэн устгах зорилготой нь амьдрал дээр тодорсоор байна. Засаг төрийн эрх мэдлийг эзлэн авахын тулд юу ч хийхээс буцахгүй болсон хэсэг бүлгийн тэр гүтгэлгийн нэн тэргүүний зорилго нь Монгол Улсын ардчилал зах зээлийн харилцаанд шилжсэн хорин жилийн үнэнхүү ололтыг үгүйсгэхийн сацуу шинэтгэлийн замд тохиолдсон элдэв бэрхшээл, эрх баригчдын ноцтой алдаа, завхралыг /шударгаар шүүмжлэн эв эеэр хамтран залруулахын тулд биш/

элдвээр дөвийлгөн хөөрөгдөж үндсэн хуульт байгууллагыг үзэн ядсан өшөө хорсол төрүүлэх замаар олон түмнийг араасаа хуурмаглан дагуулахыг чармайж байгаад оршино. Түүний зорилго нь засгийн эрхэд гарах!!” (“Ардчилсан Үндсэн хууль – 20”. УБ.,2012 14-16 дахь тал)

гэснийг Үндсэн хуулийн Цэцийн дарга асан, академич Ж.Амарсанаа “Үндсэн хуулийн хямрал” илтгэлдээ³ тэмдэглэхийн сацуу “Үндсэн хуулийн хямрал бол Үндсэн хуульт байгуулал, улс төрийн тогтолцоонд хамгийн их аюул занал учруулдаг зөрчлийн хурц хэлбэр юм... Үндсэн хуулийн хямралын үед Үндсэн хууль, түүний бодит хэрэгжилтийн хооронд үлэмж зааг гарч, тэдгээрийн хоорондын тэнцвэрт байдал алдагдаж, улмаар Үндсэн хуульд зарчмын өөрчлөлт оруулахгүйгээр Үндсэн хууль хэвийн үйлчлэх боломжгүй болдог байна... Үндсэн хуулийн хямрал нь ихэнх төлөв улс төрийн хямралын үр дагавар болж гарч ирдэг байна” хэмээсэн байдаг.

Дагаж мөрдөгдөх хуулийг мөрдөөгүйн төлөө хариуцлага хүлээлгэх, зөрчигдөх явдлаас урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоо зайлшгүй шаардлагатай бөгөөд эс тэгвээс тухайн хуулинд хямрал нүүрлэх нь гарцаагүй. Нэгэнт нүүрлэсэн хямралыг ч хариуцлагын тогтолцоогүйгээр даван туулах

³ Үндсэн хуулийн Цэц, Ханнс-Зайделийн сан. “Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын чиг хандлага” илтгэлийн эмхтгэл. УБ.,2012 он 36-45 тал



боломжгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц 1993 оноос 2015 он хүртэл нийт 8 удаа Улсын Их Хурлаас баталсан хууль нь Үндсэн хуульд нийцээгүй талаар их суудлын хуралдаанаараа эцэслэн шийдвэрлэж тогтоол гаргасан⁴ ба түүнээс хэд дахин олон тийм агуулга бүхий маргааныг дунд суудлаараа хянан шийдвэрлэж дүгнэлт гаргасан байна. Үүнээс үзэхэд хууль санаачлах эрх бүхий эрх мэдэлтнүүд маань Үндсэн хуульд нийцээгүй буюу түүнийг зөрчсөн агуулга, заалт бүхий хууль санаачилж, Улсын Их Хурал түүнийг нь дэмжин баталж, тэр ч бүү хэл нэлээд хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан удаа цөөнгүй байжээ. Гэвч одоогийн тогтолцоогоор эдгээр тохиолдлуудад Үндсэн хуульд нийцээгүй хууль, зарлиг, батламж шийдвэрүүд, түүний холбогдох заалтууд хүчингүй болохоос хэтэрдэггүй ба зарим улс төрчид бие биенээ “худалдагдсан, хувиа бодсон, юм мэдэхгүй” зэргээр нь цоллоод л өнгөрөхөөс цаашгүй. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуульд нийцээгүй буюу ард түмэн, нийтийн ашиг сонирхолтой зөрчилдсөн агуулга бүхий шийдвэрийг санаачилсан, гаргасан, хэрэгжүүлсэн тохиолдолд уг шийдвэрийг л хүчингүй болгохоос биш гэм буруутай⁵ субъектэд

хүлээлгэх хариуцлагын тогтолцоо байхгүй хэвээр. Магадгүй энэ нь цаашид дахин ийм хууль гаргах элдэв оролдлого хийж, гарах үр дагавараас нь огтхон ч эмээхгүй болгох бий.

- Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж заасан. Үндсэн хуулийн энэхүү зарчим нь төрийн үүрэг, үйл ажиллагааны суурь үзэл баримтлал мөн. Нийтийн эрх ашигт үйлчилдэг төрийн байгууллага, албан тушаалтан бүр үйл ажиллагаандаа энэхүү зарчмыг удирдлага болгож, зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээдэг байх нь ардчилсан эрх зүйт төрийн чухал шинж билээ.⁶
- Төрийн албаны тухай хуулийг 2002 онд шинэчлэн найруулж төрийн албан тушаалтанд сахилгын хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчинг бий болгосноос гадна эдүгээ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 70 орчим хуульд

шийдвэр гаргасан. /Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албан хаагчдад /улс төрийн албан хаагчдад ч мөн адил/ ажил, үүргийн хувьд Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг мэдсэн байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, мэргэшлийн шаардлага тавигдах бөгөөд уг шаардлагад нийцээгүй, Үндсэн хууль, бусад хуулийг зөрчсөн субъектийг мэдэхгүй байсан эсэхээс үл шалтгаалан гэм буруутайд тооцно./

⁶ “Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай хуулийн төсөл”-ийн үзэл баримтлалаас.

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн албан ёсны цахим хуудаснаас авав.

⁵ Үндсэн хууль зөрчсөн гэм буруутай буюу Үндсэн хуулийг мэдэх ёстой байсан ч түүнд нийцээгүй



төрийн албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх, огцруулах үндэслэлийг зааж өгсөн нь улс төрийн албан тушаалтнуудын хувьд ч хариуцлагыг бэхжүүлэх чухал алхам болсон хэдий ч Үндсэн хуулиар бүрэн эрх нь олгогддог өндөр албан тушаалтнуудын хувьд эрх зүйн байдлын онцлогоос хамаарч дээрх зохицуулалт үйлчилдэггүй ба хариуцлага хүлээлгэх хуулийн зохицуулалт тодорхойгүй, бүрхэг байна.

Органик хуулиудын зохицуулалтаар төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхэд бэрхшээлтэй байдаг учраас Үндсэн хуулиар бүрэн эрх нь олгогддог, эрх үүргийн суурь зохицуулалт, чиг үүрэг нь чухамхүү тэнд тодорхойлогддог албан тушаалтнуудад Үндсэн хуулийн шинжтэй хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог бүрдүүлэх шаардлага байна. Органик хуулиудыг баталдаг субъектүүдэд органик хуулиудад үндэслэн хариуцлага хүлээлгэх бодит боломж үнэндээ алга. Монгол Улсад л гэхэд Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсанаас бусад тохиолдолд улс төр, эрх зүйн бодит хариуцлага хүлээлгэх нь дөрвөн жилд нэг удаа болдог сонгуулиар шийддэг мэтээр ойлгогддог.

- Органик хуулийн зохицуулалт, хариуцлага нь тухайн хуулийн хүрээнд субъектив эрхийг

хамгаалж, үүргийг хангуулж мөн тийм хохирлыг барагдуулдаг. Иргэн хийгээд энгийн субъектүүдийн хувьд субъектив эрхээ хамгаалуулсан, хохирлоо арилгуулсан тохиолдолд үндсэн эрх ч давхар хамгаалагдаж, хангагдаж байдаг бол албан тушаалтны хувьд хүлээх ёстой үүрэг, хариуцлага нь зөвхөн субъектив эрх, үүргээр хязгаарлагдахгүй буюу цаад талд нь Үндсэн хуулиар хамгаалагдсан, тухайн албан тушаалын ач холбогдлоор илэрхийлэгдсэн нийтийн буюу ард түмэн, төр улсын ашиг сонирхол агуулагддаг учраас Үндсэн хуулийн онцлог хариуцлага шаардлагатай юм.

Эрүүгийн хуулийг зөрчихөд эрүүгийн хариуцлага, захиргааны зөрчил гаргавал шийтгэл хүлээлгэдэг, иргэний хэрэг маргаанаар учирсан хохирлыг арилгуулдаг зэрэг хууль зүйн хариуцлагын төрлүүд тодорхой байхад Үндсэн хуулийн хариуцлага хүлээлгэдэх үйлчлэлт механизм үгүйлэгдсэн хэвээр.

Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь тангараг өргөснөөр эхэлж дараагийн субъект тангараг өргөснөөр дуусгавар болдог ба төрийн бусад албан хаагчид ч үүрэг гүйцэтгэж эхлэхдээ тус тусын тангарагийг өргөдөг⁷ нь

⁷ Монгол Улсын Ерөнхийлөгч нь "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ эрх чөлөө, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн хамгаалж, Үндсэн хуулийг дээдлэн



гагцхүү хуульд заасан чиг үүргээс гадна ёс зүй, үнэт зүйлсийн хувьд ч ихээхэн чухал үүргүүдийг хүлээдгийн илэрхийлэл мөн. Монголчууд бид эртнээс “ам алдвал барьж болдоггүй, агт алдвал барьж болдог” хэмээн хэлэлцсээр ирсэн нь хэлсэн үгэндээ эзэн байх, үгэндээ үл хүрвээс үр дагаварыг хариуцаж, хариуцлагаа хүлээхийн нэр биз. Андгай, тангараг өргөж, ам өгнө гэдэг нь ёс төдий зүйл биш, үйлдэл, эс үйлдэл ба дотоод сэтгэлээ ч үгэндээ багтаахын үүрэг юм.

Тогтолцооны хувьд авч үзэхэд, Үндсэн хуулийг зөрчих /мөн Үндсэн хуульд нийцээгүй шийдвэр гаргах/ магадлалтай этгээд нь Үндсэн хуулиар эрх, үүрэг нь тодорхойлогдон тангараг өргөдөг, улс төрийн үйл ажиллагаанд тодорхой үүрэг оролцоотой, төрийн өндөр албан тушаал бүхий субъектүүд байгаа нь Үндсэн хуулийн хариуцлагыг эрх зүйн, улс төрийн, ёс зүйн гэж ангилан хэрэгжүүлэх нь зүйтэй гэх үндэслэл болох юм. Хариуцсан чиг үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор эрхээ эдэлдэг бол түүнээс үүдсэн үр дагавар, алдаа дутагдлаа ч хариуцдаг байх нь эрх зүйт төрийн

сахиж, Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглая” гэж, Монгол Улсын Их Хурлын гишүүн нь “Монгол Улсын Их Хурлын гишүүн би ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрийн хуулийг дээдлэн сахиж, гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая” гэж, Төрийн албан хаагч нь “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” гэж тус тус тангараг өргөнө.

нэгэн чухал зарчим төдийгүй хүлээх хариуцлагыг тодорхойлон тогтоож, хэрэгжүүлснээр улс төр, эрх зүйн соёл ухамсрын түвшин ахиж, хууль дээдлэх ёс, Үндсэн хуульт ёс төлөвшин хөгжих суурь нөхцөл бүрэлдэх юм.

Хоёр. Үндсэн хуулийн хариуцлага ба Үндсэн хуулийн шүүх, гадаад орнуудын жишиг

Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийн “манаач” төдийгүй түүний үйл ажиллагаа нь Үндсэн хууль, түүнд хадгалагдсан улс төр, эрх зүйн цаашдын хөгжил төлөвшилд голлох үүрэг, байр суурьтай байдаг талаар эрдэмтэн судлаачид цөөнгүй бичсэн. Үндсэн хуулийн зөрчлийг хариуцлагажуулах нь Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрийн үр нөлөө, баталгаат байдлыг нэмэгдүүлэхэд ч онцгой ач холбогдолтой төдийгүй онол, практикийн үүднээс уг хариуцлагыг оногдуулах субъект нь Үндсэн хуулийн Цэц байх ёстой юм.

Үндсэн хуулийг хамгаалах, Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх зорилгын хүрээнд гадаад улсуудад ч Үндсэн хуулийг хариуцлагажуулах аргыг хэрэглэдэг бөгөөд үүнийг нь Үндсэн хуулийн шүүхүүд нь хэрэгжүүлдэг байна. Гадаад улсуудын Үндсэн хуулийн шүүх эрх бүхий байгууллагуудын Үндсэн хуулийн зөрчилтэй холбоотойгоор хэрэгжүүлдэг бүрэн эрхээс тухайлан дурьдвал:

Герман: Холбооны ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан



шийдвэрлэдэг ба парламентийн аль нэг танхимаас Үндсэн хуулийн шүүхэд хандаж гаргасан дээрх хүсэлтийн агуулгад ерөнхийлөгчийг буруутгах үндэслэл хангалттай байгаа тохиолдолд түүнийг холбооны Үндсэн хуулийн шүүх албан тушаалаас нь огцруулах боломжтой байдаг. Мөн Үндсэн хуулийн шүүх нь "улс төрийн намуудыг хориглох" буюу тухайн нам, улс төрийн хүчний баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Үндсэн хуульд заагдсан улсын бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахаар байвал тэдгээр нам, эвслийн үйл ажиллагаанд хориг тавих эрхтэй ажээ.

Франц: Парламентийн гишүүний хэрэгжүүлж байгаа үүрэг парламентийн гишүүдийн эрх, үүргийн хүрээг хамарч байгаа эсэхийг тогтоох, шаардлагатай гэж үзвэл гишүүний бүрэн эрхийг түтгэлзүүлэх эрхтэй. /Парламентийн гишүүд, танхимийн дарга нар, Хууль зүйн яамны сайд дээрх асуудалтай уялдуулан Үндсэн хуулийн зөвлөлд хүсэлт гаргах эрхтэй/

БНСУ-д: Импичмент - Хэрэв эрх бүхий албан тушаалтнууд нь өөрийн үйл ажиллагаагаар Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл Ерөнхий ассамблей Үндсэн хуулийн шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ. Шүүхээс импичментийн шийдсэн шийдвэр гарах хүртэл тухайн албан тушаалтан нь албан тушаалаасаа түтгэлздэг. Шүүх тухайн албан тушаалтныг

огцруулах шийдвэр гаргаснаар огцордог. Мөн Үндсэн хуулийн шүүх нь улс төрийн намын зорилго, үйл ажиллагаа нь Үндсэн хуулиар тогтоосон ардчиллын үндсэн зарчимд харшилж байгаа гэж үзвэл тухайн намыг татан буулгах эрхтэй.

Арменд: Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгчийг албан тушаалаас огцруулах үндэслэлийн талаар дүгнэлт гаргах, Хуульд заасны дагуу улс төрийн намын үйл ажиллагааг зогсоох эсэх талаар шийдвэр гаргах эрхтэй.

Украйн: Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн эсэх, түүнийг огцруулах үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.

Беларус: Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийг парламентийн танхимууд болон түүний гишүүд зөрчсөн эсэх тухай дүгнэлт гаргана.

Гүрж: Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн дарга, Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Төрийн хянан шалгах танхимын дарга, Үндэсний банкны зөвлөлийн гишүүд Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар шийдвэрлэнэ.⁸

Үүнээс үзэхэд ХБНГУ, БНСУ, Франц зэрэг хөгжингүй улсуудад Үндсэн хуулийн хариуцлагыг ашигладаг бол, Украин, Беларус, Гүрж зэрэг хөгжиж буй, буурай орнууд нь манай улсын нэгэн адил маргааныг шийдвэрлэж дүгнэлт гаргадаг байна.

⁸ Э.Лхагвасүрэн. Гадаад орнуудын Үндсэн хуулийн шүүх: бүрэлдэхүүн эрх хэмжээ, онцлог. УБ., 2003-2006 /"Хууль дээдлэх ёс" сэтгүүлд цувралаар хэвлэгдсэн/



Төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч "Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай" хуулийн төслийг санаачилсан нь Үндсэн хууль зөрчсөн, Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа тангарагаасаа няцсан, ёс зүйн ноцтой зөрчил гаргасан, бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэж хэвших явдалд бодитой нэмэр болохуйц санаачилга байсан ч байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэнгүй. Хуулийн төсөлд техникийн шинжтэй алдаа байсныг үгүйсгэхгүй ч зарчмын хувьд зайлшгүй байх ёстой зохицуулалт байсныг дурьдах нь зүйтэй.

Манай улсын хувьд хувьд:

- Үндсэн хуулиар бүрэн эрх нь олгогддог Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүд, Засгийн газрын Ерөнхий сайд, гишүүд нь Үндсэн хууль зөрчсөн буюу түүнд нийцээгүй шийдвэр гаргасан бол улс төрийн болон сахилгын хариуцлагыг хүлээлгэхээр, ёс зүйн зөрчил гаргасан субъектэд ёс суртахууны хариуцлага хүлээлгэхээр "Үндсэн хуулийн хариуцлагын тухай" - Үндсэн хуулийн дагавар хуулийг батлан зохицуулж хариуцлага хүлээлгэх хугацаа, үндэслэл, түүнийг хянан шийдвэрлэх

процессын ажиллагааг тодорхойлон тогтоох нь зүйтэй. /Сахилгын хариуцлагыг ганцаарчилсан - хаалттай болон нийтэд нээлттэй сануулга өгөх замаар, улс төрийн хариуцлагыг албан тушаалаас нь огцруулж, эсхүл эгүүлэн татаж⁹ албан тушаал хаших эрхийг нь хязгаарлах замаар, ёс суртахууны хариуцлагыг уучлалт гуйлгах, сайн дураараа албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргах эрх өгөх замаар хүлээлгэж болно./

- Үндсэн хуульд нийцээгүй нь тогтоогдсон хууль, бусад хэм хэмжээний актууд хүчингүй болсон тохиолдолд тухайн хэм хэмжээний зохицуулж байсан нийгмийн харилцаанд эрх зүйн хийдэл үүсэхээс сэргийлсэн зохицуулалтыг нэвтрүүлэх нэн шаардлагатай байна.

Түүнчлэн Үндсэн хуулийг хамгаалах явдалд зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээс гадна зөрчигдөхөөс өмнө урьдчилан сэргийлэх боломжтойг зарим улсуудын жишиг харуулж байна. Тухайлбал, Францийн Үндсэн хуулийн зөвлөл Үндсэн хуулийн шүүхтэй нэгэн адил хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлэхдээ тухайн органик хууль тогтоомжийг

⁹ Сонгогдсон албан тушаалтныг эгүүлэн татах, импичментийн ойлголтыг ялган зааглах нь зүйтэй. Энэ талаар Б.Наранцэцэг, Э.Энхцэцэг "Парламентийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох хариуцлагын эрх зүйн зохицуулалт" УБ.,2015 илтгэлээс дэлгэрүүлэн үзэж болно.



батлагдан гарахаас нь өмнө эрх бүхий байгууллага, албан тушаалтны мэдэгдлийн дагуу хянаж, тэдгээр нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргадаг ажээ. Ингэхдээ хуулийн төслийг Үндсэн хуультай уялдуулан баталсан органик хуулиуд, 1789 оны Хүний ба иргэний эрхийн тунхаглал, 1946 оны Үндсэн хуулийн нэгдүгээр зүйл, 3 дугаар Бүгд Найрамдах Улсыг тунхаглах үед Бүгд Найрамдах Улсын Үндсэн зарчим болгохоор зүйлчилсэн заалтуудтай ч харьцуулан үздэг байна.

Манай улсад ч мөн шаардлагатай хуулийн төслүүдийг Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргуулахаар Үндсэн хуулийн Цэцэд хандах боломжийг хуульчлах нь зүйтэй бөгөөд нэн ялангуяа Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Үндсэн хуульд байгуулал, төрийн эрх мэдэл хуваарилалт, ардчилсан эрх зүйт төрийн суурь үзэл баримтлалд нийцэж буй эсэх талаар, Үндсэн хуулийн дагавар шинжтэй хуулиуд нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэх эсэх талаар дүгнэлт, зөвлөмж гаргуулдаг, цаашлаад шаардлагатай тохиолдолд Цэцээс хуулийн төслийг Улсын Их Хуралд оруулахаас татгалзаж, хориг тавих эрхтэй болох нь Үндсэн хуулийг хамгаалах үйл ажиллагааны баталгааг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтой төдийгүй Үндсэн хуулийг зөрчигдсөний дараа нэхэн залруулах гэхээсээ илүүтэйгээр зөрчигдөхөөс өмнө урьдчилан

сэргийлэх боломжтой болох юм. / Тэр ч бүүхэл ОХУ-н Үндсэн хуулийн шүүх нь өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль санаачлах эрхийг эдэлдэг нь Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг баталгуулахад ихээхэн анхаарах ёстойн нэг жишээ юм./

Монгол Улсын гавъяат хууль, доктор Ц.Сарантуяа: "...хэрэв аль нэг хуулийн заалтыг хүчингүй болгосноор тухайн харилцаа бүхэлдээ зохицуулалтгүй үлдэх аваас Үндсэн хуулийн шүүх үндсэн хууль зөрчсөн хуульд өөрчлөлт оруулах талаар хууль тогтоогчид тодорхой хугацаа зааж, зөрчилтэй хуулийг шилжилтийн хугацаанд хүчинтэй байлгах туршлага байдгийг мөн судлан үзэх боломжтой юм" гээд Австри болон Оросын Холбооны Улсын жишээг татсан байна.¹⁰ Үндсэн хуулийн хариуцлага нь гагцхүү субъектийг шийтгэх гэсэн явцуу зорилгоор хязгаарлагдахгүй. Цэцийн шийдвэрээр аливаа эрх зүйн актийг хүчингүй болгосноор тухайн хүчингүй болсон актын зохицуулалттай холбоотой эрх зүйн хийдэл үүсэх тохиолдол гардаг учраас уг асуудалтай холбоотойгоор холбогдох этгээдэд даалгавар өгөх бүрэн эрхийг мөн Үндсэн хуулийн Цэцэд олгох хэрэгцээ шаардлага буй.

¹⁰ Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн эрх зүйн үр нөлөөг дээшлүүлэх нь. УБ., 2012 /Үндсэн хуулийн Цэц, Ханнс-Зайделийн сан. "Үндсэн хуульд ёсны төлөвшил, цаашдын чиг хандлага" илтгэлийн эмхтгэлээс/



Гурав. Төгсгөл.

Монгол Улсын Үндсэн хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” хэмээн заасан нь Үндсэн хуулийг бүх эрх зүйн актууд, баримт бичгүүдийн “эцэг хууль” гэдгийг илэрхийлэхээс гадна түүний заавал дагаж мөрдөгдөх амин шинжийг тодотгон харуулжээ. Үндсэн хуульд ёсыг суурьшуулан хөгжүүлэх, чигч шударга, зөв зүйтэй иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийн тулд Үндсэн хуулийн хариуцлагыг хууль тогтоомж, төрийн тогтолцоондоо нэвтрүүлэн төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага нэн тулгамдаж буй.

Эцэст нь дүгнэхэд Үндсэн хуулиар тогтоосон өндөр ач холбогдол бүхий албан тушаал, ажил үүргүүдийг тухайн ажилд нийцсэн мэдлэг боловсрол, соёл төлөвшил, сэтгэл хандлага бүхий этгээд гүйцэтгэх ёстой бөгөөд нийцэж эс чадваас огцорч ч мөн болно гэдгийг анхаарах хэрэгтэй.

Суут сэтгэгч Аристоталь-н хэлснээр “Улс төр гэдэг, сайн хүнийг ч муу болгож чаддаг” учраас бид улс төрд хэн байхаас үл шалтгаалан ард түмнийхээ ашиг сонирхол, итгэл найдвар шингэсэн Үндсэн хуулийг хамгаалж чаддаг тогтолцоотой, хазах эрхтэй манаачтай болох шаардлагатай биз ээ.

Тиймээс, Ардчилсан Үндсэн хуулийн Эх баригч, доктор Б.Чимид багшийн нэгэнтээ ишэлсэн “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсантай холбогдуулан Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулийн 2 дугаар хуралдаанд Ерөнхийлөгч П.Очирбатын хэлсэн үг”-ээр уг сэдэмжээ төгсгөө:

“...Үндсэн хуулийнхаа ардчилсан хүнлэг үзэл санааг эрхэмлэн дээдэлж, заалт бүрийг нь уг, үсэгчлэн мөрдөж, өөрийн хүчийг дээд зэргээр дайчлан хичээх сэтгэлээр хувийн санаачилгатай хөдөлмөрлөж, баян чинээлэг амь зуулгатай, цог золбоотой, хийморлог үндэстэн байхын төлөө миний ард түмэн чин сэтгэлээсээ зүтгэнэ гэдэгт итгэл дүүрэн байна...”



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХӨРӨНГӨ АЛБАДАН ХУДАЛДАН БОРЛУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫГ НЭГ МӨР ОЙЛГОХ, ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС



С.Бямбарагчаа

*ШШГЕГазрын харьяа Банк хадгаламж
зээлийн хоршоодын төлбөр барагдуулах
ажлын албаны Дэд бөгөөд шийдвэр
гүйцэтгэлийн хэлтсийн дарга, хошууч
Шихихутуг ИС-ийн магистрант*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 32-р зүйлд **төлбөр авагч** гэж “Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээдийг”, **төлбөр төлөгч** гэж “Төлбөр авагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн, үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан хүн, хуулийн этгээдийг” ойлгохоор заасан гэнэ.

Тэгвэл шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь хуулийн хүчинтөгөлдөр шүүхийн шийдвэрийг хуулийн дагуу, шуурхай биелүүлж, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээн, хамгаалах зорилготой.

Шүүхийн шийдвэрийг шуурхай биелүүлэхэд хууль эрх зүйн оновчтой зохицуулалт чухал үүрэг, ач холбогдолтой. Практикаас харахад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг онцлог, эрх зүйн зохицуулалтын эерэг ба сул тал нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шууд нөлөөлж, нэг бол үр дүнгээ өгч, нэг бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнгүй болгож байдаг бөгөөд хуулийн зүйл заалтыг нэг мөр ойлгох, практикт зөв хэрэглэх асуудал чухал болоод байгаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинээр батлагдан гарч, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Шинэчлэн батлагдсан хуульд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг томоохон төрөл болох хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагаатай холбоотой өмнөх хуулиар зохицуулагдаагүй байсан харилцааг зохицуулсан шинэ зохицуулалтууд нэмэгдсэнээрээ онцлогтой болсон.



Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр иргэн хуулийн этгээдээс хураан авсан хөрөнгийг албадан худалдан борлуулах ажиллагааг шинэ хуулийн 5 дугаар бүлгээр зохицуулсан бөгөөд хөдлөх хөрөнгийг үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар, үл хөдлөх эд хөрөнгө төдийгүй үнэт цаас, эдийн бус хөрөнгө, түүх, соёлын өвд хамаарах үнэт зүйл, тусгай зөвшөөрөл, шаардах эрхийг албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар хуульчилсан бөгөөд шинээр орсон зарим зүйл заалтыг нэг мөр ойлгох, практикт зөв хэрэглэх тал дээр учир дутагдалтай байгаа юм.

Иймд хөрөнгө албадан худалдан борлуулахтай холбоотой шинээр орсон зарим зохицуулалтыг хэрхэн нэг мөр ойлгох талаар санал бодлоо бичлээ.

1. Хөрөнгө худалдан борлуулахтай холбоотойгоор шинэ хуульд орсон нэг чухал зохицуулалт бол төлбөр төлөгч өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах эрхийг хуульчилсан явдал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д "Хөрөнгийн үнэлгээний талаар талуудаас гомдол гаргаагүй тохиолдолд төлбөр төлөгч энэ хуулийн 55.3-т заасан шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор өөрийн хөрөнгийг уг шийдвэрт зааснаас багагүй үнээр бие даан худалдан борлуулах тухай санал гаргаж болох"-оор, 62.2-т "Шийдвэр гүйцэтгэгч саналыг

хүлээн авсан тохиолдолд бие даан худалдан борлуулах 1 сарын хугацааг төлбөр төлөгчид олгож, энэ хугацаанд тухайн хөрөнгийг албадан борлуулах ажиллагааг зогсоох"-оор зохицуулсан. Мөн хуулийн 55.3-т "...хөрөнгийн үнэлгээг шинжээчээр тогтоолгосон тохиолдолд шинжээчийн дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор талуудад мэдэгдэж, дүгнэлтийг танилцуулж, санал хүсэлт авах"-аар зохицуулсан.

Дээрх заалтыг ойлгохдоо хөрөнгийн үнэлгээг зөвхөн шинжээчээр тогтоолгосон тохиолдолд төлбөр төлөгч өөрийн хөрөнгийг шинжээчийн үнэлсэн үнээс багагүй үнээр бие даан худалдан борлуулах боломжтой болно гэж ойлгох нь зүйтэй.

Учир нь өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах тухай төлбөр төлөгчийн саналыг хүлээн авснаар бие даан худалдан борлуулах 1 сарын хугацааг төлбөр төлөгчид олгож, энэ хугацаанд тухайн хөрөнгийг албадан борлуулах ажиллагаа зогсдог бөгөөд мэргэжлийн шинжээчийн үнэлгээ нь тухайн хөрөнгийн тухайн цаг үеийн зах зээлийн хамгийн бодитой үнэлгээ байдаг тул зөвхөн шинжээчээр үнэлгээ тогтоолгосон тохиолдолд л төлбөр төлөгчид өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах боломжийг хуулиар бий болгожээ.

Өөрөөр хэлбэл хөрөнгийн үнэлгээг төлбөр төлөгч, төлбөр



авагч, өмчлөгчид харилцан тохиролцож тогтоосон бол төлбөр төлөгчид өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах эрх үүсэхгүй гэж ойлголт юм.

Гэхдээ төлбөр төлөгч өөрийн хөрөнгийг албадан худалдан борлуулах ажиллагааны явцад төлбөрийн үүргийг бүрэн хангах хэмжээний үнээр худалдан борлуулах боломжийг хуулиар хориглоогүй. Тухайлбал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 72.2-т Төлбөр төлөгч өөрийн хөрөнгийг албадан худалдан борлуулах ажиллагааны явцад өөрийн хөрөнгийг бие даан худалдах эрх эдлэхээр, 72.3-т Төлбөр төлөгч хөрөнгийг албадан худалдахаас өмнө Иргэний хуульд заасан хувь хэмжээгээр тогтоосон албадан дуудлага худалдааны үнээс илүү үнээр худалдахаар гэрээ байгуулсан тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд төлбөрийг шилжүүлснээр хөрөнгийг худалдан авагчид шилжүүлэхээр зохицуулсан байна.

2. Хөрөнгө худалдан борлуулах ажиллагаатай холбоотой анхаарал татсан бас нэг зохицуулалт бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн "Шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар хураан авсан хөрөнгийг түүний үнэлгээг тогтоосноос хойш 2 сарын дотор, төлбөр төлөгчийн өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах тухай саналыг хүлээн авсан тохиолдолд 3 сарын дотор

албадан худалдан борлуулах ажиллагааг явуулна" гэж заасан зохицуулалт юм.

Уг зохицуулалт нь хөрөнгийн үнэлгээ тогтоосноос хойш 2 сарын дотор хөрөнгө албадан худалдан борлуулах тодорхой ажиллагаа явагдсан байхаар тайлбарлагдана. Өөрөөр хэлбэл дээрх хугацааны дотор хөрөнгө худалдан борлуулах ажиллагаа бүрэн дуусах биш шийдвэр гүйцэтгэгчийн зүгээс хөрөнгө худалдан борлуулах хуульд заасан ажиллагааг явуулсан байх хугацаа юм. Учир нь хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны явцад хөрөнгийн үнэлгээ болон шийдвэр гүйцэтгэх тодорхой төрлийн ажиллагаанд талуудаас гомдол гарах, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд зааснаар түдгэлзүүлэх зэрэг шалтгаанаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тодорхой бус хугацаагаар сунжрах тохиолдол практикт их байдаг. Иймд дээрх хугацааг зөв ойлгож практикт хэрэглэхгүй бол шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит үр дүнд сөргөөр нөлөөлөх боломжтой юм.

Мөн хуулийн 55 дугаар зүйлийн 55.5-д "Үнэ ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан тогтоосон хөрөнгийн үнэлгээнд анх тогтоосон үнийн гуравны нэгээс багагүй хэмжээний өөрчлөлт орсон гэх үндэслэлтэй тохиолдолд талуудын хүсэлтээр шийдвэр гүйцэтгэгч анхны үнэлгээг тогтоосноос **6 сараас багагүй хугацааны дараа** дахин үнэлгээ



тогтоолгож болно” гэж зааснаас дүгнэхэд хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагаа үнэлгээ тогтоосоноос хойш 2 сарын дотор бүрэн дууссан байхыг хатуу тогтоогоогүй нь харагдаж байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.10-т заасан “Дуудлага худалдаагаар борлогдсон үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлсэн дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийн шийдвэрийг тогтоосон хугацаанд танилцуулна. Энэ хугацаа 14 хоногоос хэтрэхгүй байна.” гэсэн заалтыг хэрхэн нэг мөр ойлгох, эрхлэн хөтлөгчийн шийдвэрийг хэдийд гаргах зэрэг асуудлыг тодорхой болгох шаардлага практикаас урган гарч байна.

Уг заалтыг мөн хуулийн 71.11-т заасан “Дуудлага худалдааг эрхлэн хөтлөгчийн шийдвэрт дуудлага худалдааны ялагчийн овог, нэр, дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнэ, хөрөнгийн үнийг бүрэн төлсөн болон өмчлөх эрх үүсэх, эд хөрөнгө чөлөөлөх хугацааг заана.” гэсэн заалттай уялдуулж ойлгох нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийн өмчлөх эрх шилжүүлэх шийдвэр гаргах хугацааг албадан дуудлага худалдааны ялагч тодормогц дуудлага худалдааны ялагчийн санхүүгийн боломж, худалдан авсан эд хөрөнгийн үнийг ямар хугацаанд төлөх талаар гаргасан саналыг

харгалзан тогтоохоор зохицуулсан ойлголт бөгөөд дуудлага худалдааны ялагч худалдан авсан хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө гэсэн ойлголт юм.

Дуудлага худалдааны ялагч 14 хоногийн дотор худалдан авсан хөрөнгийн үнийг төлсний дараа дуудлага худалдааны эрхлэн хөтлөгч өмчлөх эрх шилжүүлэх шийдвэрийг гаргаж уг шийдвэрт хөрөнгийн үнийг бүрэн төлсөн талаар дурдаж дуудлага худалдааны ялагчид өмчлөх эрхийг үүсгэж, төлбөр төлөгчид эд хөрөнгийг чөлөөлж өгөх хугацаа тогтоож өгөхөөр зохицуулсан байна.

4. Мөн хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагаа түүний дотор худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох ажиллагаатай холбоотой шинээр орсон нэг чухал ач холбогдолтой зохицуулалт бол худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох дараалал тогтоосон явдал юм. Уг хуулийн 73.2-т “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэд хэдэн гүйцэтгэх баримт бичгийн дагуу гүйцэтгэж байгаа бол ипотекийн эрхтэй этгээд болон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн дарааллаар худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгоно.” гэж заасан нь ипотекийн эрхтэй этгээдийн үүргийг тэргүүн ээлжинд гүйцэтгэх, бусад төлбөр авагчдын хувьд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр шийдвэр гүйцэтгэх



албанд хамгийн түрүүнд хандсан төлбөр авагчийн хувьд төлбөрийн үүргээ худалдан борлогдоогүй хөрөнгөөр тэргүүн ээлжинд хангуулах эрхтэй гэсэн ойлголт юм.

Худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох дарааллыг ийнхүү тодорхой болгож өгснөөр санал болгох ажиллагааны талаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудаас гарах гомдол маргаан буурах ач холбогдолтой.

5. Хөрөнгийн үнэлгээ хэрхэн тогтоогдох нь хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны үр дүнд ихээхэн нөлөөлж байдаг. Тухайлбал 2002 оны хуулиар худалдан борлогдоогүй үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид ямар үнээр санал болгох нь тодорхойгүй байснаас талууд харилцан тохиролцсон нэрийдлээр хөрөнгийн үнийг бодитой бус тогтоох, үүнээс улбаалаад хөрөнгө үнэгүйдэх, төлбөрийн үүргээс хэдахин илүү үнэтэй хөрөнгө төлбөр

авагчид шилжих, эсвэл худалдан борлогдоогүй хөрөнгөөр төлбөрийн үүргийг бүрэн хангуулах боломжгүй болж төлбөрийн зөрүү үүсэх зэрэг сөрөг хандлага байсан бөгөөд хөрөнгө санал болгох ажиллагаатай холбоотойгоор шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудаас гомдол санал их гардаг байсан.

Шинэ хуулиар худалдан борлогдоогүй хөрөнгийг төлбөр авагчид санал болгох үнийг тодорхой болгосноор хөрөнгийн үнийг илүү бодитой тогтоогдох, тэр хэмжээгээр хөрөнгө албадан худалдах болон санал болгох ажиллагаа илүү бодитой явагдах нөхцөл бүрдсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2002 оны хуулиар зохицуулагдаагүй байсан олон харилцааг шинээр зохицуулж, олон зүйлийг тодорхой болгосон боловч цаашид хуулийг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх, хөрөнгө албадан худалдан борлуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй шаардлага практикаас урган гарсаар байна.



ЭРҮҮЛ ОРШИХУЙН БАТАЛГАА БА АВЛИГА



Г.Батнасан

*Шихихутуг ИС-ийн Төр, захиргааны эрх
зүйн тэнхимийн дадлагажигч
багш, магистрант*

Эрүүл мэндийн салбар дах авлигын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Хууль зүйн утгаараа авлига гэдэг нь "энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг" хэлнэ¹

¹ Авлигын эсрэг хуулийн 3-р зүйлийн 3.1 дахь заалт

гэсэн байна. Харин монгол хэлний утга зүйн талаасаа авлига гэдэг үг нь "эдэд шунах, сон бус аргаар юмыг олзолж авах, хээл хахууль"² гэдэг утгатай байна. Хууль зүйн утгаараа "бэлэг гэж нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг" хэлнэ³ хэмээн заажээ.

Монгол хэлний хэл зүйн талаасаа бэлэг гэдэг нь "талархлаа илэрхийлж өгөх юм"⁴ гэж тодорхойлжээ. Монголчууд эртнээс нааш аливаа ажлыг бүтээхдээ бэлэг сэлт барьдаг байсан бөгөөд "авахыг мэдвэл өгөхийг мэд, өгөхийг мэдвэл авахыг мэд" гэх мэт хэлсэн үгсээс үзвэл бэлэг нь заавал хариу хүлээж байдгийг харуулж байна.⁵ Д.Зүмбэрэллхам багш "Албан үүргийнхээ дагуу аливаа эрх олгогдсон этгээд бусдаас хээл хахууль авсаныхаа төлөө өөртөө хувийн матеиаллаг болон материаллаг бус ашиг,

² Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар. УБ.1966 он. 16 дахь тал

³ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 3.1.6 дахь заалт

⁴ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар. УБ.1966 он. 122 дахь тал

⁵ Шударга ёс сэтгүүл 2011 он.№4.50 дахь тал



ашиг хонжоо олох үүднээс тэрхүү боломжоо урвуулан ашигласан, үйлдэл эс үйлдэл, мөн албан үүргээ биелүүлсэнийхээ төлөө хууль бус шан харамж авах, иргэд, хуулийн этгээдийн зүгээс энд дурдсан үйлдэл ба эс үйлдлийг хээл хахууль шан харамж өгөх явдлыг бүхэлд нь авилга⁶ гэж тодорхойлсон байна. Тэгвэл эмч нь албан үүргээ биелүүлсэнийхээ төлөө хууль бус шан харамж авах нь авилгад /бэлэг/ орох нь харагдаж байна.

Иймд дараах тулгамдсан асуудал байна. Үүнд:

1. Эмч, эмнэлэгийн байгууллагын ажилчдын бэлэг сэлт авч болно гэсэн сэтгэхүйн байдал
2. Үйлчлүүлэгч нарын ухамсарын байдал эмч, эмнэлэгийн байгууллагын ажилчдад талархсан сэтгэлээ илэрхийлж бэлэг өгөх ёстой гэсэн байдал
3. Эмч, эмнэлэгийн байгууллагын ажилчдын цалин хангамж муу байгаа нь бэлэг, авлига авах шалтгаан болж байна.
4. Үйлчлүүлэгчдээс өгсөн авлига, бэлэг сэлт үйлчилгээний чанарт нөлөөлдөг тул үйлчлүүлэгч нар авлига өгөх шаардлагатай болдог.
5. Талархсан сэтгэлээ заавал материаллаг байдлаар илэрхийлэх ёстой гэсэн нийгмийн сэтгэхүйн байдал нь бусдад нөлөөлж байгаа нь тулгамдсан асуудал болно.

6. Ёс зүйн хэм хэмжээг баримталдаггүй буюу хүнд суртал

7. Хариуцлагын тогтолцооны механизм муу буюу авилгалаас хүлээх хариуцлага алга

8. Эмчийн хариуцлагын даатгал байхгүй байдал

Эрүүл мэндийн салбар дахь авлигын асуудал шийдлийг гадаадын зарим орнуудтай харьцуулах нь

1. Холбооны бүгд найрамдах герман улс

ХБНГУ нь Эрүүл мэндийн салбарын хөгжил, тогтолцоо, үйлчилгээгээрээ дэлхийн бусад улс орнуудыг тэргүүлдэг. Тус улс нь 82 сая хүн амтай. Түүнээс 4,8 сая нь эрүүл мэндийн салбарт ажилладаг. Эрүүл мэндийн салбарын нийт зардал нь 287 тэрбум евро ба жилд нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардалд 3500 евро зарцуулдаг бөгөөд энэ нь ДНБ-ний 11. 6 хувийг⁷ эзэлдэг байна. Германы эрүүл мэндийн салбарын хөгжил, хууль эрх зүйн орчин нь нилээд эртний уламжлалт тогтолцоотой гэж хэлж болно. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль нь 1883 онд анх батлагдсан бөгөөд одоог хүртэл анхны утга агуулга, хэлбэрээ алдаагүй уламжлан үйлчилж ирсэн байна. Эрүүл мэндийн даатгалын талаар Иргэний тухай хуулиндээ тусгаж өгсөн байдаг.

⁶ Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11 сарын 25ны 446-р тушаалын хавсралтын 4.4 дахь заалт

⁷ Healthcare in Germany. <http://en.wikipedia.org/wiki/>



Германы эрүүл мэндийн салбар нь:

- Эв санааны зарчимд тулгуурласан
- Өөрөө удирдах ёстой
- Урьдчилсан төлбөрт үйлчилгээт системтэй
- Бүх нийтийн хамралтыг хангах зорилготой
- Эрүүл мэндийн яам нь эрүүл мэндийн салбарт гол үүрэгтэй боловч мужууд эмнэлгийн төлөвлөлтийг хариуцах ба тэдгээрийн санхүүжилтыг хариуцах гол үүргийг хүлээдэг.
- Заавал даатгалд 90% нь даатгуулсан байдаг, үлдсэн хэсэг нь хувийн даатгалд даатгуулсан
- Амбулаторын үйлчилгээг эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхээс үргэлж түрүүнд байлгах зорилгыг баримталдаг. Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг Эрүүл мэндийн яам хариуцдаг.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилт: ХБНГУ нь эрүүл мэндийн салбарын зардлаараа дэлхийд 4-т ордог. Америк улс энэхүү үзүүлэлтээрээ 1-т ордог боловч Герман улсын хамрагдалт болон бүх хүнд хүртээмжтэй байдлаараа илүү үр дүнтэй байдаг байна.

Эрүүл мэндийн салбарын зардлын бүтэц:

- Эмнэлгийн байгууллагууд 38.8%

- Эмнэлэг/эмчилгээний хэрэгсэлд/ 18.4%
- Эмч нарт 12.5%

Мөн ХБНГУ нь эмч, эмнэлэгийн байгууллагын ажилчдын авлигын асуудлыг шийдвэрлэхдээ эмнэлэгт хандивын хайрцагыг ажиллуулдаг ба уг хайрцаганд тухайн эмнэлэгээр үйлчлүүлсэн үйлчлүүлэгч нар эмчид болон эмнэлэгт талархсан сэтгэлээ мөнгөн хэлбэрээр илэрхийлж хандив өргөж болдог. Тухайн хандивын хайрцаганд цугласан мөнгө нь нийтэд ил бөгөөд зарцуулалтын тайланг сар бүр гаргадаг байна. Мөн тухайн цугласан мөнгөний 20% ийг тухайн эмч, эмнэлэгийн ажилчдын цалинг хангамжийг нэмэхэд зарцуулдаг ба үлдсэн 80% ийг эмнэлэгийн үйл ажиллагааг сайжруулах тоног төхөөрөмж нэмэгдүүлэхэд зарцуулдаг болно.⁸

2. Бүгд Найрамдах Эстони улс: Сүүлийн 20 жилд Эстони улсын эрүүл мэндийн салбарт маш өргөн хүрээтэй шинэчлэл хийгдсэн бөгөөд туршлагыг нь хуучин зөвлөлтийн улс орнууд идэвхтэй судалж байгаа ажээ. Эрүүл мэндийн салбарын анхан шатны байгууллагуудын чиг үүргийг өргөжүүлэх, эмнэлгүүдийг нэгтгэх, стационар тусламжийн төрөлжилт, үр дүнг нэмэгдүүлэх, амбулаторийн тусламжийг өргөжүүлэх, ажилтнуудын хэрэгцээнд тулгуурлан идэвхжүүлэх удирдлагын шинэ механизмыг нэвтрүүлэх зэрэг нь энэхүү шинэчлэлийн үндсэн

⁸ Synopsys of Germanys Switzelands health system. www.princeton.edu



ололтууд болжээ.

Түүнчлэн шинэчлэлийн гол чиглэл нь уламжлалт нэгдсэн эмнэлгийн тогтолцооноос өрхийн эмнэлгийн загварт шилжсэн явдал юм. Нэгдсэн эмнэлгүүдийн ихэнхийг өрхийн эмнэлэг болгон өөрчилж, тэдгээрийн хөгжилд томоохон хөрөнгө оруулалт хийсэн байна. Нэгдсэн эмнэлгийн эмч байсан мэс засал, зүрх судасны зэрэг нарийн мэргэжлийн эмч нарын зарим нь хувийн эмнэлэг нээж, нөгөө хэсэг нь стационар ба амбулаторийн үзлэгийг хослуулсан эмнэлгийн орон тооны эмчээр ажиллах болсон. 1991 оноос эхлэн нэгдсэн эмнэлгийн эмч нарыг давтан бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх, хэсгийн эмч нарт амбулаторийн нарийн мэргэжлийн эмчийн чиг үүргийг эзэмшүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг өргөжүүлэх, өрхийн эмнэлгийн зарчмаар ажиллах чиглэлийг хэрэгжүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг явуулжээ. Ерөнхий эмчилгээний чиглэлийн эмч нар хүүхэд, насанд хүрэгчдийг эмчилдэг өрхийн эмч нар болжээ. Анхан шатны эмнэлгийн тусламжийн байгууллагын шинэ институци бүрдүүлэх зорилт шинэчлэлийн эхний 10 жилийн хугацаанд биелэлээ олжээ.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилт

Эстоний эрүүл мэндийн салбарт улсын санхүүжилт давамгайлдаг ба улсын санхүүжилтын тогтолцоо нь эрүүл мэндийн даатгалын зарчимд

суурилдаг. Эстоний эрүүл мэндийн даатгалын фонд нь даатгуулагчдын төлөө эрүүл мэндийн үйлчилгээг худалдан авагч гол байгууллага юм. Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг хийх улсын орлогын ихэнх хувь нь хөдөлмөрийн хөлснөөс суутгах нийгмийн татвар (13%) болон улсын төсвөөс төлдөг нийгмийн татвараас бүрддэг.

Бүгд Найрамдах Эстони улсад бүх эмч мэргэжилтнүүд улсын ба хувийн хэвшилд үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран Эстоний эрүүл мэндийн даатгалын фондтой гэрээ байгуулан ажиллаж, гэрээний үндсэн дээр санхүүжилт авдаг байна. Тус улсын эрүүл мэндийн салбарын шинэчлэл, санхүүжилтын үйл явцад олон янзын саад бэрхшээл учирч байгаа хэдий ч олон улсын байгууллагын шинжээчдын Европын Холбооны 27 улс мөн Швейцар, Норвеги, Хорват, Македонийн эрүүл мэндийн тусламжийн байдлыг шинжилсэн дүгнэлтээр Эстоний эрүүл мэндийн салбар Европын шилдэг тогтолцоотой орны тоонд шалгарч, 6 ангилал, 34 үзүүлэлтээр 1000 оноо авахаас 669 оноогоор 10 дугаар байрт жагссан байна. Авлигын асуудлаас төрийн санхүүжилтын үр дүнд сэргийлж чаддаг болно.⁹

⁹ Health Consumer Powerhouse (HCP)



3. Бүгд Найрамдах Молдав улс

Эрүүлийг хамгаалахын санхүүжилтын талаар: Улсын эрүүлийг хамгаалах байгууллагуудын санхүүгийн эх үүсвэр нь эрүүл мэндийн заавал даатгалын хөрөнгө /Эрүүл мэндийн даатгалын үндэсний компани, түүний нутаг дэвсгэрийн салбартай эрүүл мэндийн тусламжийг санхүүжүүлэх тухай байгуулсан гэрээг үндэс болгон/, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийн хэлбэрээр хуваарилсан төсвийн эх үүсвэр, ивээн тэтгэгчдийн хандив, тэтгэлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэхээр хуульчилсан байна. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилттай төрийн өмчийн эрүүлийг хамгаалах байгууллагын үйл ажиллагаа нь ашгийн бус хэлбэрээр өөрийгөө санхүүжүүлэх зарчимтай байна. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт нь төлбөртэй үйлчилгээ, хуулиар хориглоогүй бусад санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ. Эрүүл мэндийн орон нутгийн төв байгууллага нь тухайн жилийн улсын төсөвт эрүүлийг хамгаалахад төсөвлөгдсөн хөрөнгийг төвлөрүүлэн түүний дотор салбарын зорилтот төслүүдийг хэрэгжүүлэхээр харьяа байгууллагуудад хуваарилах эрх эдэлнэ. Үндэсний эрүүл мэндийн даатгалын компанитай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх талаар байгуулсан.

Төрийн болон хувийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг, эрүүл ахуйн үйлчилгээ үзүүлэх тарифыг тогтоох аргачлал, төрийн өмчийн эмнэлэг, эрүүл ахуйн байгууллагын төлбөртэй үйлчилгээний нэгдсэн тариф, төрийн болон хувийн өмчийн эмнэлэг, эрүүл ахуй байгууллагын эрүүл мэндийн албан журмын даатгалын сангаас төлөгдөх үйлчилгээний нэгдсэн тарифыг Эрүүл мэндийн яам боловсруулж оруулснаар Засгийн газар батлахаар зохицуулсан байна.

Дүгнэлт, санал

Эрүүл мэндгүй бол Монгол хүнгүй болно. Монгол хүнгүй бол эд баялаг хэнд ч хэрэггүй. Иймд улсын маань гол баялаг болсон эрүүл Монгол хүний төлөө төр засаг тэмцэх ёстой. Иймээс Монгол Улсын Эрүүл мэндийн салбарын бүх шатанд шинэчлэл-өөрчлөлт хийж сайжруулах нэн шаардлагатай байна. Нийгмийн суурь үйлчилгээний нэг бол яахын аргагүй эмнэлийг үйлчилгээ юм. Хүний эрүүл мэндийг хамгаалж байдаг эрүүл мэндийн салбарт сүүлийн үед авлигын асуудал тулгамдаад байна. Иймд судлаач миний бие дараах тулгамдсан асуудлыг тодорхойлсон билээ.

1. Эмч, эмнэлэгийн байгууллагын ажилчдын бэлэг сэлт авч болно гэсэн сэтгэхүйн байдал
2. Үйлчлүүлэгч нарын ухамсарын байдал эмч, эмнэлэгийн байгууллагын ажилчдад талархсан сэтгэлээ илэрхийлж



бэлэг өгөх ёстой гэсэн байдал

3. Эмч, эмнэлэгийн байгууллагын ажилчдын цалин хангамж муу байгаа нь бэлэг, авлига авах шалтгаан болж байна.
4. Үйлчлүүлэгчдээс өгсөн авлига, бэлэг сэлт үйлчилгээний чанарт нөлөөлдөг тул үйлчлүүлэгч нар авлига өгөх шаардлагатай болдог.
5. Талархсан сэтгэлээ заавал материаллаг байдлаар илэрхийлэх ёстой гэсэн нийгмийн сэтгэхүйн байдал нь бусдад нөлөөлж байгаа нь тулгамдсан асуудал болно.

Гадаадын зарим орнуудын эрүүл мэндийн салбарын санхүүжилтын асуудлыг судласан юм. Үүнээс дүгнэхэд:

- Эрүүл мэндийн салбарын санхүүжилтэнд (иргэдийн шууд төлбөр, заавал даатгалын сан бүрдүүлэхэд иргэдийн оролцоо, эрүүл мэндийн сайн дурын даатгал) хувийн мөнгө хөрөнгийг оруулах болон төрийн бус эмнэлгийн тусламж үзүүлэгч хувь хүн, байгууллагын улсын хөтөлбөрийн хэрэгжилтэнд оролцохыг хууль эрх зүйн актаар зохицуулдаг.
- Өндөр хөгжилтэй орнуудад нийгмийн эрүүл мэндийн ямар тогтолцоотойгоос үл хамааран (улсын хангамж эсхүл нийгмийн даатгал) ер нь тусдаа орших эрүүл мэндийн үйлчилгээний хувийн хэвшлийн

тухай яригддаггүй. Тухайлбал, Европын Холбооны улсуудад эрүүл мэндийн үйлчилгээ болон түүний санхүүжилт, нийгмийн болон хувийн холимог (public-private mix) хэлбэр зонхилдог байна.

- Практик дээр эрүүл мэндийн аль ч тогтолцоо дан ганц эх үүсвэрээс санхүүжих нь ховор байдаг. Эрүүл мэндийн салбарын орлого, санхүүжилт нь улсын болон хувийн эх үүсвэрээс зэрэг санхүүждэг ба тэдгээрийн харьцаа нь улс бүрийн онцлогоос хамааран ялгаатай байна.

Иймд судлаач миний бие дараах саналтай байна:

Хууль эрх зүйн хүрээнд хийгдэх ажлууд:

1.Эмч эмнэлгийн ажилтнуудын цалинг нэмэх, урамшуулын системтэй холбох

Судалгаанд оролцогсдын 85.9 хувь нь эмч эмнэлгийн ажилтнуудын цалин орлого бага учраас авилгад өртдөг гэж үзсэн байна. Цалинг нэмбэл авилгатай холбоотой асуудал багасна гэж судалгаанд хамрагдсан эмч эмнэлгийн ажилтнуудын 51 хувь нь бүрэн санал нийлсэн бол 33.3 хувь нь зарим талаараа тийм гэжээ. Цалинг доод тал нь 800- 900 мянган төгрөг болгох хэрэгтэй гэж үзэж байна. Мөн экспертэд оролцсон олон эмч ажилтнууд урамшууллын асуудлыг тавьж байв.¹⁰ Тиймээс эмч,

¹⁰ “Эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын нөхцөл байдал судалгаа” 2017 он..., УБ хот



эмнэлэгийн ажилчдын цалинг нэмэх шаардлагатай. Нэмж чадвал авлига авах явдал багасна.

Төрийн байгууллагын эмч, эмнэлэгийн ажилчдын цалинг дараах байдлаар нэмэх саналтай байна.

- Нэгдүгээр шатлалын эмч, эмнэлэгийн байгууллагын ажилчдын цалинг 100—200 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх
- Хоёрдугаар шатлалын эмч эмнэлэгийн байгууллагын ажилчдын цалинг 300—400 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх
- Гуравдугаар шатлалын эмч эмнэлэгийн байгууллагын ажилчдын цалинг 500—600 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг тус тус гаргаж байна.

Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд:

1. Хүртээмж чанарыг сайжруулах:

Үйлчилгээний чирэгдэл, хүнд суртал нь дан ганц эмнэлэг болоод эмч, ажилтнуудаас хамаарахгүй ч энэ нь хүмүүсийг албан бус төлбөр болон бусад арга саам эрэлхийлэхэд хүргэдэг. Үүнийг эрүүл мэндийн салбар дахь авилгын хамгийн гол шалтгаан хэмээн олон нийт /64.9хувь/ үзсэн байна. 46.2 хувь чирэгдэл ихтэй учраас гар цайлгадаг гэж хариулжээ. Бүс нутаг,

дэд бүтцийн тэнцвэргүй хөгжил томоохон сөрөг хүчин зүйл болон гарч ирж байна. Иргэдийн дийлэнх хэсэг нь сайн үйлчилгээ авахын тулд юуны түрүүн Улаанбаатар болон томоохон хотууд руу цувж, ачааллыг хэд дахин нэмэгдүүлдэг нь үйлчилгээний хүртээмжийг хомсдуулж, чирэгдэл болоод албан бус харилцааны элдэв сүлжээг ердийнхөөс нь хэд дахин ихэсгэж байна.

2. Авлигын эсрэг мэдээлэл, сургалтыг өргөжүүлэх: Эрүүл мэндийн салбар дахь авлигын эсрэг сургалт сурталчилгаа, чухал гэж олон нийтийн 15.6 хувь нь, эмч эмнэлгийн ажилтнуудын 14.0 хувь нь хариулсан бөгөөд энэ нь дээрээсээ гуравт сонгогдсон байна. Мөн үнэн зөв мэдээлэл түгээх нь дээрхээс ч илүүтэй чухал гэж үзжээ. Боловсрол, ерөнхий боловсрол болон их, дээд сургуулийн хөтөлбөрт авлигын эсрэг сэдэв оруулах нь чухал гэж үзэж байна. Авлигыг үл тэвчих, жигших сэтгэл зүйн орчин, дадал зуршлыг иргэдэд бүр багаас нь төлөвшүүлэх явдал бол нүдэнд үл үзэгдэх атлаа авлигатай тэмцэхэд ихээхэн чухал нийгэм- соёлын хөрс суурь юм.



ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА



Д.Очмаа

Шихихутуг ИС-ийн магистрант

Манай улсын эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн өөрчилж үйлчлүүлээд төдийлөн удаагүй байна. Эрүүгийн эрх зүйн энэ шинэчлэлийн хүрээнд судлаачдын зүгээс уг салбарт эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг эрчимжүүлэх нь үр дүнтэй гэж үзэх болсон байна. Монгол улсын хувьд “Эвлэрүүлэн зуучлалын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “иргэний эрх зүйн маргаан, хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон гэр бүлийн эрх

зүйн маргаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэнэ” гэж заасан байдаг. Энд дурдсан маргаан нь иргэний процессын эрх зүйн хүрээнд шийдвэрлэдэг маргаан юм. Учир нь тус хуулийн 3.2-т “...бусад харилцаанаас үүссэн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэглэж болно” гэжээ.

Тиймээс эрүүгийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах шаардлага байгаа эсэх, хэрэв байгаа бол хэрхэн яаж шийдвэрлэх арга замын талаар ажиглалт судалгаа хийж зарим дүгнэлт, санал гаргахыг хичээв.

“Эвлэрүүлэн зуучлах гэдэг нь зуучлагчийн оролцоотойгоор маргалдагчталуудаддэмжлэгүзүүлэх зорилго бүхий системчлэгдсэн арга хэрэгслийг ашиглан, маргаанаа ухаалгаар зохицон шийдвэрлэх зорилго бүхий сайн дурын үйл ажиллагаа” бөгөөд шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх арга юм.

Эвлэрүүлэн зуучлал нь талууд өөрсдийн хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэн маргааныг зардал багатайгаар хурдан шуурхай, аль аль талдаа сэтгэл ханамжтай шийдвэрлэх боломжийг олгодог. Энэхүү мөн чанараараа эвлэрүүлэн



зуучлах ажиллагаа улс, бүс нутаг, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх болсон юм. Монгол улсын статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас гэмт хэргийн улмаас учирсан хохирол болон нөхөн төлүүлсэн хэмжээг сүүлийн 6 сарын байдлаар харахад 11%-23%-тай байжээ.

Эрүүгийн хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэх нь хохирогч болон гэмт хэрэг үйлдсэн этгээдэд аль алинд нь ашиг тустай байх учиртай. Хохирогч шүүх хуралдаанд үүрэг багатай төдийгүй шүүхийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй, харин эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаанд гол үүрэгтэй оролцдог олон жишээ туршлага бий. Манай улсын эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд хохирогчийн оролцох үүрэг бага байдаг. Хохирогч эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн хохирол хүлээдэг атлаа хохирлоо нөхөн төлүүлж, эрхээ хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээх талаар харьцангуй бага хамгаалалт хүлээдэг.

Тухайлбал Эрүүгийн хуулийн 16.1 дүгээр зүйл "Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах" гэмт хэрэгт хохирогч эрүүл мэндээрээ хохирсон үед эмчилгээний зардал, бусад зардлыг гаргуулах нотлох баримт нь хуульд заасан олон янзын шаардлага хангасан, заавал бичгээр бүрдүүлсэн байх ёстой. Гэтэл ихэнх нотлох баримтыг хохирогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч

нар бичгээр баталгаажуулж авдаггүй, авсан ч тэр нь шаардлага төдийлөн хангадаггүй, мөн шүүгч нотлох баримтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар "...нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн гүйцэд, нягт нямбай, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр өөрийн дотоод итгэлээр үнэлнэ" гэсэн шалгуурыг давахад хүнд. Түүнээс шалтгаалж хохирлоо бүрэн барагдуулж чаддаггүй, шүүхийн шийдвэрт гомдолтой үлддэг. Мөн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт, жишээлбэл Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл "Хулгайлах" гэмт хэргийн тухайд хэдийгээр шинжээч томилж, эд зүйл, хөрөнгийн үнэлгээ гаргуулдаг боловч тэр нь хэрэг дээрээ бодитой гардаггүй бөгөөд хохирогч гомдолтой үлддэг. Хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл ногдуулах нь хохирогчийг гомдолгүй болгох нэг үндэслэл боловч гол нь гэж үзэхэд хүндрэлтэй.

Мөн яллагдагч, хохирогч нарын ихэнх нь төлбөрийн чадваргүй, тэгээд ч өмгөөлөгчдийн хууль зүйн туслалцаа үзүүлэх хөлс өндөр байдгаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд санхүүгийн хувьд бэрхшээл үүсдэг. Шүүх гэм буруугийн улмаас учирсан хохирлыг барагдуулахдаа хохирогчийн нэхэмжилсэн өмгөөлөгчийн хөлсийг тэр бүрчлэн хангаж шийдвэрлэдэггүй бөгөөд харин энэ талаар иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг



дурдаж шийдвэрлэдэг. Гэвч хохирогч, тэдгээрийн өмгөөлөгч иргэний шүүхэд нэхэмжлэл гаргахад цаг хугацаа, зардал гардаг тул энэ талаар тэр бүр цаашид ханддаггүй.

2002 оны "Эрүүгийн байцаан шийтгэх хууль"-д тусгагдсан хөнгөн гэмт хэргийн хохирогч нь яллагдагчтай эвлэрч, учруулсан хохирлоо барагдуулснаар эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалт нь өнөө үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой тусгаагүй бөгөөд гэхдээ гэм буруугаа хүлээсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагатай холбоотой шинэлэг зохицуулалт орсон байна.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд /17-р бүлэг/ "Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэд нэрлэж болоно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "... хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх тухай хүсэлтэнд хохирлоо нөхөн төлсөн баримт, нөхөн төлөхөө баталж хохирогчтой эвлэрсэн тухай баримтаа хавсаргана" гэж заасан нь хохирогчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад сүхий нөлөөлөх учиртай.

Түүнчлэн шүүх хуралдаанаар гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн эсэх нөхцөл байдлыг тодруулан хянахаар зааж, энэ талаар гаргасан шүүгдэгч, түүний хууль ёсны

төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүх хуралдааныг завсарлуулж болохоор тус тус зохицуулсан. Үүнтэй холбоотой эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхээр хэргийг прокуророос шүүхэд шилжүүлэхэд гэмт хэрэг үйлдсэн этгээд хохирогчид заавал хохирол, төлбөрийг барагдуулсан байх, хохирлоо барагдуулахаа илэрхийлсэн байх гэсэн хуулийн шаардлага тавигддаг болов. Гэтэл практикт гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлдэг "Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах, /ЭХ 11.6/, "Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах" /ЭХ 11.4/ зэрэг хэрэгт хохирогч, тэдгээрийн өмгөөлөгчдийн зүгээс хуулийн энэ зохицуулалтыг ашиглан яллагдаж байгаа этгээдээс эмчилгээний зардал, эрүүл мэндийн хохиролд хэт их хэмжээний мөнгө төлөхийг шаардаж авдаг нь нууц биш. Гэмт хэрэг үйлдсэн этгээд ч хүссэн хэмжээнийх нь мөнгийг өгөхгүй бол хэрэг маань шийдэгдэхгүй удаашрах, ял хөнгөрүүлэх нөхцөлд орохгүй байх, хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэхгүй байх үндэслэл болно гэж үзээд аль болох хохирогчийн хэлсэн хохирлын төлбөрийг хүлээн зөвшөөрөх нь олонтой. Тэгээд ч Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийг хэрэглэх гол нөхцөл болсон "учруулсан хохирол" гэсэн ойлголт нь тодорхой биш байгаатай холбоотой гэж үзэж байна. Эрүүгийн хуулийн 6.7



дугаар зүйлд "... гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж, эсвэл учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол..." гэдгийг дээрхтэй уялдуулан онцолж байна.

Сүүлийн жилүүдэд Эрүүгийн эрх зүйн хүрээнд үүссэн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх хандлага улс, орнуудын түвшинд ихсэж байна. Тухайлбал Австрали, Шинэ Зеланд, АНУ зэрэг улсад эрүүгийн хэргийн эвлэрүүлэн зуучлах институтийг бие даасан байдлаар зохион байгуулсан байдаг байна. Эдгээр улс орон дахь институт нь "хохирогчтой эвлэрүүлэх замаар гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх" жишигт суурилсан байдаг байна. Дээрх улсуудад хөнгөн гэмт хэрэг, насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг, эд хөрөнгөтэй холбоотой гэмт хэргүүдийг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэдэг хандлага байна. Дээрх гэмт хэргүүдийг хянан шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлал амжилттай хэрэгжиж байгаа тул зарим төрлийн хүнд гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд эвлэрүүлэн зуучлалыг нэвтрүүлэх боломжтой гэж үзэх судлаачид байна. Тухайлбал, хүн амины гэмт хэрэг, хүчиндэх гэмт хэрэг, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөнөөс хүний амь нас хохирох зэрэг хэргүүдэд хэрэглэх нь зүйтэй гэжээ.⁹ Судалгааны үзүүлэлтээр гэмт хэрэг үйлдсэн этгээд эвлэрүүлэн зуучлалд оролцсоноор эвлэрүүлэн зуучлалд оролцоогүй этгээдтэй харьцуулахад

хохирогчийн гомдлыг барагдуулсан үзүүлэлт өндөр байжээ. Тодруулбал эвлэрүүлэн зуучлалын 95 хувьд гэмт хэрэг үйлдсэн этгээд ба хохирогч нь хохирол нөхөн төлүүлэх гэрээ байгуулдаг байна.

Ихэнх улсад гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэхэд анхаарч ирсэн бөгөөд хохирогчийг орхигдуулсан, бага анхаарал хандуулж ирсэн байдаг байна. Япон улс нь эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа нь нилээн боловсронгуй бөгөөд манай улс иргэний хэрэгт энэ үйл ажиллагааг хэрэглэхдээ нилээдгүй олон зохицуулалтаас нь санаа авсан байдаг. Японы эрх зүй дэх Jidan буюу иргэн, эрүүгийн хэрэгт хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлөх шүүхээс гадуурх тохиролцоо гэж байдаг. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээд хариуцагчийн зүгээс уучлалт хүсч, төлбөр өгөх саналыг хохирогч хүлээн зөвшөөрөх явдал хамаарна. Эрүүгийн хэрэгт Jidan нь хүчинтэй байсан ч, эрүүгийн процесс нь ердийн журмаар үргэлжилнэ. Өөрөөр хэлбэл Jidan гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял шийтгэлийг хөнгөрүүлэх ач холбогдолтой.

Эрүүгийн хэрэгт эвлэрүүлэн зуучлалын талууд нь маргагч талууд байдаггүй, харин хохирогч гэмт хэрэг үйлдсэн этгээд байх тул гэм буруугийн талаар маргадаггүй, зөвхөн хохирол төлбөртэй холбоотой асуудлаар хэлэлцэн тохиролцдогоороо давуу талтай байдаг байна. Мөн гэмт



хэрэг үйлдсэн этгээдийн хувьд хохирогчоос уучлалт гуйх, нийгэмд тустай хөдөлмөр эрхлэх, хохирол барагдуулах зэргээр гэмт хэрэг үйлдсэн этгээд идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг байна.

Монгол улсын эрүүгийн хуулинд 95 төрлийн гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэрэгт хамаарах бөгөөд эдгээр гэмт хэргийг шүүхийн бус журмаар буюу эвлэрүүлэн зуучлал хэрэглэж шийдвэрлэх боломжтой юм.

Манай улсын нийт хуульчдын 40 орчим хувь нь шүүгч, прокурор, өмгөөлөгч нар байна. Тиймээс үлдсэн хувьд эзлэх өмгөөлөгчдөөс эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулах боломжтой байна. Гэвч манай улсад 2011 оноос хойш нийт 7 удаагийн эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалтаар улсын хэмжээнд нийт 700 гаруй эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэжээ.

Энэ бүгдээс дүгнэхэд манай улсад эрүүгийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг нэвтрүүлэх хэрэгцээ байна. Энэ нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлөлт хангалтгүй байгаатай холбоотой. Мөн хохирогчийн өөрийн хүссэн хэмжээгээрээ, бодит байдалд нийцэхгүй хэмжээний хохирол төлбөрийг гаргуулахгүй байх, гэмт хэрэг үйлдсэн этгээд, хохирогч хоорондын харилцан гомдолгүй байх зэрэг асуудлыг шийдвэрлэх нөхцөл болно. Шинээр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулинд эвлэрүүлэн зуучлал хэрэглэх тусгайлсан зохицуулалт

байхгүй ч хуульд дүн шинжилгээ хийх замаар эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулж болох хэрэг маргааныг төрлийг тодорхойлох боломжтой юм. Тухайлбал Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулинд эвлэрүүлэн зуучлалын тусгайлсан зохицуулалт байхгүй ч "Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т "...эвлэрүүлэх үйл ажиллагаа явуулах нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарч байгаа юм" гэжээ. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулинд тодорхой тусгах шаардлагатай. Энэ зүйл заалтын учруулсан хохирол гэдгийг яг яаж ойлгох нь хуулийн тайлбарт байхгүй байгаа бөгөөд энэ ойлготыг нэг мөр болгох шаардлагатай. Дээр дурдсан эвлэрүүлэн зуучлагчдын дунд эрүүгийн эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулах арга зүйн сургалтыг явуулж, энэ чиглэлээр дагнасан эвлэрүүлэн зуучлагчдыг бэлтгэх боломж харагдаж байна. Цаашид эрүүгийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулах эрх зүйн болон зохион байгуулалтын асуудлыг бусад улс орны туршлага дээр тулгуурлан нарийвчлан судлах шаардлагатай байна.



“ЭС ҮЙЛДЭХҮЙГЭЭР ИЛРЭХ АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ”

/Хууль тогтоох процессын хүрээнд/



Т.Нарандэлгэр

Шихихутуг ИС-ийн 4-р курсын оюутан

Оршил

*Хууль нь хамгийн чухал, хэвшсэн
Харилцааг зохицуулдаг ард түмний
Нийтлэг хүсэл эрмэлзлийн актууд юм.
Ш.Л.Монтескье, ж.Ж. Руссо*

Нийгмийн харилцааг зохицуулах зорилттой хууль нь ард түмний ашиг сонирхлыг нэн тэргүүнд илэрхийлэн хамгаалдаг байх ёстой. Тиймдээ ч хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж буй албан тушаалтан өөрөө нийтийн ашиг сонирхолд нийцсэн хууль батлах үүрэгтэй буюу хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдөн батлах ёсгүй

хуулийг батлах буюу батлах ёстой хуулийг батлахгүй байж болохгүй.

Монгол улс сүүлийн жилүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй эрчимтэй тэмцэж олон улсын “Транспаренси” байгууллагаас гаргадаг авлигын төсөөллийн индексийг бууруулсан боловч одоог хүртэл эрсдэл өндөртэй улсуудын тоонд багтсаар¹ байгаагаас гадна ашиг сонирхлын зөрчлийн индексийг тогтоох судалгаа хийгдээгүй байна. Одоогийн байдлаар нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийн эсрэг арга хэмжээнүүд авч, үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч хүний амьдралын бүхий л үе шатыг зохицуулдаг хуулийг батлах процесс нь ашиг сонирхлын зөрчилгүй явагдсан гэдэг нь эргэлзээтэй байгаа бөгөөд хууль тогтоох процесс дахь ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх механизм учир дутагдалтай хэвээр байна.

Судалгааны ач холбогдол:

Хууль тогтоох процессыг эрх зүйн хүрээнд ашиг сонирхлын зөрчлөөс хамгаалж чадсанаараа нийтийн ашиг сонирхолд нийцсэн, зөв хуулийг баталж, хууль тогтоогчид өөрсдийн ашиг сонирхолдоо нийцүүлэн тодорхой харилцааг зохицуулахгүй үлдээхээс ч сэргийлэх боломжтой юм.

¹ 2016 оны судалгаагаар Монгол улсын авлигын индекс 38 хувьтай гарсан байна.



Энэхүү судалгаагаар хууль тогтоох процесс төдийгүй хууль тогтоогч нартай холбоотой одоогийн эрх зүйн зохицуулалт дахь ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлсэн заалтуудын дутагдалтай талыг илрүүлж цаашид оновчтой зохицуулалт хийхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

Судалгааны зорилго: Монгол улсын хууль тогтоох процесс дахь ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэж буй аргачлалыг парадигмын түвшинд нь судлаж, эс үйлдэхүйгээр илрэх ашиг сонирхлын зөрчлийн эсрэг оновчтой зохицуулалтыг эрэлхийлэхэд оршино.

Судалгааны арга зүй: Судалгааг шинжлэх ухааны судалгааны арга болох харьцуулалт, түүхчлэх, статистик, тохиолдол шинжлэх, мөн хууль зүйн шинжлэх ухаанд түлхүү хэрэглэгддэг анализ, синтез, индукц, дедукцийн аргуудад голчлон тулгуурлаж гүйцэтгэсэн болно.

Судлагдсан байдал: Хууль тогтоох процесс, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх аргачлал зэргийн талаар академик болон практикийн хүрээнд багагүй судлагдсан боловч эс үйлдлээр илрэх ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх аргачлалтай холбоотой нь дутмаг байна.

Нэг. Монгол улсын ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх механизм

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хүн төрөлхтөн өнөөг хүртэл олон янзын арга замуудыг сонгон ашиглаж ирсэн бөгөөд орчин үед түүнтэй тэмцэх олон улсын болон үндэсний

механизмуудыг хөгжүүлэн ажиллуулж байна. Олон улсын механизмд оффшор дансны ил тод байдал, олон улсын хараат бус шинжилгээ хийж тайлан гаргах, авлигын хэрэгт холбогдсон албан тушаалтанд улс төрийн орогнол олгохгүй байх зэрэг олон төрлийн аргууд багтдаг бол улс бүрийн үндэсний механизмууд харилцан адилгүй, онцлогтой байдаг. Монгол улс 2007 онд Авлигатай тэмцэх газрыг байгуулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталсан нь ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх механизмын хөгжилд зохих хувь нэмэр оруулсан гэж судлаачид үнэлдэг.

Ашиг сонирхлын зөрчил гаргах сэтгэл зүйн хандлага, сэдэл, үндэслэл нь үндэстэн бүрийн менталитет², уламжлалт сэтгэлгээтэй салшгүй холбоотой. Аливаа улс, үндэстний олон зуун жилийн туршид төлөвшин тогтсон тэрхүү сэтгэлгээ нь үл ухамсарлахуйгаар илэрч, нөхцөл байдал бүрт үзүүлэх хариу үйлдлээр нь тодорхойлогддог. Тиймээс үндэсний хууль тогтоомж нь гадаад орнуудын жишгийг тусгахын сацуу тухайн ард түмний менталитет сэтгэлгээг харгалзсан байх ёстой. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх монголчуудын сэтгэлгээ хэрхэн төлөвшсөнийг түүхэн баримт бичгүүд болон ардын аман зохиол

² Аливаа улс үндэстний түүх хөгжиж ирсэн нөхцөл, газар зүйн өөр өөр байдлаас ялгаатай үзэл бодол зан үйл төлөвших



бүрнээ илэрхийлэх юм.

Түүхэн уламжлал

Ашиг сонирхлын зөрчлийг хориглох хэм хэмжээний түүхэн уламжлалыг тоймчилвол анхны бичмэл эрх зүйн эх сурвалж болох "Их засаг" хуулийн 16 дугаар зүйлд: "Дайн байлдааны үед олзонд бүү шунагтун. Байлдаан дууссан хойно хуваалцах хэрэгтэй", 19 дүгээр зүйлд: "Байлдааны талбарт нөхдийнхөө буюу дайн байлдааны олзыг хулгайлагсдыг алах ялаар шийтгэнэ"³ гэж заасан бөгөөд энэ нь тухайн үедээ нийтийн ашиг болж байсан олзыг хувьдаа авахыг хориглосон заалт байна. Монголчуудын ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх механизм нь хууль, хэв хуулиас илүүтэй хүмүүжилд⁴ тулгуурладаг байсан бөгөөд хүмүүжлийн зарчим, чиглэлд эхэн үеийн язгуур уламжлал, бөөгийн шашны сургааль, номлол давамгайлдаг байжээ. Ийнхүү төлөвшиж байхад тус сэтгэлгээнд XIII дугаар зуунаас эх авсан буддизмын⁵

³ Ням-Осор.Н "Эзэн чингис хааны Их засаг хууль", УБ., 2010 он 85 дэхь тал

⁴ Хүмүүжил гэдэг нь ардын аман зохиол, уран зохиол, зүйр цэцэн үг, уламжлал, зан заншлын хэм хэмжээн дээр тулгуурладаг байжээ. Жишээ нь: "Ард олны ашиг өндөр тэнгэртэй адил, Амин хувийн ашиг өвсний шүүдэртэй адил" гэсэн нь аливаа үйл ажиллагаандаа нийтийн ашиг сонирхол, зан суртахууны хэм хэмжээг тэргүүн ээлжинд тавьдаг байсан нь харэгдэж байна.

⁵ XIII зууны үед төвдийн шүлэгч Сажу бандидын зохиосон Субашид монгол хэлэнд олон удаа орчуулагдаж, ихэд дэлгэрсэн байна. Энэхүү зохиолд ашиг сонирхлын зөрчил гаргаж болохгүй талаар дараах байдлаар сургасан байна. "№32 Эрдэмтэй болоод сайн хүнийг ноён болговол, Үүрд хэрэг үйлс бүтээд, нийтээр амаржьюу. Ээрлийг хангагч чандманы тугийн үзүүрт тахивал, Энэ насны хүсэл бүгдийг хангах хэмээн алдаршсан мэт." Энэ нь улсын дээд албан тушаалтан нь

сургааль XV дугаар зуунаас эхлэн хүчтэй нөлөөлөх болсон байна. Харин Их Засаг хуулиас хойших бичмэл эх сурвалжуудад⁶ ашиг сонирхлын зөрчлийг шууд хориглон зохицуулсан заалт цөөн байна. Сүүлд Дэлхий дахин даяршихийн хирээр Монгол улсад барууны улс орнуудын үзэл сэтгэлгээ нэвтэрч, нөлөөлж эхэлсэн. Социализмын үед ашиг сонирхлын зөрчлийн эсрэг агуулга бүхий зохицуулалтыг "БНМАУ-ын депутатын тухай хууль"⁷-инд оруулсан бөгөөд Оршил⁸ хэсэг болон хуулийн 9-р зүйлд⁹

нийтийн сайн сайхны төлөө үйл ажиллагаагаа явуулах ёстойг сургасан шинжтэй байна.

⁶ Монгол- Ойрадын хуулинд: "Отгийн ахлагч өөрийн ялгал үгүй нийтийг асар гэв. Асрах аргагүй болхул дээр мэдүүл гэв. Асралтай байтал эс асрав гэм, хүн үхэв гэм хүний цаазаар болтугай. Зөвтэй, буруутай үхсэнийг шүүж мэдье."

Монгол улсын хууль зүйлийн бичгийн Тэргүүн дэвтрийн 6-р зүйлд: "Зэрэг залгамжлуулахад хуурмаглан хөвгүүнгүй хэмээн мэдүүлэхээр ирэх нь. Аливаа ван, бэйл, бэйс, гүн, засаг тайж нарын зэргийг залгамжлуулахад хөвгүүн буй бөгөөд хөвгүүнгүй хэмээн хуурмаглан баталж мэдүүлбэл харьяат засгийн ван, тайж нар бас хушууны хэргийг туслан ялгагч тайж нарыг цөм хушууны хэргийг ялгах тушаалаас байлгаад нижгээд жилийн пүнлүүг нь тасал."

Халх журмын 47.13-т: "Ер төр барьсан сайд хэргийн тул занчваас ба харааваас ялгүй. Шоглож занчаад яс эвдэрвээс, мах арьс улайваас, хөхөрөөс энгийн цаазын ёсоор торго." Энэхүү заалт нь төрийн албан тушаалтан энгийн хүнийг өөрийн ашиг сонирхлын төлөө гэмтээж болохгүй гэсэн агуулга бүхий байна.

⁷ "БНМАУ-ын хуулиуд 1-р боть", УБ., 1980 773 дэхь тал

⁸ Депутат ард түмнээс тавьсан шаардлагын хэмжээнд ямагт байж бүхий л үйл ажиллагаагаараа төрийн эрх барих байгууллагын үүрэг зорилт, сонгогчдын хүсэл зориг, захиа даалгаврыг хэрэгжүүлснээр, тэдний итгэл найдварыг ханган биелүүлнэ.

⁹ 9-р зүйл: "Сонгогчдын итгэл найдварыг хөсөрдүүлж, Депутатын нэр алдарт харш явдал гаргасан депутатыг хуульд заасан журмаар сонгогчдын олонхийн шийдвэрээр хэзээ ч огцруулж болно."



тус тус заасан байна. Харин Монгол улс ардчилсан нийгэм рүү шилжсэний дараа ашиг сонирхлын зөрчил гэж тодорхойлсон зохицуулалт бий болж 1996 оны "Авлигын эсрэг" хууль, 2012 оны "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулиар тус тус зохицуулж байна.

Ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх орчин үеийн зохицуулалт

Ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх үндэсний эрх зүйн тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хууль¹⁰, дагнасан органик хууль¹¹, салбар бүрийн холбогдох нарийвчилсан хэм хэмжээ заалтуудаас бүрдэг. Үүнээс хууль тогтоох процесс дэх сонирхлын зөрчилтэй холбогдох нийт 4 хуулийн¹² 17 зүйлийн 61 заалт байгаагаас 14 нь үйл ажиллагаанд баримтлах зарчмын шинжтэй, 47 нь үйлдлээр илрэх ашиг сонирхлын зөрчлийг хориглосон гэж хэлж болохоор агуулгатай боловч эс үйлдлээр илрэх ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой заалт алга.

Улсын их хурлын гишүүдийн баталсан хууль нь Монгол улсад ажиллаж амьдарч байгаа иргэд, үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн хувь заяатай салшгүй

холбоотой. Тэрхүү хууль тогтоогчид үйл ажиллагаандаа буюу хууль тогтоох процессд баримтлах нийтийн ашиг сонирхлыг дээдэлсэн зохицуулалт байгаа нь авууштай зүйл хэдий ч хэт ерөнхий заалт нь тус процессд ашиг сонирхлын зөрчил гарахгүй байх баталгаа болохгүй. Түүнчлэн, хууль тогтоогчдийн эс үйлдлээр илрэх ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж чадаагүй байгаа нь Монгол улсын ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх өнөөгийн зохицуулалт учир дутагдалтай байсаар байгааг илтгэж байна.

Хоёр. Эс үйлдэхүйгээр илрэх ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт

Ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх механизмийг онолын хувьд субъектэд чиглэсэн¹³, субъектийн үйлдэлд¹⁴ чиглэсэн гэж ангилж болно.¹⁵ Монгол улсын ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх механизмд **субъектийн үйлдэлд чиглэсэн зохицуулалт** давамгайл байна. Субъектийн үйлдэлд чиглэсэн аргачлалын хувьд үйлдэл болон эс үйлдлээр илрэх

¹³ Албан тушаалтан нь ёс зүй, үнэт зүйлийн өндөр төлөвшилтэй, доголдолгүй бол түүний үйлдэл бүрийг нарийвчлан хориглож, "хуулийн заалт шүтсэн" зохицуулалтыг хийх албагүй гэж үздэг. /Хуулийн хувьд албан тушаалаас огцрох үндэслэлгүй боловч өөрийн санаачлагаар "ёс зүйн хариуцлага хүлээх" замаар ажлаа хүлээлгэн өгсөн газар тариалан, ой мод, загас агнуурын сайд Сэйити Ота болон хэд хэдэн тохиолдлууд/

¹⁴ Албан тушаалтан нь мөн чанартаа "хэн байх вэ" гэдгийг тогтоож, зохицуулж чадаагүй буюу ёс зүйн хувьд төлөвшөөгүй орнууд нь субъектийн үйлдэл бүрийг зохицуулах буюу явцуу аргачлалыг хэрэглэдэг.

¹⁵ Хатанзориг.М "Хууль тогтоох процесс дэх ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх аргачлалыг боловсронгуй болгох нь" судалгааны ажил

¹⁰ 23.1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

¹¹ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

¹² Монгол улсын их хурлын тухай, Хууль тогтоомжийн тухай, Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль



ашиг сонирхлын зөрчлийн эсрэг зохицуулалт байх бөгөөд **үйлдлээр гэдэгт ашиг сонирхлын зөрчил бүхий шийдвэрийг гаргах идэвхтэй үйлдэл хамаардаг бол эс үйлдэхүйд нь мэдсээр байж гаргах ёстой шийдвэрийг гаргаагүй, бий болгох ёстой байсан зохицуулалтыг бий болгоогүй зэрэг идэвхгүй үйлдлийн хэв шинжүүд багтана.**

Бизнесийн орчин, зах зээлийн өрсөлдөөнд шууд болон шууд бусаар нөлөөлөх, шийдвэр гаргах, бодлого тодорхойлох өргөн эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн өндөр албан тушаалтнууд хувьдаа бизнесийн үйл ажиллагаа явуулах, түүнд ямар нэг байдлаар оролцох бололцоог үгүйсгэх аргагүй тул тэдгээрт холбогдох харилцааны сонирхлын зөрчлийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тулгардаг. Монголчууд хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр багагүй ажил хийсэн нь сонирхлын зөрчилтэй тэмцэх явдалд томоохон алхам болсон хэдий ч **одоогийн зохицуулалтаар зөвхөн үйлдлээр илрэх сонирхлын зөрчлийн эсрэг арга хэмжээнүүдийг авах боломжтой, сонирхлын зөрчлөөс үүдэлтэй эс үйлдэхгүйг орхигдуулсан юм.**

УИХ-ын 2009 оны 22 дугаар тогтоолоор “Нэн тэргүүнд боловсруулж батлуулах шаардлагатай хуулийн төслийн жагсаалт”-ыг баталсан. Түүний 2 төсөл нь одоог хүртэл батлагдаагүй бөгөөд 2016 онд батлагдсан “Тэргүүн ээлжинд боловсруулж, баталбал зохих

хуулийн жагсаалт”-д багтаагүй байна. Энэ нь тус харилцаа зохицуулалтгүй үлдэх эрсдлийг дагуулж байж болзошгүй юм. Зөвхөн хууль шинээр батлах гэхээс гадна хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ч авч үзэх шаардлагатай. Тодорхой эх сурвалжуудаас иргэний эрх зүйн чиглэлээр бичигдсэн 100 орчим эрдэм шинжилгээний илтгэлийг түүврийн аргаар сонгон авч судлахад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргасан 30 гаруй хувь, иргэний хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргасан нь 10 гаруй хувь байна. Харин энэхүү 10 гаруй хувийн саналын хэрэгжилт ердөө 0,01%-ытай байна.¹⁶

Үйлдлээр илрэх сонирхлын зөрчлийн зохицуулалт нь хориглолтын хэлбэртэй байдаг бол эс үйлдлээр илрэхэд үүрэгжүүлэх зохицуулалт шаардлагатай. Үндсэн хуулийн 23.1¹⁷, Улсын их хурлын тухай хуулийн 6.1¹⁸ -т заасан заалтууд нь зарчмын шинжтэй үүрэгжүүлэх хэм хэмжээг тогтоож байгаа боловч хэтэрхий ерөнхий байна. Хууль тогтоох байгууллагын эрх зүйн байдлыг нарийвчлан тогтоосон үндсэн зохицуулалт бүхий хууль буюу Монгол Улсын их хурлын тухай хуулийн 7.1 хэсэгт улсын их хурлын

¹⁶ Хатанзориг “Иргэний эрх зүйн шинжлэх ухаан ба иргэний хуулийн нийцэмжийн асуудал” УБ., 2013 он 5 тал.

¹⁷ 23.1. Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

¹⁸ 6.1. Улсын Их Хурлын гишүүн /цаашид “гишүүн” гэх/ бол төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.



гишүүний бүрэн эрхийн талаар заасан бөгөөд нийт 27 заалтаас ердөө 10 нь үүрэгжүүлсэн шинжтэй түүнээс 4 л нь сонирхлын зөрчилтэй холбоотой байж болохоор байгаа нь **огт хангалтгүй** зохицуулалттай гэдгийг илэрхийлж байна.

Үүнээс үзэхэд одоогийн зохицуулалт нь зөвхөн зарчмын шинжтэй буюу маш ерөнхий үүрэг тогтоосон, түүнчлэн хуулийн төслийн санааг хүлээн авах, татгалзах үндэслэлийг тодорхой заагаагүй учраас ашиг сонирхлын зөрчлийн үндсэн дээр батлахгүй ч байх боломжтой байна. Түүнчлэн, батлах шаардлагатай хуулийн жагсаалтыг 2 удаа гаргасан хэдий ч, хуулийн төсөл уламжлуулахаар санаачилсан, түүнээс татгалзсан талаар мэдээллүүд далд хэлбэртэй байна.

Гурав. Харьцуулсан судалгаа

Харьцуулсан судалгааны зорилго: Хууль тогтоох процесс дахь ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ямар арга хэмжээг Монгол улсын эрх зүйн зохицуулалттай төсөөтэй, авлигын индекс багатай орон авч хэрэгжүүлж байгааг судлахад оршино.

Герман¹⁹

Хэдийгээр Герман улсын хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч нь Бундестаг боловч шүүхийн байгууллагаас бусад Үндсэн хуулин дах бараг бүх байгууллагууд хууль тогтоох процессд оролцдог. Засгийн газар, Бундесрат²⁰ болон Бундестаг

нь хувийн ашиг сонирхол бүхий бус гагцхүү нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хуулийн төслийг л өргөн барих ёстой (Art 76 I BL) хэмээн Үндсэн хуулиндаа заасан байна. Дараагийн шатанд Бундесрат оролцох (Art 78 BL) бөгөөд энэ үед Бундесрат нь хуулийн төслийг батлах эсвэл буцаах эрхтэй.²¹

Бундестаг болон Бундесратын шийдвэр гарсны дараа хуулийн төсөл нь хууль болно. Гэсэн хэдий ч хууль тогтоох процесс нь дуусгавар болдоггүй. Хуулийн төслийг холбооны засгийн газар луу явуулж Канцлер эсхүл Засгийн газрын гишүүнээр хянуулаад Холбооны Ерөнхийлөгч рүү хүргүүлж гарын үсэг зуруулж, соёрхон батлуулах ёстой. (Art 82 I BL)²²

Герман улсад хууль тогтоох процесс дахь эс үйлдлээр илрэх ашиг сонирхлын зөрчлийн талаар шууд зохицуулсан зохицуулалт алга. Харин зарчмын шинжтэй үүрэгжүүлсэн заалтууд байна. Герман улсын хууль тогтоох процесс нь олон шат дамжлагатай буюу олон субъект харилцан хяналт тавьж байгаа нь батлах ёстой хуулийг батлахгүй байхаас сэргийлж байна.

Далхийн улс орнууд эс үйлдлээр илрэх ашиг сонирхлын зөрчлийг хуулиар шууд зохицуулаагүй.²³ Түүнчлэн онолын түвшинд ч тусгайлан авч үзээгүй байна. Энэ нь ихэвчилэн тогтолцоо, хууль тогтоох процесс,

²¹ Werner Heun "Constitutional systems of the world (The Constitution of Germany)", Oxford- Portland Oregon, 2011 p 107

²² Werner Heun "Constitutional systems of the world (The Constitution of Germany)", Oxford- Portland Oregon, 2011 p 109

²³ АНУ, Япон, Шинэ Зеланд...

¹⁹ 2016 оны байдлаар Дэлхийд 10-т жаргасж байна.

²⁰ Герман улсын Холбооны зөвлөл буюу Холбооны муж улсуудын төлөөллийн танхим



үүрэг болгосон хэм хэмжээнд тулгуурлан зохицуулагддаг.

Дүгнэлт

Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлдэг хууль нь цөөнхийн сонирхолд зориулагдан батлагдвал улс орон доройтож эхэлдэг. Хууль тогтоогчид ард түмний ашиг сонирхлыг төлөөлөх нь ардчилалын гол үнэт зүйл юм.

Аливаа ард түмэн, үндэстэнг зохицуулж буй хууль нь тухайн үндэстний менталитет сэтгэлгээнд тулгуурласан байх ёстой. Тухайлбал, ашиг сонирхлын зөрчлийг байх ёстой зүйл гэж сэтгэлгээндээ хүлээн зөвшөөрдөг ард түмэнд түүнийг хориглосон хэм хэмжээ хэзээ ч үйлчлэхгүй. Түүхэн уламжлалаас авч үзэхэд Монгол улс нь авлига ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж төрийн албан хаагчийг ёс зүйтэй хүнээр төсөөлж тэрхүү хүндээ итгэл хүлээлгэдэг байсан байна. Түүнчлэн хүн бүрийг бага ахуй наснаас нь ардын аман зохиол сургааль номлолоор төлөвшүүлж, сурган хүмүүжүүлдэг байсан байна. Түүнчлэн, түүхэн үе болгоны бичмэл эх сурвалжуудад ашиг сонирхлын зөрчилтэй гэж хэлж болохоор үйлдэл хийсэн тохиолдолд авах арга хэмжээг заасан бөгөөд шууд хориглон зохицуулдаггүй байсан байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжуудын хувьд субъектийн үйлдэлд чиглэсэн хэм хэмжээтэй холбоотой нь давамгайлж байгаа бөгөөд энэ нь Монгол улсад субъектэд чиглэсэн зохицуулалт

хийхэд эрх зүйн ухамсар, соёл хараахан төлөвшөөгүй байгаатай холбоотой билээ. Түүнчлэн хууль тогтоогчдийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалт нь үйлдлээр илрэх ашиг сонирхлын зөрчлийг хориглосон байгаа бөгөөд эс үйлдэхүйгээр илрэх ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж үүрэгжүүлсэн заалт байхгүй байна. Үүнээс үзэхэд одоогийн зохицуулалт нь зөвхөн зарчмын шинжтэй буюу маш ерөнхий үүрэг тогтоосон, түүнчлэн хуулийн төслийн санааг хүлээн авах, татгалзах үндэслэлийг тодорхой заагаагүй учраас ашиг сонирхлын зөрчлийн үндсэн дээр тухайн хуулийг батлахгүй ч байх боломжтой байна.

Герман улсын хувьд хууль тогтоох ажиллагаанд нь парламентын 2 танхим, Засгийн газар, ерөнхийлөгч нь хүртэл оролцдог үе шаттай учраас өөрт зориулан хууль батлах, эсвэл батлахгүй байх асуудал байдаггүй гэж хэлж болохоор байна.

Дээрхээс дүгнэхэд, Монгол улсын ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх механизмд субъектийн эс үйлдэлд чиглэсэн зохицуулалт хийх цаг нь болсон гэдгийг харуулж байна. Үүнтэй холбоотойгоор холбогдох Улсын их хурлын тухай, Нийтийн аблбанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай хууль зэрэг хууль тогтоогчийн үйл ажиллагаатай холбоотой хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. Тэдгээр нэмэлт өөрчлөлт нь иргэд, хуулийн



этгээдүүдээс ирсэн хуулийн төсөл уламжлуулах асуудалд үүрэгжүүлсэн хэм хэмжээнүүдийг нарийвчлан тогтоосон. Түүнчлэн, хуулийн

төслийн санааг хүлээж авахгүй байх нөхцлүүдийг тусгаж бусад тохиолдолд хүлээж авах, авахгүй бол тооцох хариуцлага зэргийг тусгах ёстой.